Үндэсний Статистикийн Хороо

Дэлхийн банк

# Монгол Улс дахь ядуурлын дүр төрх

## (Өрхийн Нийгэм, Эдийн Засгийн Судалгааны 2007-2008 оны үр дүн)

Улаанбаатар
2009

Монгол эхийг хянасан:
Гэлэгжамцын Гэрэлт-Од, Үндэсний Статистикийн Хорооны тэргүүн дэд дарга (Эдийн засаг, удирдахуйн ухааны доктор)

Тайлбар: Энэ тайлан нь англи, монгол хэлээр хэвлэгдсэн бөгөөд тайланд гарч байгаа үнэлэлт, дүгнэлтүүд нь зөвхөн тайлан бичсэн хүмүүсийн санал болно.

Санал, хүсэлт байвал доорх хаягаар холбоо барина уу.

Үндэсний Статистикийн Хороо
Засгийн Газрын III байр
Бага тойруу 44, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар
Монгол Улс
Э-майл: nso@magicnet.mn
Факс: 976-1-324518

Үндэсний Статистикийн Хорооноос эрхлэн гаргав.
Улаанбаатар хот, Монгол Улс 2009 он

**АГУУЛГА**

Гарчиг
Хүснэгтийн жагсаалт
Зургийн жагсаалт
Өмнөх үг
Талархал
Товчилсон үгсийн жагсаалт

Оршил

1. Ядуурал ба тэгш бус байдал
1.1. Ядуурлын хэмжүүр
1.2. Ядуурлын шугамын түвшний мэдрэмж
1.3. Ядуурлын газарзүйн тархалт
1.4. Ядуурлын чиг хандлага
1.5. Цаг хугацааны харьцуулалт ядуурлын шугамын түвшнээс хамаарах нь
1.6. Тэгш бус байдал
1.7. Ядуурлын өөрчлөлтийг өсөлтийн болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваах нь

2. Аж байдлын дүр төрх
2.1 Хэрэглээний хэв шинж
2.2 Ядуурал улирлын хэлбэлзлээс хамаарах нь
2.3 Өрхийн ам бүлийн бүтэц
2.4 Өрхийн тэргүүлэгчийн шинж байдал
2.4.1 Нас
2.4.2 Хүйс
2.4.3 Боловсрол
2.4.4 Ажил эрхлэлт
2.4.5 Шилжих хөдөлгөөний байдал
2.5 Хөрөнгө
2.5.1 Мал
2.5.2 Газар
2.5.3 Санхүүгийн хөрөнгө
2.6 Сууц
2.6.1 Сууцны төрөл
2.6.2 Дэд бүтцийн үйлчилгээ
2.7. Нийгмийн хамгаалал
2.7.1 Мөнгөн шилжүүлэг, тусламжийн хэмжээ, түүний ач холбогдол
2.7.2 Өрхийн хүлээн авч байгаа мөнгөн шилжүүлэг, бэлэг, тусламж
2.7.3 Өндөр насны тэтгэвэр

Ашигласан материал

Хавсралт А. Өрхийн нийгэм эдийн засгийн 2007-2008 оны судалгаа
А.1 ӨНЭЗС-ны танилцуулга
А.2 Түүвэрлэлтийн зохиомж
А.3 Мэдээллийн чанар
Хавсралт Б. Ядуурлын дүн, шинжилгээний арга зүй
Б.1. Аж байдлын үзүүлэлтүүдийн сонголт
Б.2. Хэрэглээний бүрэлдэхүүн хэсгийг тогтоох нь
Б.3 Үнийн засварлалт
Б.4 Өрхийн бүтцийн засварлалт
Б.5 Ядуурлын шугам
Б.6 Ядуурлын хэмжүүрүүд
Хавсралт В. Доод, дээд ядуурлын тооцоонууд
Хавсралт Г. Статистикийн нэмэлт хүснэгтүүд
Г.1 Хэрэглээ ба тэгш бус байдал
Г.2 Ядуурал
Г.3 Боловсрол
Г.4 Эрүүл мэнд
Г.5 Хөдөлмөрийн зах зээл
Хавсралт Д. Ядуурлын тооцоонуудын стандарт алдаа ба итгэмжлэлт интервалууд

## Хүснэгтийн жагсаалт

1.1 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улсын дунджаар
1.2 Ядуурлын шугамын ялгавартай түвшингүүд дэх ядуурлын үндсэн хэмжүүрүүд
1.3 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, бүсээр
1.4 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, суурьшлаар
1.5 Ядуурлын тооцоо, 2002-2003; 2007-2008 он
1.6 Тэгш бус байдал ба дундаж хэрэглээ, 2002-2003; 2007-2008 он
1.7 Ядуурлын өөрчлөлтийг өсөлтийн болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваах нь, 2002-2003; 2007-2008 он
2.1 Нэг хүнд сард ногдох хэрэглээ, үндсэн нэр төрлөөр, төгрөгөөр
2.2 Нэг хүнд сард ногдох хэрэглээ, ядуурлын байдлаар
2.3 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улирлаар
2.4 Ядуурал ба өрхийн ам бүлийн тоо
2.5 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн насаар
2.6 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр
2.7 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн эзэмшсэн боловсролын дээд түвшин
2.8 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн ажиллах хүчний оролцооны байдлаар
2.9 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн салбараар
2.10 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн шилжин суурьшсан байдлаар
2.11 Мал аж ахуй эрхлэлт
2.12 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, мал аж ахуй эрхлэлтийн байдлаар

2.13 Ядуурал ба газар өмчлөл
2.14 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, хадгаламж эзэмшсэн байдлаар
2.15 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, сууцны төрлөөр
2.16 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, дэд бүтцийн үйлчилгээний төрлөөр
2.17 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, дэд бүтцийн үйлчилгээний төрлөөр, хот хөдөөгөөр
2.18 Өрхийн хүлээн авсан шилжүүлэг, бэлэг, тусламж
2.19 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улсын болон хувийн шилжүүлэг, бэлэг тусламжаар
2.20 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өндөр насны тэтгэвэр
А.1. ӨНЭЗС 2007-2008 оны түүвэр, ТАШН-ээр, ярилцлага авсан сараар
Б.1 ТАШН-ийн Паашийн индекс, ТАШН-ээр, ярилцлага авсан сараар
Б.2 Нэг хүнд хоногт ногдох хүнсний сагс, хүнсний гол бүлгүүдээр
Б.3 Нэг хүнд сард ногдох ядуурлын шугамууд
Б.4 Нэг хүнд хоногт ногдох хүнсний сагс
В.1 Нэг хүнд сард ногдох ядуурлын шугамууд, 2002-03, 2007-2008 он
В.2 Доод ядуурлын тооцоонууд, 2002-03, 2007-2008 он
В.3 Дээд ядуурлын тооцоонууд, 2002-03, 2007-2008 он
Г1 Нэг хүнд ногдох сарын хэрэглээ, ядуурлын байдлаар, суурьшлаар
Г. 2 Нэг хүнд ногдох сарын хэрэглээ, ядуурлын байдлаар, бүсээр
Г.3 Нэг хүнд ногдох сарын хэрэглээ, өрхийн тооны тэнцүү 10 бүлгээр
Г.4 Нийт хэрэглээнд эзлэх хувь, өрхийн тооны тэнцүү 10 бүлгээр
Г.5 Ядуурлын дүр төрх, өрхийн тэргүүлэгчийн шинж байдлаар, хот хөдөөгөөр
Г.6 Ядуурлын дүр төрх, өрхийн тэргүүлэгчийн шинж байдлаар, суурьшлаар
Г.7 Ядуурлын дүр төрх, өрхийн тэргүүлэгчийн шинж байдлаар, бүсээр
Г.8 Ядуурлын дүр төрх сууцны шинж байдлаар, хот хөдөөгөөр
Г.9 Ядуурлын дүр төрх, сууцны шинж байдлаар, суурьшлаар
Г.10 Ядуурлын дүр төрх сууцны шинж байдлаар, бүсээр
Г.11 Насанд хүрэгсдийн боловсролын түвшин
Г.12 Насанд хүрэгсдийн боловсролын түвшин, ядуурлын байдлаар
Г.13 Насанд хүрсэн хүн ам, эзэмшсэн боловсролын дээд түвшингээр
Г.14 Насанд хүрсэн хүн ам, эзэмшсэн боловсролын дээд түвшингээр, ядуурлын байдлаар
Г.15 Бага ба бүрэн бус дунд сургуульд хамрагдалтын түвшин
Г.16 Суралцагчдын сурч буй боловсролын түвшин
Г.17 Суралцагчдын сурч буй болосролын түвшин, ядуурлын байдлаар
Г.18 Суралцагчдын шинж байдал, сурч буй боловсролын түвшингээр
Г.19 Суралцагчдын шинж байдал, сурч буй боловсролын түвшингээр, ядуулын байдлаар
Г.20 Улсын сургуульд суралцагчдын хувийн жин, сурч буй боловсролын түвшингээр
Г.21 Улсын сургууль суралцагчдын хувийн жин, сурч буй боловсролын түвшингээр, ядуурлын байдлаар
Г.22 Сургууль хүртэлх зай, сурч буй боловсролын түвшингээр
Г.23 Сургууль хүртэлх зай, сурч буй боловсролын түвшингээр, ядуурлын байдлаар
Г.24 Сургуульд очих хугацаа, сурч буй боловсролын түвшингээр

Г.25 Сургуульд очих хугацаа, сурч буй боловсролын түвшингээр, ядуурлын байдлаар
Г.26 Улсын сургуулийн бага ангийн нэг суралцагчид ногдох зардал
Г.27 Улсын сургуулийн бага ангийн нэг суралцагчид ногдох зардал, ядуурлын байдлаар
Г.28 Бүрэн бус дунд боловсролын улсын сургуулийн нэг суралцагчид ногдох, зардал
Г.29 Бүрэн бус дунд боловсролын улсын сургуулийн нэг суралцагчид ногдох, зардал, ядуурлын байдлаар
Г.30 Улсын сургуулийн ахлах ангийн нэг суралцагчид ногдох зардал
Г.31 Улсын сургуулийн ахлах ангийн нэг суралцагчид ногдох зардал, ядуурлын байдлаар
Г.32 Өвдөж гэмтсэн хүн ам
Г.33 Өвдөж гэмтсэн хүн ам, хот хөдөөгөөр, ядуурлын байдлаар
Г.34 Өвдөж гэмтсэн хүн ам, суурьшлаар, ядуурлын байдлаар
Г.35 Өвдөж гэмтсэн хүн ам, бүсээр, ядуурлын байдлаар
Г.36 Өвдөж гэмтсэн хүн ам, хүйсээр, ядуурлын байдлаар
Г.37 Өвчлөл ба хөгжлийн бэрхшээл
Г.38 Өвчлөл ба хөгжлийн бэрхшээл хот хөдөөгөөр, ядуурлын бйадлаар
Г.39 Өвчлөл ба хөгжлийн бэрхшээл, суурьшлаар, ядуурлын байдлаар
Г.40 Өвчлөл ба хөгжлийн бэрхшээл, бүсээр, ядуурлын байдлаар
Г.41 Өвчлөл ба хөгжлийн бэрхшээл, хүйсээр, ядуурлын байдлаар
Г.42 Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзүүлэлтүүд
Г.43 Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзүүлэлтүүд, хот хөдөөгөөр, ядуурлын байдлаар
Г.44 Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзүүлэлтүүд, суурьшлаар, ядуурлын байдлаар
Г.45 Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзүүлэлтүүд, бүсээр, ядуурлын байдлаар
Г.46 Нэг хүнд сард ногдох эрүүл мэндийн зардал
Г.47 Нэг хүнд сард ногдох эрүүл мэндийн зардал, ядуурлын байдлаар
Г.49 Хүн амын тоо, ажиллах хүчний байдлаар
Г.50 Ажиллах хүчний оролцооны түвшин ба ажилгүйдлийн түвшин, ядуурлын байдлаар
Г.51 Ажиллах хүчний оролцооны түвшин ба ажилгүйдлийн түвшин, хүйсээр
Г.52 Үйлдвэрлэл, салбар ажил мэргэжил, ядуурлын байдлаар
Г.53 Үйлдвэрлэл, салбар ажил мэргэжил, хүйсээр
Д.1 Ядуурлын байдал, хот хөдөөгөөр
Д.2 Ядуурлын байдал, суурьшлаар
Д.3 Ядуурлын байдал, бүсээр
Д.4 Ядуурлын байдал, улирлаар
Д.5 Ядуурлын байдал, өрхийн тэргүүлэгчийн насаар
Д.6 Ядуурлын байдал, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр
Д.7 Ядуурлын байдал, өрхийн тэргүүлэгчийн эзэмшсэн боловсролын дээд түвшнээр
Д.8 Ядуурлын байдал, өрхийн тэргүүлэгчийн шилжин суурьшсан байдлаар
Д.9 Ядуурал ба мал аж ахуй
Д.10 Ядуурал ба хадгаламж эзэмшилт
Д.11 Ядуурлын байдал, сууцны төрлөөр

Д.12 Ядуурал ба сайжруулсан усан хангамж
Д.13 Ядуурал ба сайжруулсан ариун цэврийн байгууламж
Д.14 Ядуурал ба цахилгаан хангамж
Д.15 Ядуурал ба сайжруулсан усан хангамж, сайжруулсан ариун цэврийн байгууламж

## Зургийн жагсаалт

1.1 Нэг хүнд ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалт
1.2 Нэг хүнд ногдох хэрэглээний нягтралын функц
1.3 Нэгдүгээр эрэмбийн стохастик хамаарал, Нэг хүнд ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалт
1.4 Нэг хүнд ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалт, 2002-2003; 2007-2008 он
1.5 Нэг хүнд ногдох ДНБ, оноор
2.1 Ядуурал ба хүн ам зүйн ачааллын харьцаа
2.2 Ядуурал ба малын тоо
2.3 Дэд бүтцийн үйлчилгээний хүртээмж, ядуурлын байдлаар
Г.1. Нэгдүгээр эрэмбийн стохастик хамаарал: Нэг хүнд ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалт, хот хөдөөгөөр, 2002-2003; 2007-2008 он
Г.2. Нэгдүгээр эрэмбийн стохастик хамаарал: Нэг хүнд ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалт, суурьшлаар, 2002-2003; 2007-2008 он
Г.3. Нэгдүгээр эрэмбийн стохастик хамаарал: Нэг хүнд ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалт, бүс нутгаар, 2002-2003; 2007-2008 он
Г.4 Сургуульд хамрагдалтын түвшин

## ӨМНӨХ ҮГ

Сүүлийн үед дэлхий даяар ядууралтай холбоотой асуудлууд хурцаар тавигдаж, ядуурлыг бууруулах, ядуурлаас гарах чиглэлээр улс орнууд, олон улсын байгууллагууд хамтран ажилласаар байна. Үүний нэг жишээ нь Мянганы Хөгжлийн Зорилтуудын 1 дүгээр зорилтыг ядуурал, өлсгөлөнт байдлыг усгтахад чиглүүлж буй явдал билээ. Монгол улсын төр, засаг дэлхийн нийтийн энэхүү уриалгад нэгдэн орж, ядуурлын эсрэг, ядуурлыг бууруулахын төлөө тууштай ажиллаж байна. Энэхүү үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд ядуурлын талаарх бодитой тоо, мэдээллийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаар тооцож, мэдээллийг шинэчлэх зайлшгүй шаардлага байнга гарч байдаг. Үүний дагуу ҮСХ-ноос амьжиргааны түвшин, ядуурлын үзүүлэлтээр баяжуулсан өрхийн судалгааг Дэлхийн банкны техник санхүүгийн дэмжлэгтэйгээр “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”(ӨНЭЗС) нэрийн дор орон даяар 2007 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн явуулж эхлээд байна.

Уг судалгаа нь тус Хорооноос урьд өмнө нь зохион байгуулж байсан түүвэр судалгааны (“Монгол улсын хүн амын амьжиргааны түвшний үнэлгээ“ 1995 он, “Амьжиргааны түвшний түүвэр судалгаа” 1998 он, “Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгаа“ 2002-2003 он) үргэлжлэл болж байгаа бөгөөд улсын хэмжээнд 1966 оноос эхлэн тасралтгүй явагдаж байгаа “Өрхийн орлого, зарлагын судалгаа”-тай бүрэн хэмжээгээр нэгтгэгдэж, цаашид жил бүр тогтмол явагдаж байхаар арга зүйн хувьд шинэчлэгдэн өөрчлөгдөөд байгаа болно. Судлагдах сэдвийг шаардлага, ач холбогдол, судлах давтамжийн хувьд ангилж (заавал судлах, нэмж судлах, сонголттой судлах) авч үзэх олон улсын жишиг байдгийг харгалзан ӨНЭЗС-г цаашид 3 жил тутам дэлгэрэнгүй хэлбэрээр, жил тутам хураангүй хэлбэрээр явуулахаар тогтоод байна. Ингэснээрээ ядуурлын үндсэн үзүүлэлтийг жил бүр тодорхойлох, ДНБ, МХЗ, Ядуурлын газрын зураглал зэрэгт шаардлагатай үзүүлэлт, тооцоонуудыг гаргахын зэрэгцээ, зарим сэдвийг төрөөс явуулж буй бодлоготой, зарим сэдвийг өөрчлөлтийн хандлагатай нь уялдуулан тухай бүр судлах боломжтой болсон. Мөн тухайн цаг үеийн шаардлагаар ӨНЭЗС-нд хавсаргах хэлбэрээр сонгож судлах сэдвүүд байж болохыг мөн нээлттэй үлдээсэн болно. Дээр дурьдсан өөрчлөлтүүд нь

Монгол улсын статистикийн төдийгүй олон улсын судалгааны практикт шинэлэг зүйл болон хэрэгжиж байгааг энд дурьдах нь зүйтэй. Түүнчлэн энэ удаагийн судалгаанд удаа дараагийн сургалтуудаар бэлтгэгдэж, мэргэшсэн орон тооны ярилцлага авагч нарыг ажиллуулсан бөгөөд өрхөөс мэдээлэл цуглуулах ажилд байнгын мониторинг тавьж ажилласан нь судалгааны түүврийн бус алдааг багасгахад дорвитой алхам болсон.

Энэхүү тайланд 2007 оны 7 дугаар сарын 1-ээс 2008 оны 6 дугаар сарын 30-ны хооронд бүтэн жилийн хугацаанд хийгдсэн ӨНЭЗС-ны дүнд хийсэн ядуурлын дүн шинжилгээг толилуулж байна. Тайлангийн эхний бүлэгт ядуурлын өнөөгийн түвшин болон сүүлийн таван жилд гарсан өөрчлөлтүүдийг, хоёрдугаар бүлэгт хүн амын хэрэглээний хэв шинжийг үнэлэн, ядуурал нь өрхийн тэргүүлэгчийн шинж байдал, өрхийн эзэмшиж буй хөрөнгө, амьдарч буй сууцны төрөл болон хүн амын хүлээн авч буй нийгмийн хамгааллалтай хэрхэн холбогдож буйг үзүүлэн ядуурлын дүр төрхийг дэлгэрэнгүйгээр толилууллаа. Өмнөх судалгаануудад харьцангүй дутмаг байсан илүү дэлгэрэнгүй, мэргэжлийн шинж чанартай нэмэлт хүснэгтүүдийг ядуурлын шинжилгээ хийх арга зүйн дэлгэрэнгүй тайлбартайгаар Хавсралтаар оруулж өгсөн.

Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлтэй уялдан тодорхойлогдох хүн амын амьжиргааны байдал нь дан ганц ядуурлын үзүүлэлтүүдээр хэмжигдэхээргүй өргөн цар хүрээтэй асуудал гэдэг нь тодорхой билээ. Иймд Монгол улсын хүн амын аж байдлыг нарийвчлан үнэлэхийн тулд ӨНЭЗС-гаар цуглуулсан баялаг мэдээллийг ашиглан цаашдын дүн шинжилгээг гүйцэтгэх шаардлага бидний өмнө тавигдаж байгаа гэдгийг онцлон тэмдэглэе. Тиймээс энэхүү судалгааны тоо мэдээлэл, үр дүнгийн тайлан нь зөвхөн төрийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт төдийгүй ядуурал, нийгэм, эдийн засгийн асуудлыг судлаач, эрдэмтэд болон сонирхсон хэн бүхэнд ядуурлын талаарх хамгийн сүүлийн үеийн бодит шинэ мэдээлэл болно гэдэгт итгэлтэй байна.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА
С.МЭНДСАЙХАН

## ТАЛАРХАЛ

Монгол Улсын хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын байдлыг тодорхойлсон “Монгол Улс дахь ядуурлын дүр төрх” тайланг 2007-2008 онд улсын хэмжээнд хийгдсэн “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-ны үр дүнд үндэслэн Үндэсний Статистикийн Хорооноос гаргаад байна.

Энэ удаагийн түүвэр судалгаа нь үндэсний хэмжээний томоохон судалгаануудын нэг бөгөөд энэ утгаараа судалгааны бүхий л үе шатны ажилд оролцсон үндэсний статистикийн байгууллагын төв, орон нутгийн мэргэжилтэн, албан хаагчдын хамтын хөдөлмөр, судалгаанд оролцож мэдээллээ өгч байсан манай орны 11 мянга гаруй өрхийн иргэдийн хичээл зүтгэлийн үр дүн шингэсэн гэдгийг юуны өмнө онцлон тэмдэглэж байна.

Судалгааг олон улсын аргачлалын дагуу чанарын өндөр түвшинд явуулахад санхүү, техникийн дэмжлэг үзүүлсэн Дэлхийн Банк, “Засаглалыг дэмжих төсөл” болон түүний бүх шатны ажилтнуудад талархлаа илэрхийлье.

Түүнчлэн судалгааг гардан зохион байгуулж амжилттай явуулсан ҮСХ-ны ХАНСГ-ын ажилтнууд, судалгааны үндсэн багийн хамт олон, мэдээллийг өрх, хүн амаас цуглуулах амаргүй ажлыг хийж гүйцэтгэсэн судалгааны ярилцлага авагч, хянагч, шивэгч нарт болон судалгааны түүвэрлэлтийн зохиомж, асуулгын хуудас боловсруулах, тоон мэдээллийн боловсруулалтын ажилд хамтран ажилласан олон улсын зөвлөх хатагтай Б.Годое, ноён Х.Муноз нарт талархлаа илэрхийлж байна. Уг судалгааны мэдээллийн боловсруулалт, дүн шинжилгээг олон улсын арга зүй, технологийн дагуу богино хугацаанд гүйцэтгэж, судалгааны үр дүнгийн тайланг бичихэд судалгааны үндсэн багийн гишүүдтэй хамтран ажилласан олон улсын зөвлөх ноён М.Кумпа, судалгааны загвар, тоон мэдээллийн чанар, дүн шинжилгээ хийх ажилд өөрийн санал зөвлөмжийг өгч ажилласан Дэлхийн банкны ажилтан хатагтай Д.Стиил, хатагтай Ч.Гох болон тус судалгааны үндэсний зөвлөх хатагтай Н.Ерөөгэрэл нарт талархал илэрхийлж байна.

Судалгааны загвар тодорхойлох, асуулга боловсруулах ажилд мэргэжлийн зөвлөгөө өгч ажилласан ҮСХ-ны аргачлалын болон даргын зөвлөлийн гишүүд, судалгааг орон нутагт зохион байгуулах, мэдээлэл цуглуулах ажилд идэвх зүтгэлтэй оролцож, дэмжлэг үзүүлсэн аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын хамт олон мөн аймаг, сум, багийн удирдлагууд, орон нутгийн засаг захиргааны нэгжийн ажилтнууд, хувь хүмүүст мөн талархлаа илэрхийлж, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА

С.МЭНДСАЙХАН

## Товчилсон үгсийн жагсаалт

| | |
|---|---|
| АТТС | Амьжиргааны түвшний түүвэр судалгаа |
| ДНБ | Дотоодын Нийт Бүтээгдэхүүн |
| ӨНЭЗС | Өрхийн нийгэм эдийн засгийн Судалгаа |
| ӨОЗАТТС | Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгаа |
| ӨОЗС | Өрхийн орлого, зарлагын судалгаа |
| ТАШН | Түүвэрлэлтийн анхан шатны нэгж |
| ҮСХ | Үндэсний Статистикийн Хороо |
| ХАНСГ | Хүн ам, нийгмийн статистикийн газар |
| GE | Ерөнхий Энтропи |

# ОРШИЛ

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо ядуурлын мониторинг хийх, Мянганы Хөгжлийн Зорилтуудыг хангах үйл ажиллагааны явцыг үнэлэх зорилгоор 2007 оны 7 сараас Өрхийн Нийгэм Эдийн Засгийн Судалгаа (ӨНЭЗС)-г эхлүүлсэн билээ. ӨНЭЗС нь сүүлийн таван жилд ядуурлын байдал хэрхэн хувьсан өөрчлөгдсөнийг харах, хүн амын өнөөгийн амьжиргааны түвшинг үнэлэх, ядуурлыг бууруулах цаашдын үйл ажиллагаанд тулгарах сорилтуудын талаар бодлого боловсруулагчдад мэдээлэл өгөх онцгой боломж олгож байна. Энэ тайланд ӨНЭЗС-ны 2007-2008 оны дүнг ашиглан хийсэн ядуурлын дүн шинжилгээг толилуулж байна. Өмнөх буюу 2002-2003 оны “Өрхийн орлого, зарлага амьжиргааны түвшний судалгаа“-тай харьцуулалт хийх боломжийг аль болох өндөр байлгахын тулд адилхан арга зүй ашиглалаа. Гэхдээ ийнхүү ядуурлын асуудалд дүн шинжилгээг хандуулж байгаа нь ядуурал зөвхөн нийгэм, эдийн засгийн хүчин зүйлүүдээр илэрхийлэгдэх хүн амын аж байдал, сайн сайхныг хэмжих бүх хэмжээсийг бүрдүүлдэг гэж өрөөсгөл ойлгох үндэслэл болох ёсгүй. Монгол улсын хүн амын аж байдлыг нарийвчлан үнэлэхийн тулд ӨНЭЗС-ны өргөн хүрээтэй сэдвүүдээр цуглуулсан мэдээллийг ашиглан цаашдын дүн шинжилгээг гүйцэтгэх шаардлагатай.

Энэхүү тайлан дараах бүтэцтэй.
Бүлэг 1-д ядуурлын өнөөгийн түвшин болон сүүлийн таван жилд гарсан өөрчлөлтүүдийг, Бүлэг 2-т хүн амын хэрэглээний хэв шинжийг шалган үзэж ядуурал нь өрхийн тэргүүний шинж байдал, өрхийн эзэмшиж буй хөрөнгө, амьдарч буй сууцны төрөл, болон хүн амын авч буй нийгмийн хамгааллалтай хэрхэн холбогдож буйг харуулж ядуурлын дүр төрхийг дэлгэрэнгүйгээр толилууллаа. Тайланд ашигтай боловч илүү мэргэжлийн шинж чанартай зарим хавсралтыг дагалдууллаа. Хавсралт А-д ӨНЭЗС-ны тухай ерөнхий танилцуулга, Хавсралт Б-д ядуурлын дүн шинжилгээний арга зүй, Хавсралт В-д ядуурлын шугамын хувилбаруудын харьцуулалт, Хавсралт Г-д голлон боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөрийн зах зээл зэрэг сэдвүүдээр нэмэлт үр дүн, мэдээлэл, Хавсралт Д-д ядуурлын тооцоотой холбоотой стандарт алдаа, итгэмжлэгдэх интервалуудыг тусгасан болно.

# 1. Ядуурал болон тэгш бус байдал

Энэ бүлгийн судалгаа, шинжилгээ нь дараах 4 зорилгыг агуулж байгаа болно. Нэгдүгээрт, ядуурлын өнөөгийн цар хэмжээг тодорхойлж тэр нь ядуурлын шугамын түвшнээс хэрхэн хамаарч байгааг үнэлнэ. Хоёрдугаарт, сүүлийн таван жилийн хугацаанд ядуурал хэрхэн хувьсч өөрчлөгдсөн, харгалзах харьцуулалтуудын үнэн зөв байдлыг тооцоолно. Гуравдугаарт, тэгш бус байдлын чиг хандлагыг тодорхойлно. Дөрөвдүгээрт, ядуурлын өөрчлөлтийг өсөлтийн болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн талаас нь авч үзнэ.

Хүн амын амьжиргааны түвшин, ядуурлыг тодорхойлохдоо мөнгөн дүнгийн үзүүлэлтээр буюу хүн амын хэрэглээнд үндэслэн тооцох арга зүйг энэ удаагийн дүн шинжилгээнд баримтласан. [1] Ядуурлын шугам нь хүн амыг ядуу эсэхийг тогтоох босго үзүүлэлт бөгөөд нэг хүнд ногдох хэрэглээ нь ядуурлын шугамаас доогуур хүнийг ядуу гэж үздэг. Үндсэн хэрэгцээний зардлын аргаар тооцоход ядуурлын шугам 62.5 мянган төгрөг болж байна.

## 1.1 Ядуурлын хэмжүүрүүд

Монгол Улсад ядуурлын түвшин буюу ядуурлын хамрах хүрээ 35.2 хувь (Хүснэгт 1.1) болсон байгаа бөгөөд 930,0 мянга орчим хүн ядууралд өртсөн байна.[2] Өөрөөр хэлбэл, 100 хүн тутмын 35 нь зайлшгүй шаардлагатай хүнсний болон хүнсний бус хэрэглээний зүйлийг худалдан авах чадваргүй байна. Хэдийгээр ядуурлын түвшинг илэрхийлж байгаа энэ үзүүлэлтийн агуулгыг ойлгоход хялбархан бөгөөд уг үзүүлэлт ядуучуудад үндсэн хэрэглээгээ хангахад хэдий хэмжээний зүйл (мөнгөн дүнгээр) дутагдалтай байгаа, эсвэл орлого, хэрэглээ нь ядуучуудын дунд хэрхэн хуваарилагдсан талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өгдөггүй. Энэ нь бодлогын хувилбаруудыг үнэлэхэд ноцтой сул тал болох магадлалтай. Жишээлбэл, тодорхой нэгэн бодлогыг хэрэгжүүлснээр хүн амын аж байдал дээшлэх боловч ядуурлын хамралтын хүрээ өөрчлөгдөхгүй үлдэж болно.

Ядуурлын хамрах хүрээ хэмээх үзүүлэлтийн энэ сул талыг нөхөж ядуурлын байдлын талаар илүү нарийн ойлголт авахын тулд ядуурлын гүнзгийрэлт ба ядуурлын мэдрэмж хэмээх өөр хоёр хэмжүүрийг ашигладаг.

---

[1] Арга зүйн тайлбарыг Хавсралт Б-ээс харна уу.

[2] Өрхийн судалгаа явагдсан хугацааны дунд үе буюу 2007 оны сүүлийн байдлаар авсан засаг захиргааны мэдээллээр Монгол улсын нийт хүн ам 2,635, 169 байна.

**Хүснэгт 1.1. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улсын дунджаар**

| Хамралтын хүрээ | Ядуурлын гүнзгийрэлт | Ядуурлын мэдрэмж |
|---|---|---|
| 35.2<br>(0.8) | 10.1<br>(0.3) | 4.0<br>(0.2) |

*Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав*
*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-2008*

Ядуурлын гүнзгийрэлт нь хэрэглээ ядуурлын шугамаас хэр доогуур байгааг тодорхойлдгоороо ядуурлын хамралтын хүрээнээс давуу талтай. Нийт хүн амын дунд тооцсон энэ үзүүлэлт 10 хувьтай байгаа тул ядуу бус хүн амыг ядуурлын шугамаас 0 хувийн зөрөөтэй гэж тооцвол дунджаар хүн тус бүр ядуурлын шугамаас 10 хувиар доош хэрэглээтэй болж байна. Харин зөвхөн ядуу хүн амын дунд ядуурлын гүнзгийрэлтийг тооцоход 29 хувь байгаа нь ядуучуудын дундаж хэрэглээ ядуурлын шугамаас 29 хувь буюу сард дунджаар 17.9 мянган төгрөгөөр бага байгааг харуулж байна.

Ядуурлын мэдрэмж 4 хувь байна.[3] Ядуурлын хамралтын хүрээ болон гүнзгийрэлтээс ялгаатай нь энэ үзүүлэлт ядуучуудын хэрэглээний тархалтаас хамаардаг. Жишээлбэл, нэг ядуу өрхийн хэрэглээ багасч харин тэр өрхөөс арай чинээлэг өөр өрхийн хэрэглээ яг тэр хэмжээгээр ихэсвэл ядуурал нэмэгдэж байна гэж үзэж болно. Гэтэл хэрэглээ нь нэмэгдэж байгаа тэр өрх ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хэвээрээ үлдвэл ядуурлын хамрах хүрээ болон ядуурлын гүнзгийрэлт өөрчлөгдөхгүй боловч харин ядуурлын мэдрэмж нь нэмэгдэнэ. Энэ үзүүлэлтийг энгийнээр тайлбарлахад хүндрэлтэй бөгөөд ядуурлын хамралтын хүрээ болон ядуурлын гүнзгийрэлт нь ижил байгаа бүлгүүдийн ядуурлыг харьцуулахад энэ үзүүлэлтийг ашигладаг.

## 1.2 Ядуурлын шугамын түвшний мэдрэмж

Ядуурлын шугамын түвшин өөрчлөгдөхөд ядуурлын хэмжүүрүүд хэр зэрэг мэдрэмжтэй байгааг тодорхойлох нь ядуурлыг бүрэн ойлгоход зайлшгүй чухал билээ. Аргачлалын дагуу ядуурлын шугамыг тодорхойлох тооцооны явцад гарах санамсаргүй бэрхшээлүүдээс аль болохоор зайлсхийхийн зэрэгцээ хэрэглэсэн аргачлал, мэдээллийг ил тод, бодитой харуулахыг зорив. Магадгүй тооцоо хийх явцад дэвшүүлсэн шууд болон шууд бус таамаглалуудтай зарим хүмүүс санал нийлэхгүй байж болох юм. Ядуурлын шугамуудыг бусад байж болон хувилбаруудыг ч энэ удаагийн дүн

[3] Энэ үзүүлэлтээр аливаа хүний хэрэглээ ядуурлын шугамаас доош алслах тусам илүү жин ногддог.

шинжилгээнд хэрэглэгдсэн ядуурлын шугамтай адилаар тайлбарлаж ашиглах бүрэн бололцоотой. [4]

Ядуурлын шугамыг өсгөх юм уу бууруулахад (дээш юм уу доош зөөхөд) ядуурлын хамралтын хүрээ хэр зэрэг өөрчлөгдөхийг тооцоолохын тулд нэг хүнд ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалтын функцийг график дээр дүрсэлж харъя. (Зураг 1.1.) Хэрэглээг хэвтээ тэнхлэг, хэрэглээний тухайн түвшинд харгалзах хүн амын тооны өсөн нэмэгдэх хувь хэмжээг босоо тэнхлэгээр илэрхийлж, өөрөөр хэлбэл хэрэглээний аливаа нэг түвшинд түүнтэй тэнцүү буюу бага хэрэглээтэй хүн амын хувийн жинг энэ муруй харуулдаг. Хэрэглээний ямар нэг түвшинг сонгоод ядуурлын шугам гэж үзэх юм бол уг шугамаар тодорхойлогдох ядуурлын хамралтын хүрээний түвшинг энэ муруй илэрхийлэх учир үүнийг “Ядуурлын хамралтын хүрээний муруй” гэж үзэж болох юм. Эндээс нэг хүний сарын 62494 төгрөгний хэрэглээг ядуурлын шугам гэж авбал нийт хүн амын 35 хувь нь ядуу байна. Нөгөө талаас дээрх түвшний орчинд тархалтын муруй харьцангуй эгц байгаа нь ядуурлын энэ шугамыг бага зэрэг өөрчлөхөд л ядуурлын хамрах хүрээ нэлээн хэмжээгээр өөрчлөгдөх магадлалтайг харуулж байна.

**Зураг 1.1. Нэг хүнд ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалт**

[4] Харьцуулж үзэхийн тулд бусад ядуурлын шугамын тухай Хавсралт Â-ãээс харна уу.




Ядуурлын шугамны ойролцоо байгаа өрхүүдийн төвлөрлийг нягтралын функц хэмээх өөр нэгэн ойлголт ашиглан тайлбарлая.[5]

Зураг 1.2-т нэг хүнд ногдох хэрэглээний хэмжээгээр тооцсон нягтралыг дүрслэн харууллаа. Энд ядуурлын шугамны *ойролцоо* байгаа тархалтын 2 чухал онцлог шинжүүдийг үзүүлж байна. Үүнд: Нэгдүгээрт, энэ цэгийн (ядуурлын шугамын) ойролцоо их хэмжээний төвлөрөл байгааг харуулж байна. Хоёрдугаарт, хүн амын дийлэнхийн хэрэглээний түвшин нь ядуурлын шугамнаас доош байх магадлал их байгаа нь ядуурлын шугамыг нэмэгдүүлэх тохиолдолд ядуурлын хэмжигдэхүүнүүдэд гарч байгаа өөрчлөлтийн хэмжээ нь тухайн шугамыг бууруулахад гарах өөрчлөлтөөс бага байгааг харуулж байна.

[5] Нягтралын функцын ойлголт нь ерөнхийдөө гистограммын ойлголттой ойролцоо. Энгийн гистограммууд сонгож авсан үзүүлэлтүүдийг тэнцүү урттай хэд хэдэн завсарт хуваан завсар бүрт харгалзах давтамжтай нь тэнцүү өндөртэй босоо тэгш өнцөгтүүдийг байгуулна. Нягтралын функцыг “тэгшитгэсэн” гистограмм гэж үзэж болох юм. Энэ нь нягтрал буюу харгалзах давтамжийг завсар бүр дээр биш цэг бүр дээр тооцдог. Тиймээс хэрэглээний хувьд үзвэл хэрэглээний түвшин бүрийн хоорондох зай бол тэр завсарт байгаа хүн амын хувь юм. (муруйгаас доош байгаа нийт зайг хүн амын 1 буюу 100 хувь гэж үзнэ.)

**Зураг 1.2: Нэг хүнд ногдох хэрэглээний нягтралын функц**




Ядуурлын шугамыг өсгөж, бууруулж авсан ядуурлын хамралтын хүрээний тооцоо бүхий Хүснэгт 1.2-оос мөн ийм үр дүн харагдана. Тухайлбал ядуурлын шугамыг 10 хувиар нэмэгдүүлж мөн хэмжээгээр бууруулсан интервалын хооронд хүн амын бараг 13 хувь нь оршиж байхад, ядуурлын шугамыг 20 хувиар өсгөж, бууруулсан интервалын хооронд хүн амын бараг дөрөвний нэг нь ногдож байна. Нөгөө талаас ядуурлын шугамыг бууруулахад ядуурлын хамрах хүрээ нь ядуурлын шугамыг өсгөснийхөөс илүү ихээр өөрчлөгдөж байна.

**Хүснэгт 1.2. Ядуурлын шугамын ялгавартай түвшнүүд дэх ядуурлын үндсэн үзүүлэлтүүд**

## 1.3 Ядуурлын газар зүйн тархалт

Улс орны хэмжээнд ядуурал хэрхэн ялгарч байна вэ? Энэхүү тайланд Монгол улсыг гурван ангиллаар буюу бүс нутгаар, хот ба хөдөөгөөр, суурьшлаар ялган харуулсан болно.

Монгол Улсын Засгийн газар бүс нутгуудын эдийн засгийн хөгжлийг хурдасгах оновчтой бодлогуудыг боловсруулан хэрэгжүүлэх зорилгоор улс орноо эдийн засгийн таван бүс болгон авч үзэж байна. Хүснэгт 1.3-д ядуурлын хэмжүүрүүдийг Баруун, Хангайн, Төвийн, Зүүн болон Улаанбаатар гэсэн таван бүс нутгаар харуулав.[6] Ядуурал нийслэл хотод хамгийн бага буюу хүн амын тавны нэг хувь нь ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай байна. Үүний дараа Төвийн бүс орж байгаа бөгөөд арван хүний гурав нь ядуу байна. Баруун, Хангайн, Зүүн бүс нутгуудад ядуурлын хамралтын хүрээ ойролцоо буюу хүн амынх нь бараг тал хувь нь ядууралд өртөөд байна. Ядуу хүмүүс хаагуур нутагладгийг судалж үзэхэд Хангайн бүсэд хүн амын дөрөвний нэг хүрэхгүй нь оршин суудаг боловч ядуучуудын гуравны нэг амьдардаг нь харагдаж байна. Харин Улаанбаатар хотод нийт хүн амын гуравны нэг харин ядуучуудын дөнгөж тавны нэг нь амьдарч байна. Баруун бүсэд ядуучуудын тавны нэг, Зүүн бүсэд аравны нэг, үлдсэн хэсэг нь Төвийн бүсэд амьдарч байна.

**Хүснэгт 1.3 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, бүс нутгаар**

Хотжилт ядуурлын байдалд нөлөөлөх хүчин зүйл мөн эсэх нь судалгааны дүнгээр нийслэлээс бусад бүс нутгуудад тодорхой харагдахгүй байна.

Жишээлбэл, Төвийн бүсийн хотжилтын түвшин нь Зүүн бүсийнхтэй ижил, Хангайн бүсийнхтэй ойролцоо боловч ядуурал нь энэ хоёр бүсийг бодвол нэлээн бага байна. Харин хот, хөдөө гэж хуваасан ангиллаар шинжилгээ хийх нь илүү мэдээллийг бий болгож байна. Хүснэгт 1.4-д ядуурлын байдлыг дөрвөн үндсэн суурьшлаар харууллаа. Хотод ядуурал хөдөөгөөс нэлээн бага буюу хамралтын хүрээ нь 27 хувь (хөдөөд 47 хувь) байна. Хотыг суурьшлаар нь авч үзвэл ядуурлын хамралтын хүрээ Улаанбаатар хотод аймгийн төвүүдийнхээс бага байна. Хөдөөг суурьшлаар нь авч үзвэл сумын төвд хөдөө нутгийг бодвол ядуурал бага байна. Нийслэл ба аймгийн төвүүд гэсэн хоёр суурьшилд хуваагддаг хотод нийт хүн амын 58 хувь нь амьдарч

[6] Баруун бүсэд Баян -Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгууд, Хангайн бүсэд Архангай, Баянхонгор, Булган,Өвөрхангай, Хөвсгөл, Орхон аймгууд, Төвийн бүсэд Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Ç¿үн бүсэд Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгууд багтдаг.

байгаа боловч ядуучуудын дөнгөж 44 хувь нь байна. Харин сумын төвүүдэд ядуучуудын тавны нэг, хөдөө нутагт гуравны нэгээс илүү нь амьдарч байна.

### Хүснэгт 1.4 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, суурьшлаар

| | Улсын дундаж | Хот | | | Хөдөө | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт | Улаанбаата | Аймгийн төв | Нийт | Сумын төв | Хөдөө нутаг |
| Ядуурлын хамралтын хүрээ | 35.2 | 26.9 | 21.9 | 34.9 | 46.6 | 42.0 | 49.7 |
| | (0.8) | (1.1) | (1.4) | (1.8) | (1.2) | (1.8) | (1.6) |
| Ядуурлын гүнзгийрэлт | 10.1 | 7.7 | 6.3 | 9.9 | 13.4 | 12.7 | 13.9 |
| | (0.3) | (0.4) | (0.5) | (0.7) | (0.5) | (0.7) | (0.6) |
| Ядуурлын мэдрэмж | 4.0 | 3.1 | 2.6 | 3.9 | 5.2 | 5.2 | 5.3 |
| | (0.2) | (0.2) | (0.2) | (0.3) | (0.2) | (0.3) | (0.3) |
| *Нэмэлт үзүүлэлтүүд:* | | | | | | | |
| Хүн амын хувь (%) | 100.0 | 57.6 | 35.6 | 22.0 | 42.4 | 17.4 | 25.1 |
| Хүн ам ('000) | 2,635.2 | 1,516.9 | 938.2 | 578.7 | 1,118.2 | 457.4 | 660.9 |
| Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин(%) | 100.0 | 43.9 | 22.2 | 21.8 | 56.1 | 20.7 | 35.4 |
| Ядуурлын шугамаас доогуур хүн амын тоо ('000) | 928.5 | 407.7 | 205.7 | 202.0 | 520.8 | 192.1 | 328.7 |
| Өрхийн ам бүлийн тоо | 3.9 | 3.9 | 3.9 | 3.9 | 3.9 | 3.9 | 3.8 |
| Хүн ам зүйн ачаалал (%) | 38.9 | 37.5 | 36.4 | 39.2 | 40.8 | 39.5 | 41.7 |
| Хүүхэд (өрхөд эзлэх хувь) | 26.4 | 25.0 | 24.0 | 26.8 | 28.2 | 27.8 | 28.5 |
| Өрхийн тэргүүлэгчийн нас | 44.9 | 45.7 | 45.9 | 45.4 | 43.8 | 44.7 | 43.1 |
| Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх | 78.0 | 73.7 | 71.7 | 77.0 | 83.8 | 79.5 | 86.8 |

*Санамж: 2007-2008 оны нийт хүн амын тоо нь засаг захиргааны мэдээлэл дээр үндэслэсэн бөгөөд 2007 оны эцсийн байдлаарх тооцоо юм.*

*Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав*

*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-08.*

Эдгээр үр дүнгүүд ядуурлын шугамын түвшингээс хэр зэрэг хамаарч байна вэ? Таамаглал дэвшүүлэх шинжилгээний аргыг ашиглан харьцуулах боломжтой ядуурлын шугамуудыг гаргаж авдаг. Энэ аргад хэрэглээний тархалтыг график ашиглан бүхэлд нь авч үздэг.[7] Бүс нутгаар авч үзвэл Баруун бүс, Хангайн бүс, Зүүн бүсд ядуурал хамгийн их байна. Гэвч энэ гурван бүсийн гурван муруй нь тархалтын ихэнх хэсэгт хоорондоо давхцаж байгаа учраас тэдгээрийг харьцуулж үзэх боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, ядуурлын шугамыг өөр өөрөөр сонгосон ч эдгээрийн ядуурлын хамрах хүрээнүүд хоорондоо тун ойролцоо гарч байна. Ядуурлын хамралтын хүрээ Улаанбаатар хотод хамгийн бага, хоёрдугаарт Төвийн бүс орж байна. (Зураг 1.2) Хот, Хөдөө гэсэн байршлаар нь ялгаж харьцуулахад дараах гурван дүгнэлт гарна. Нэгдүгээрт, хотынхон хөдөөнийхнөөс амьжиргаа сайтай

[7] Нэг графикт 2 ба түүнээс дээш суурьшилаар нэг хүнд ногдох хэрэглээг дүрсэлсэнээр хамгийн давуу талтай байгаа суурьшилыг тодорхойлж болох юм. Хэрэв нэг хүнд ногдох ямар ч хэрэглээний хувьд бага буюу тэнцүү хэрэглээний түвшинтэй хүн амын хувь үргэлж B тархалтаас доогуур байгаа тохиолдолд A тархалтыг илүү давуу талтай гэж үзнэ. Өөрөөр хэлбэл, A муруй B муруйн дээр үргэлж байдаг бол B тархалт илүү эд баялагтай байх тул ядуурал багатай байна. Гэхдээ муруйнууд огтолцсон тохиолдолд энэ шинж чанар тохирохгүй бөгөөд аль тархалт нь илүү эд баялагтайг нь тодорхойлох боломжгүй.

байна. Хоёрдугаарт, Улаанбаатар хотод ядуурал аймгийн төвүүдийнхээс бага байна. Гуравдугаарт, хэрэв ядуурлын шугамыг маш доогуур тооцохгүй л бол сумын төвийнхөний амьжиргаа хөдөө нутгийнханаас илүү байсаар байна. Нэгтгэж дүгнэвэл нийслэл хотод амьжиргаа хамгийн сайн, хоёрдугаарт аймгийн төв, гуравдугаарт сумын төв, хамгийн сүүлд хөдөө нутаг орж байна.

Зураг 1.3. Нэг хүнд ногдох хэрэглээний нягтралын функц




*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-2008.*

## 1.4 Ядуурлын чиг хандлага

Сүүлийн нэг жилийн хугацаанд ядуурал хэрхэн өөрчлөгдсөнийг үнэлэх зорилгоор 2007-2008 оны ядуурлын дүн шинжилгээнд 2002-2003 оныхтой адил арга зүйг ашиглалаа. Эдгээр судалгааны түүврийн зохиомж ба хэрэглээний модулиудыг харьцуулах боломжтой учир цаг хугацааны явцад гарсан өөрчлөлтийг бодитойгоор үнэлэх боломжтой юм. [8]

Сүүлийн жилүүдэд ядуурлын төлөв байдал хэрхэн хувьсан өөрчлөгдсөнийг Хүснэгт 1.5-д харуулав. Сүүлийн таван жилийн хугацаанд ядуурал бага зэрэг буурсныг энэ гурван тооцоолол харуулж байна. Жишээ нь ядуурлын хамрах хүрээ 36.1 хувь байснаа 35.2 хувьд хүрч буурчээ. Гэхдээ суурьшилтай холбоотой өөрчлөлтүүдийг зөвхөн дээрх тоон баримтаар дүгнэх боломжгүй билээ. Хотод ядуурлын хамралтын хүрээ 30.3 хувиас 26.9 хувь болж илт буурсан байхад харин хөдөөд 43.4 хувиас 46.6 хувь болж өссөн урвуу дүр зураг харагдаж байна. Үүнээс гадна суурьшлын энэ хоёр томоохон ангилал тус бүрийн дотор нь харилцан адилгүй өөрчлөлтүүд явагджээ. Улаанбаатар хотод ядуурал 5 гаруй хувиар буурсан байхад аймгийн төвүүдэд бага зэрэг өссөн байна. Нөгөө талаас сумын төвүүдэд ядуурал бага зэрэг буурсан байхад харин хөдөө нутагт ядуурлын хамрах хүрээ 7 хувиар өсчээ.

Бүх бүс нутагт ядуурлын хамрах хүрээ эрс өөрчлөгдсөн байна. Ядуурлын хамрах хүрээ Баруун бүсэд 51.1 хувиас 47.1 хувь, Төвийн бүсэд 34.4 хувиас 30.7 хувь болж буурсан бол Хангайн бүсэд 38.7 хувиас 46.6 хувь, Зүүн бүсэд 34.5 хувиас 46.7 хувь болж өссөн урвуу үр дүн гарчээ. Ядуурлын гүнзгийрэл, ядуурлын мэдрэмж хоёр ч ядуурлын хамрах хүрээтэй нэг чиглэлд шилжин өөрчлөгджээ.

Ядуурлын бусад үзүүлэлтүүд энэ хугацаанд хэрхэн өөрчлөгдсөнийг сонирхоё. Хот, хөдөөгийн харьцуулсан үр дүн хэвээр үлдсэн буюу ядуурал хотод хөдөөгөөс бага байна. Ядуурал Улаанбаатар хотод хамгийн бага бөгөөд үүний дараа аймгийн төвүүд орж байна. 2002-2003 онд хөдөөгийн хоёр суурьшилд ядуурал ерөнхийдөө ойролцоо байсан. Харин энэ удаа сумын төвүүд хөдөө нутгаас ядуурал багатай болжээ. Бүсүүдэд ядуурлын байдал өөрчлөгдсөн нь тодорхой харагдаж байна. Урьд нь ядуурал Зүүн болон Төвийн бүсэд хамгийн бага байсан бөгөөд дараа нь Хангайн бүс орж, Баруун бүс хамгийн ядуу байжээ. Одоо ядуурал Төвийн бүсэд хамгийн бага хэвээрээ байхад бусад бүсүүдийн ядуурал ойролцоо түвшинд хүрчээ.

Дээрх өөрчлөлтүүд нь ядуу хүн амын тооны хот, хөдөөгийн тархалтанд ноцтой нөлөөлөөгүй бөгөөд хотод хүн амын ихэнх, харин хөдөөд ядуучуудын ихэнх нь амьдарсан хэвээр байна. Гэхдээ таван жилийн өмнөхтэй харьцуулахад хөдөөд арай илүү олон ядуу хүн амьдрах болсон бөгөөд 53.5 хувиас 56 хувь болж нэмэгдсэн байна.

[8] Хавсралт Б-д хэрэглэсэн арга зүйг дэлгэрэнгүй тайлбарлав.

Харин ядуучуудын тооны тархалт бүсүүдэд нэлээн өөрчлөгдсөн байна. Ядуучуудын дөрөвний нэг Хангайн бүсэд 2002-2003 онд амьдарч байсан бол одоо гуравны нэгд хүрч өсчээ. Үүнтэй урвуугаар Төвийн бүсэд таван жилийн өмнө ядуучуудын 18.6 хувь амьдарч байсан бол одоо 14.7 хувь болж 3.9 пунктээр буурчээ.

## Хүснэгт 1.5 Ядуурлын тооцоо, 2002-2003; 2007-2008 он

| | 2002/03 | | | | | 2007-08 | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Ядуурлын | | | Хүн амын хувийн жин (%) | Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%) | Ядуурлын | | | Хүн амын хувийн жин (%) | Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%) |
| | Хамралтын хүрээ | Гүнзгийрэлт | Мэдрэмж | | | Хамралтын хүрээ | Гүнзгийрэлт | Мэдрэмж | | |
| Улсын дундаж | 36.1 | 11.0 | 4.7 | 100.0 | 100.0 | 35.2 | 10.1 | 4.0 | 100.0 | 100.0 |
| Хот | 30.3 | 9.2 | 4.0 | 55.4 | 46.5 | 26.9 | 7.7 | 3.1 | 57.6 | 43.9 |
| Хөдөө | 43.4 | 13.2 | 5.6 | 44.6 | 53.5 | 46.6 | 13.4 | 5.2 | 42.4 | 56.1 |
| Улаанбаатар | 27.3 | 8.1 | 3.3 | 30.2 | 22.8 | 21.9 | 6.3 | 2.6 | 35.6 | 22.2 |
| Аймгийн төв | 33.9 | 10.5 | 4.7 | 25.2 | 23.7 | 34.9 | 9.9 | 3.9 | 22.0 | 21.8 |
| Сумын төв | 44.5 | 14.4 | 6.4 | 16.2 | 20.0 | 42.0 | 12.7 | 5.2 | 17.4 | 20.7 |
| Хөдөө нутаг | 42.7 | 12.6 | 5.1 | 28.4 | 33.6 | 49.7 | 13.9 | 5.3 | 25.1 | 35.4 |
| Баруун | 51.1 | 14.6 | 5.7 | 17.0 | 24.0 | 47.1 | 12.8 | 4.7 | 16.6 | 22.1 |
| Хангай | 38.7 | 12.3 | 5.2 | 24.1 | 25.8 | 46.6 | 13.6 | 5.3 | 23.1 | 30.5 |
| Төв а) | 34.4 | 10.1 | 4.3 | 19.5 | 18.6 | 30.7 | 8.4 | 3.3 | 16.8 | 14.7 |
| Зүүн | 34.5 | 12.4 | 6.6 | 9.3 | 8.9 | 46.7 | 14.9 | 6.6 | 7.9 | 10.5 |

*а/ Улаанбаатарыг оруулаагүй.*

*Эх сурвалж: ӨОЗС/АТТС 2002-03, ӨНЭЗС 2007-08.*

## 1.5 Цаг хугацааны харьцуулалт ядуурлын шугамын түвшнээс хамаарах нь

Дээрх үр дүнгүүд ядуурлын шугамын түвшингээс хэрхэн хамаарч байгааг таамаглал дэвшүүлэх шинжилгээний аргаар тодруулж болно. Зураг 1.4-өөс харахад 2007-2008 оны тархалт нь 2002-2003 оны тархалтаас огтхон ч дордоогүй буюу өөрөөр хэлбэл 2007-2008 оны ядуурал 2002-2003 оныхоос их биш байна. Тархалтын дээд хагаст 2007-2008 оны муруй нь 2002-2003 оны муруйгаас сайн үзүүлэлттэй байгаа бол харин доод хагаст энэ хоёр муруй ихэнх хэсгээрээ давхцаж байна. Мөн тархалтын бүр хамгийн доод хэсгээс харахад 2007-2008 онд амьжиргаа 2002-2003 оныхоос сайжирсан нь илэрхий харагдаж байна. Хотод ядуурлын шугамын түвшинг хэрхэн сонгохоос үл хамааран ядуурал 2007-2008 онд таван жилийн өмнөхөөс буурсан үр дүн гарч байна.[9] Харин хөдөөд энэ хоёр муруй огтлолцож байгаа учраас арай өөр дүр зураг үүснэ. Энэ хоёр муруй огтлолцоод салж эхэлж байгаа тархалтын тэр цэгт ядуурлын шугам оршиж байна. Ядуурлын доод шугамуудын хувьд ядуурал өөрчлөгдөөгүй хэвээрээ байна. Харин ядуурлын дээд шугамуудын хувьд 2007-2008 онд 2002-2003 оныхоос амьжиргаа муудсан байна.

**Зураг 1.4. Нэг хүнд ногдох хэрэглээний өсөн нэмэгдэх тархалт 2002-2003; 2007-2008 он**




*Эх сурвалж: ӨОЗАТС 2002-2003 ба ӨНЭЗС 2007-2008.*

[9] Хот, хөдөө, суурьшил болон бүс нутгаар гаргасан үр дүнг хавсралт Г-ээс харна уу.

Суурьшлаар нь авч үзэхэд дээрх үр дүнгүүд мөн батлагдаж байна. Амьжиргааны түвшин Улаанбаатар хотод бусад суурьшлаас өндөр буюу ядуурлын шугамыг яаж сонгосноос үл хамааран ядуурал хамгийн багатай байна. Аймгийн төвүүдэд хоёр муруй сүлжилдсэн байгаа учраас тодорхой дүгнэлт хийх ямар ч боломжгүй бөгөөд ядуурлын шугамын сонголтоос хамаарахгүйгээр байдал хэвээр байна. Сумын төвүүдэд хүн амын амьжиргаа таван жилийн өмнөхтэй харьцуулахад дээшилж ядуурал үл ялиг буурсан байна. Хөдөө нутагт ядуурлын шугамыг нэлээн доогуур авахгүй л бол 2007-2008 онд ядуурлын хамрах хүрээ өссөн бөгөөд өөрөөр хэлбэл тархалтын доод хэсгээр хэрэглээ нь 2002-2003 оныхтой ойролцоо харин бусад буюу ихэнх хэсэгт нь 2002-2003 оныхоос буурсан байна. Хөдөөд явагдсан энэ өөрчлөлтөөр амьжиргаа сумын төвд сайжирч харин хөдөө нутагт буурсан тул энэ хоёр суурьшлын ядуурлын эрэмбэ солигджээ.

Гарсан үр дүнгүүд бүс нутгийн хувьд ч мөн баталгаажиж байна. Төвийн бүсэд энэ хугацаанд хэрэглээ нэмэгдсэн учраас ядуурлын шугамын сонголтоос үл хамааран ядуурал буурсан дүнтэй гарч байна. Хангай болон Зүүн бүсэд тархалтын ихэнх хэсэгт амьжиргааны түвшин буурсан нь илэрхий харагдаж байгаа учраас ядуурлын хамрах хүрээ ихэссэн байна. Баруун бүсэд хэрэглээ бага зэрэг өсч, улсын дундажтай ойролцоо болжээ. Иймд хамгийн зохистой ядуурлын шугамуудын хувьд ядуурлын хамрах хүрээ буурсан байх магадлалтай юм. Эдгээр нь бүсүүдийн ядуурлын шинэ эрэмбийг бататгаж байна. Төвийн бүс эхний байраа бататгасан бол харин Баруун бүсэд амьжиргаа сайжирч, Хангайн болон Зүүн бүсэд буурснаар энэ гурван бүс нутгийн хэрэглээний түвшин ойролцоо түвшинд очжээ.

## 1.6 Тэгш бус байдал

Өнгөрсөн хугацаанд тэгш бус байдал даамжирсан байна.[10] Хүснэгт 1.6-д Жини коэффициент, болон Ерөнхий Энтропийн индексүүдийн өнгөрсөн хугацаанд (2002-2003 онд хийгдсэн ӨОЗ-АТТС-наас хойшхи) гарсан өөрчлөлтийг харуулав. Улсын хэмжээнд нэг хүнд ногдох хэрэглээний тэгш бус байдал нэлээн ихэссэнийг гурван үзүүлэлт харуулж байна.

Хүснэгт 1.6 **Тэгш бус байдал ба дундаж хэрэглээ, 2002-2003; 2007-2008 он**

[10] Тэгш бус байдлын Ерөнхий Энтропи ангийн хэмжүүрүүдийг GE($\alpha$) гэж тэмдэглэдэг. $\alpha$ утга ихсэх (багасах) тусам тархалтын дээд (доод) хэсэг дэх хэрэглээний өөрчөлтөөс энэ үзүүлэлт илүү хүчтэй хамаардаг. Жини коэффициент нь тархалтын дунд хэсэг дэх хэрэглээнийөөрчлөлтөөс илүү хамаардаг. Энэ гурван индекс гурвуулаа тэгээс нэг хүртэл утга авах бөгөөд утга нь өсөх тусам тэгш бус байдал их байна.

Жишээ нь, улсын хэмжээнд Жини коэффициент 0.33-аас 0.36 болж өссөн бөгөөд үүний дотор хотод хөдөөг бодвол илүү их өссөн байна. Тэгш бус байдал нь бараг бүх суурьшил, бүсүүдэд өссөн нь харагдаж байна. Бусад хоёр үзүүлэлт ч мөн өссөн байгаа нь дээрх дүгнэлтийг нотолж бататгаж байна. Харин суурьшлын хүрээнд зөвхөн хөдөө нутагт, бүс нутгаас зөвхөн Баруун бүсэд л дээрхээс өөр хандлагатай байна. Хөдөөд гурван индексийн хоёрын дүн тэгш бус байдал хэвээрээ байгаа буюу буурсан гэж илтгэж байгаа бол гуравдахь индекс нь нэлээн өссөн болохыг илэрхийлж байна. Баруун бүсэд аль ч индексээр тооцоход тэгш бус байдал өсөөгүй буюу хоёр индексийн тооцоо буурч харин гуравдахь индексийн дүн өөрчлөгдөөгүй өмнөх түвшиндээ байна. Түүнчлэн шинжилгээнд хамаарах хугацаанд дундаж хэрэглээнд гарсан өөрчлөлтүүдийг судласнаар зарим дүгнэлт хийж болно. (Хүснэгт 1.6-ийн баруун хагас). Нэг хүнд ногдох хэрэглээ 2002-2003 болон 2007-2008 оны хооронд 9 хувиар өссөн байна. Хотод ялангуяа Улаанбаатар хотод хэрэглээ үлэмж өссөн байна. Хөдөөгийн суурьшлын хүрээнд сумын төвийнхний хэрэглээ өссөн боловч хөдөө нутагт буурсан байна. Бүсүүдээр тооцоолж үзвэл, дундаж хэрэглээ Төвийн бүсэд ихээхэн, Баруун бүсэд арай бага нэмэгдсэн бол Хангай болон Зүүн бүсэд мэдэгдэхүйц буурсан байна. Ийнхүү аж байдал сайжирч байгаа нь энэхүү шинжилгээнд хамаарах хугацаанд харгалзах ДНБ-ний жилийн өсөлтийн тооцоогоор нотлогдож байна. Зураг 1.5-д нэг хүнд ногдох ДНБ-ийг эдийн засгийн үндсэн гурван салбараар харуулж байна. Энэ гурван салбарын өсөлтийн хувь ойролцоо байсан учраас нийт ДНБ-д эзлэх хувийн жин нь хэвээр үлдэж, өсөлт нь нийт эдийн засгаар жигд тархалттай байгааг харуулж байна. [11]

Зураг 1.5. Нэг хүнд ногдох ДНБ, онуудаар




[11] Өрхийн судалгаанаас тооцсон өрхийн хэрэглээг үндэсний тооцооны дүнтэй харьцуулж үзвэл сонирхолтой дүгнэлт гарч болох юм.

## 1.7 Ядуурлын өөрчлөлтүүдийг өсөлтийн болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваах нь

Дундаж хэрэглээ өсөх, хэрэглээний тэгш бус байдал ихсэх нь ядууралд хэрхэн нөлөөлдөг вэ? Бусад хүчин зүйлүүд өөрчлөгдөөгүй байхад хэрэглээ өссөнөөр ядуурал буурч, харин тэгш бус байдал өссөнөөр ядуурал нэмэгдэх хандлагатай байдаг. Ядуурлын өөрчлөлтийг өсөлтийн болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваан үзсэнээр дээрхи хандлагыг бүр тодорхой харж болно.[12] Бодит дундаж хэрэглээ өөрчлөгдөж, харин харьцангуй тэгш бус байдал өөрчлөгдөөгүй нөхцөлд үүсэх өөрчлөлт нь ядуурлын өөрчлөлтийн өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг юм. Харин харьцангуй тэгш бус байдал өөрчлөгдөж, бодит дундаж хэрэглээ өөрчлөгдөөгүй үед үүсэх өөрчлөлтийг ядуурлын өөрчлөлтийн тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг гэж үзнэ. Хүснэгт 1.7-д ядуурлын өөрчлөлтийг дээрх бүрэлдэхүүний бүтцээр харууллаа. Улсын хэмжээнд өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг нь ядуурал буурахад нөлөөлсөн боловч энэ нөлөөллийн ихэнх нь тэгш бус байдлын өсөлтөөс хамаарч үгүй болжээ. Жишээ нь, 2002-2003 он болон 2007-2008 оны хооронд ядуурлын хамрах хүрээ улсын хэмжээнд 0.9 пунктээр буурсан байна. Хэрэв энэ хугацаанд харьцангуй тэгш бус байдлууд өөрчлөгдөөгүйсэн бол хэрэглээний өсөлтийн улмаас ядуурал 5.0 пунктээр буурах байлаа. Хэрэв энэ хугацаанд бодит дундаж хэрэглээ өсөөгүйсэн бол тэгш бус байдал даамжирснаас болж ядуурал 4.2 пунктээр нэмэгдэх байжээ. Эдгээр хоёр эсрэг хүчин зүйлийн нөлөөллөөр ядуурлын цэвэр бууралт нь 0.9 пункт болсон байна.

Ядуурлын бусад хоёр индексийн хувьд ч үүнтэй төстэй үр дүн гарч байна.

[12] Datt and Ravallion (1992).

**Õуснэгт 1.7. ßдуурлын үндсэн хэмжүүрүүдийн өөрчлөлтийг өсөлтийн болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсгүүдээр хуваах нь, 2002-2003; 2007-2008 он**

Хотын хувьд нийт улсын хэмжээний үр дүнтэй бараг ижил байгаа боловч тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг нь арай бага нөлөөтэй байна. Хөдөөд ядуурал өсөхөд энэ хоёр хүчин зүйл хоёулаа нөлөөлсөн бөгөөд үүнээс тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг нь давамгайлжээ. Харин хөдөөгийн ядуурлын мэдрэмжинд эдгээр хоёр бүрэлдэхүүн хэсэг эсрэгээр нөлөөлжээ. Суурьшлуудаар тооцож үзэхэд бараг бүх дөрвөн ангилалд болон ядуурлын гурван үзүүлэлтэнд өсөлтийн бүрэлдэхүүн хэсгийн үйлчлэл тэгш бус байдлын үйлчлэлийг давж байна. Ядуурал зөвхөн аймгийн төвд л тэгш бус байдлын өсөлтийн давамгайллаас шалтгаалан өссөн байна. Хэрэглээний өсөлт нь Зүүн бүсээс бусад бүх бүсэд тэгш бус байдлын нөлөөллөөс давж байна. Өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсэг аль аль  нь бүх суурьшил болон Төвийн бүсээс бусад бүх бүсэд эерэг, адил чиглэлд үйлчилж байна. Зөвхөн Төвийн бүсэд л өсөлтийн бүрэлдэхүүн хэсэг нь ядуурлын хамрах хүрээг бууруулж байхад харин тэгш бус байдал нь ядуурлын хамралтын хүрээг ихэсгэж эсрэг чиглэлд үйлчилж байна.

Ерөнхийдөө ядуурлын хамрах хүрээний өөрчлөлт нь өсөлтийн бүрэлдэхүүн хэсгийн нөлөөллөөр үүссэн байна гэдгийг дээрх үр дүнгүүд харуулж байна. Харин тэгш бус байдал нь ерөнхий өөрчлөлтөөрөө өсөлтийн бүрэлдэхүүн хэсгийн урвуу чиглэлд нөлөөлөл үүсгэжээ. Улсын хэмжээнд тэгш бус байдал ингэж мэдэгдэхүйц нэмэгдээгүй бол ядуурлын хамрах хүрээ  нэлээн хэмжээгээр буурах байжээ.

# 2 АЖ БАЙДЛЫН ДҮР ТӨРХ

Аж байдлын дүр төрх нь хүн амын янз бүрийн бүлгүүдэд амьжиргааны түвшин хэр зэрэг өөр өөр байгааг харуулдаг. Энэ бүлэгт ядуурлын шинж чанар, тэдгээр нь өрхийн ялгаатай шинж байдал болон аж байдлын бусад талтай хэрхэн холбогдож байгааг харуулах ядуурлын ерөнхий төрхийг авч үзнэ. Ингэснээр ядуучуудыг ядуу бус хүмүүсээс ялган, ядуу хүн гэж хэн бэ, тэдний хүмүүний капитал, эзэмшж буй эдийн засгийн нөөц баялгийн түвшин, амьдарч байгаа сууцны чанар, хүртэж буй нийгмийн хамгаалал, эрхэлж байгаа ажлын төрөл зэргийг тодорхойлсон. Энэ нь ядуурлыг бууруулах оновчтой арга замыг төлөвлөхөд шаардлагатай мэдээллийг бий болгох боломжийг хангах юм.

## 2.1 Хэрэглээний хэв шинж

Ядуурлын дүр төрхийг боловсруулахын тулд юуны өмнө хүн амын аж байдлын талаархи харьцуулж болохуйц үзүүлэлтүүдийг сонгоно. Бид өрхийн нэг хүнд ногдох хэрэглээг хүн амын аж байдлыг тодорхойлох үзүүлэлт болгон сонгон авав. Үүнд нэг хүнд ногдох хэрэглээнд юуг хамааруулж байгаа, түүний бүрдэл хэсгүүдийн үнэмлэхүй болон харьцангуй ач холбогдлыг тодруулах нь чухал.

Судалгааны дүнгээр Монгол улсын нэг хүнд ногдох сарын хэрэглээ 2007-2008 онд 100865 төгрөг[13] байна. Хүн амын дундаж хэрэглээг зардлын үндсэн бүлгүүдээр болон хот, хөдөө, бүс нутгаар Хүснэгт 2.1-д харуулав. Хот, суурин газрын хүн амын хэрэглээний түвшин хөдөөнийхээс эрс их буюу 40 хувиар илүү байна. Үүнийг хүн амын суурьшлаар авч үзвэл нэгдүгээрт, нийслэл хот, хоёрдугаарт, аймгийн төвүүд, гуравдугаарт, сумын төв орж харин хөдөө нутгийнхан хамгийн бага хэрэглээтэй байна. Бүс нутгуудын хувьд хэрэглээний түвшин Төвийн бүсэд хамгийн өндөр бөгөөд улсын дунджаас өндөр хэрэглээтэй цорын ганц бүс болж байна. Хоёрдугаарт Зүүн бүс, гуравдугаарт Хангайн бүс, хамгийн сүүлд Баруун бүс орж байна. Гэвч эдгээр гурван бүсийн хэрэглээний ялгаа тун бага байна

[13] Энэхүү тайлангийн мөнгөн дүнгээр илэрхийлэгдсэн мэдээлэл нь 2007-2008 оны зэрэгцүүлсэн үнээр тооцогдсон байгаа болно.

Хүснэгт 2.1 **Нэг хүнд  сард ногдох хэрэглээ, үндсэн нэр төрлөөр, төгрөгөөр**

Хүн амын хэрэглээний бүтцийг энэ хүснэгтийн доод хэсэгт үзүүллээ. Хүнс нь нийт хэрэглээний 36 хувийг эзлэх гол бүрдэл хэсэг бөгөөд хот, хөдөөд хувь хэмжээ нь үлэмж ялгаатай байна. Хот суурин газрын аж байдлын түвшин хөдөөнийхөөс өөр бөгөөд хэрэглээний бусад шаардлагатай зардлаас шалтгаалан хүнсний хувийн жин нь арай бага байдаг. Бодит байдал дээр дээрх таамаглал батлагдаж байна. Хотод хүнсний зүйл нийт хэрэглээний 33 хувь болж байхад, хөдөөд 43 хувь болж байна. Хотын суурьшлын хоёр ангилал буюу нийслэл хот, аймгийн төвүүдэд хүнсний хувь хэмжээ нь ойролцоо буюу дээр өгүүлснээр гуравны нэг орчим хувьтай тэнцэж байна. Харин хөдөөд илүү их ялгаа ажиглагдаж байгаа бөгөөд сумын төвд улсын дундажтай ойролцоо байхад хөдөө нутагт хүнс нийт хэрэглээний бараг тэн хагастай тэнцэж байна. Бүсүүдийн хувьд хүнсний хувь хэмжээ нь харьцангуй ойролцоо, хамгийн бага нь Төвийн бүсэд 36 хувь, хамгийн их нь Баруун бүсэд 41 хувь болж байна.

Хүнсний бус нэр төрлүүдийн дотроос хамгийн том бүрэлдэхүүн хэсэг нь болох гутал, хувцасны зардал улсын дунджаар нийт хэрэглээний 17 хувийг эзэлж байгаа бөгөөд хотод үүнээс арай бага хувь, харин хөдөөд бараг 20 хувь байна. Тээвэр, холбоо нь нийт хэрэглээний 13 хувийг эзэлж байгаа бөгөөд нийслэл хотод хамгийн өндөр, харин бусад гурван суурьшилд ойролцоо хэмжээтэй байна. Боловсрол нь нийт хэрэглээний 7 хувь болж байгаа бөгөөд бүхий л байршилд харьцангуй ойролцоо хувь хэмжээтэй байна. Сууцны хэрэглээ нь нийт хэрэглээний зөвхөн 6 хувь болж байгаа бөгөөд хотод 8 хувь, харин хөдөөд 1 хүрэхтэй үгүйтэй хувийг эзэлж байна. Эрүүл мэндийн зардал нь бүх байршлаар тогтвортой буюу 5 хувь болж байна. Халаалтын зардал нь нийт хэрэглээний 3 хувь болж байгаа бөгөөд хотод 4 хувь, хөдөөд 2 хувь байна. Халаалтын хувийн жин бүс нутгуудад бараг адилхан байна. Ус, цахилгаан, гэрэлтүүлэг зэрэг ахуйн хэрэглээ 3 хувь болж байна. Нийт хэрэглээний үлдсэн 10 хувь нь амралт чөлөөт цаг, гоо сайхан, удаан эдэлгээт бараа болон архи, тамхинд ноогдож байна.

Ядуурлын байдал болон хот, хөдөөгийн байршлын хувьд бүр илүү ялгаа ажиглагдаж байна. (Хүснэгт 2.2) Нэгдүгээрт, ядуучуудын дундаж хэрэглээ нь ядуу бус хүн амын дундаж хэрэглээний гуравны нэгтэй тэнцэж байна. Хоёрдугаарт, ядуу бус хүн амын хүнсний дундаж хэрэглээ ядуучуудын хүнсний дундаж хэрэглээнээс бараг хоёр дахин их бөгөөд гэхдээ нийт хэрэглээ нь асар зөрөөтэй учраас ядуучуудын хэрэглээнд хүнсний хувийн жин өндөр гарч байна. Гуравдугаарт, боловсролын дундаж зардал нь ядуурлын байдлаар эрс ялгарч байгаа боловч хувь хэмжээгээр авч үзвэл ядуу бус хүн амынх ядуу хүн амынхаас бага зэрэг л өндөр байна. Дөрөвдүгээрт, ядуу бус хүн амын эрүүл мэндийн дундаж зардал нь ядуучуудынхаас үлэмж өндөр бөгөөд хувь хэмжээний хувьд ч илүү байна. Тавдугаарт ядуу бус хүн ам нь халаалтандаа ядуучуудаас илүү зардал гаргадаг боловч хувь хэмжээгээрээ ядуу хүн амынх илүү байна. Хөдөөд ядуучуудын халаалтын зардлын хувьд эсрэг үр дүн харагдаж байгаа учраас дээрх үр дүн нь хотын ядуучуудын халаалтын хувь хэмжээнээс шалтгаалан гарч байна. Зургаадугаарт ядуу бус хүн амын хувцасны зардал үлэмж өндөр байгаа боловч ядуу хүн амын хувцасны зардлын хувь хэмжээ нь харьцангуй өндөр байна. Эцэст нь тэмдэглэхэд, ядуу бус хүн ам тээвэр холбооны

зардалд ядуу хүн амыг бодвол үнэмлэхүй болон харьцангуй үлэмж ихийг зарцуулдаг байна.

Хүснэгт 2.2. Сард нэг хүнд ногдох хэрэглээ, үндсэн нэр төрлөөр, ядуурлын байдлаар, хот хөдөөгөөр

## 2.2 Ядуурал улирлын хэлбэлзлээс хамаарах нь

Улирлаар хэлбэлздэг нь Монгол дахь ядуурлын нэг онцлог юм. Хүн амын хэрэглээний түвшин ингэж улирлаар хэлбэлзэхэд мал аж ахуй, газар тариалан эрхлэлтийн хүчин зүйлүүд хамгийн их нөлөөлдөг. Хүнсний хэрэглээний бүтэц нь улирлаар эрс өөрчлөгдөх буюу зунд сүү, цагаан идээ, намар хүнсний ногоо, өвөл махыг түлхүү хэрэглэх боловч хавар ерөнхийдөө тарчигдуу болдог байна. Намартаа сүү, цагаан идээ сайтай, махны хангамж бас сайжирдаг тул дөрвөн улирал дотроо хүнсний хэрэглээ хамгийн өндөр, харьцангуй элбэг дэлбэг улирал юм. Бид өмнөх тайлантай харьцуулах боломжийг хангахын тулд Монгол орны байгалийн дөрвөн улирлаар[14] бус харин хуанлийн дөрвөн улирлаар дүн шинжилгээ хийлээ.

Судалгаа явуулсан нэг жилийн хугацаанд хүн амын аж байдал улирлаас улиралд дордсон бөгөөд үүнийг зөвхөн улирлын хэлбэлзэл[15] юм уу, өрхүүдийн шинж чанараар[16] тайлбарлах бололцоогүй гэж үзэж байна. (Хүснэгт 2.3) Ядуурлын хамралтын хүрээ нь судалгааны эхний улиралд 25.1 хувь байсан бол сүүлийн улирал буюу сүүлийн гурван сард 42.1 хувь болж өссөн бөгөөд энэ хугацаанд ядуурлын гүнзгийрэлт, ядуурлын мэдрэмж хоёулаа бараг хоёр дахин нэмэгдсэн байна. Ядуурал нь судалгааны гуравдугаар улирал хүртэл харьцангуй хурдацтай харин судалгааны дөрөвдүгээр улиралд арай удаан явцтай нэмэгдсэн байна. Энэ чиг хандлага нь бараг бүх хот, хөдөөд, бүх суурьшил, бүс нутгуудад ижилхэн байна. Ядуурлын хамрах хүрээ судалгааны сүүлийн улиралд хотод 14 пунктээр, хөдөөд 21 пунктээр нэмэгджээ. Нийслэл хот болон аймгийн төвүүдэд энэ өсөлт нь хотын нийт өсөлт буюу 14 пункттэй ойролцоо байхад хөдөөгөөр нь авч үзвэл сумын төвийг бодвол хөдөө нутагт харьцангуй их (харгалзан 17 болон 24 пунктээр) өссөн байна.

[14] Монгол улсад 6-8-р сарууд нь зун, 9-11-р сарууд нь намар, 12-2 сарууд нь өвөл, 3-5 сарууд нь хаврын улиралд тооцогддог.

[15] Хэрэглээний бүтцийг улирлын үнийн зөрүүгээр хангалттай засварласан гэдгийг хэлэх нь зүйтэй. (Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт Б-ээс харна уу.)

[16] Хүснэгтэнд байгаа нэмэлт үзүүлэлтээс харахад түүвэр дэх өрхийн хүн ам зүйн шинж чанар болон хотжилтын зэрэгт дөрвөн улирлын онц ялгаа ажиглагдахгүй байна.

**Хүснэгт 2.3. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улирлаар**

| | Улсын дундаж | I улирал (2007 7-9 сар) | II улирал (2007 10-12 сар) | III улирал (2008 1-3 сар) | III улирал (2008 4-6 сар) |
|---|---|---|---|---|---|
| Ядуурлын хамралтын хүрээ | 35.2 | 25.1 | 33.3 | 40.5 | 42.1 |
| | (0.8) | (1.5) | (1.6) | (1.8) | (1.8) |
| Ядуурлын гүнзгийрэлт | 10.1 | 6.9 | 9.3 | 11.5 | 12.7 |
| | (0.3) | (0.5) | (0.6) | (0.6) | (0.7) |
| Ядуурлын мэдрэмж | 4.0 | 2.8 | 3.6 | 4.5 | 5.1 |
| | (0.2) | (0.3) | (0.3) | (0.3) | (0.3) |
| *Нэмэлт үзүүлэлтүүд:* | | | | | |
| Хүн амын хувийн жин (%) | 100.0 | 25.1 | 24.8 | 25.0 | 25.1 |
| Ядуурлын шугамаас доогуур хү | 100.0 | 17.9 | 23.5 | 28.7 | 29.9 |
| Өрхийн ам бүлийн тоо | 3.9 | 3.9 | 3.9 | 3.9 | 3.9 |
| Хүн ам зүйн ачаалал (%) | 38.9 | 39.1 | 39.5 | 38.6 | 38.3 |
| Хүүхдийн тоо (% өрхийн ам б | 26.4 | 26.9 | 27.0 | 26.3 | 25.4 |
| Өрхийн тэргүүний нас | 44.9 | 44.5 | 44.7 | 44.9 | 45.4 |
| Эрэгтэй тэргүүнтэй өрх (%) | 78.0 | 79.2 | 77.5 | 78.5 | 76.9 |
| Хотжилт (%) | 57.6 | 57.3 | 57.0 | 58.1 | 57.8 |

*Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав*

*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-2008*

Дээрх ажиглалтыг тайлбарлах аливаа оролдлого нь энэ тайлангийн хүрээнээс хальсан хэрэг болох хэдий ч дэлхий даяар хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэ өргөн хүрээнд огцом өссөн цаг үе нь манай судалгааны үетэй давхацсан нь нөлөөлсөн гэсэн илэрхий үндэслэлтэй таамаглал дэвшүүлж болно. Ядуучуудын хүнсний хэрэглээ нь ядуу бус хүн амыг бодвол нийт хэрэглээндээ илүү өндөр хувь хэмжээтэй байдаг тул хүнсний бүтээгдэхүүний үнэ өссөн нь тэдэнд илүү хүндээр туссан нь дамжиггүй. Жишээ нь, судалгаанд хамрах хугацаанд хүнсний бүтээгдэхүүний үнийн инфляци 50 орчим хувьтай байсан бөгөөд монголчуудын хоол тэжээлийн бүтцэд голлодог гурил, цагаан будаа, талх, хүнсний ногооны үнэ бүр илүүтэйгээр өссөн байна.[17] Судалгааны хоёрдугаар хагаст инфляци онцгой өндөр байсан бөгөөд энэ үед ядуурлын өсөлт мөн дээд хэмжээндээ хүрчээ. Үнийн өсөлтийн мэдээлэл нь мөн хүнсний бүтээгдэхүүний үнийн инфляци хот, хөдөөд зэрэг явагдсаныг мөн харуулж байгаа билээ.

## 2.3 Өрхийн ам бүлийн бүтэц

Судалгаанд хамрагдсан өрхүүд өрхийн ам бүлийн бүтцийн хувьд хоорондоо ялгаатай байна. Зарим өрх нь үндсэн гэр бүлээс (эхнэр, нөхөр, хүүхдүүдээс бүрдсэн өрх), нөгөө хэсэг нь өргөтгөсөн гэр бүлээс (эхнэр, нөхөр,

[17] Энэ 12 сарын хугацаан дахь хүнсний бүтээгдэхүүний үнийн нифляци нь албан ёсны мэдээгээр 47 õóâü боловч өрхийн судалгааны тооцоллоор 54 õóâü байна.

хүүхдүүдээс гадна бусад хамаатнуудаас бүрдсэн гэр бүл) тус тус бүрдэж байхад зарим өрхүүд олон хүүхэдтэй, эсвэл зөвхөн өндөр настай хүмүүсээс бүрдсэн гэх мэтээр өөр өөр байна. Тиймээс ядуурал болон өрхийн ам бүлийн бүтцийн хооронд харилцан хамаарал байна уу? Хүснэгт 2.4-д өрхийн ам бүлийн тооноос шалтгаалж ядуурлын үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдөж байгааг харуулж байна. Өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тутам ядуурлын хамралтын хүрээ жигд өсч байна. Энэ нь аж байдлын үзүүлэлтийг нэг хүнд ногдох хэрэглээгээр авч байгаа тохиолдолд буюу өрхийн гишүүн бүр ижил хэрэглээтэй (эсвэл өрхөд эдийн засгийн хэм хэмжээний тохируулга хэрэггүй) гэж үзсэн учраас энэ хандлагад тийм ч гайхмаар зүйл биш юм.

Хоёр хүртэлх ам бүлтэй өрхийн хувьд ядуу байх магадлал ойролцоогоор 10 гаруй хувь байна. Ийм өрх нийт хүн амын 9 хувь, харин ядуучуудын 3 хувийг эзэлж байна. Дундаж буюу гурав, дөрөв, таван ам бүлтэй өрхүүдийн ядуурлын хамралтын хүрээ 31 орчим хувь болж байна. Эдгээр өрх нийт хүн амын гуравны хоёрыг, ядуучуудын тавны гурвыг эзэлж байна. Харин таваас дээш ам бүлтэй өрхийн талаас илүү хувь нь ядуу байна. Ийм өрхөд амьдардаг хүмүүс нийт хүн амын дөрөвний нэгийг эзэлж байгаа боловч нийт ядуучуудын тавны хоёрыг бүрдүүлж байна. Наймаас багагүй ам бүлтэй өрхүүдэд ядуурал бүр онцгой их буюу 70 орчим хувь нь ядуурлын шугамаас доогуур амьдарч байна. Ийм олон ам бүлтэй өрх нийт хүн амын 6 хувийг, харин ядуучуудын 12 хувийг эзэлж байна.

## Хүснэгт 2.4. Ядуурал ба өрхийн ам бүлийн тоо

| | Улсын дундаж | Өрхийн ам бүлийн тоо | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | | 7 -аас багаүй |
| Ядуурлын хамралтын хүрээ | 35.2 | 8.9 | 13.4 | 21.8 | 30.3 | 38.6 | 47.8 | 53.6 | 69.0 |
| | (0.8) | (1.1) | (1.0) | (1.0) | (1.1) | (1.4) | (1.9) | (2.8) | (3.1) |
| Ядуурлын гүнзгийрэлт | 10.1 | 1.7 | 2.9 | 4.9 | 7.8 | 10.8 | 14.5 | 18.1 | 24.8 |
| | (0.3) | (0.3) | (0.3) | (0.3) | (0.4) | (0.5) | (0.7) | (1.2) | (1.6) |
| Ядуурлын мэдрэмж | 4.0 | 0.5 | 1.0 | 1.6 | 2.8 | 4.1 | 5.9 | 8.0 | 11.5 |
| | (0.2) | (0.1) | (0.1) | (0.1) | (0.2) | (0.2) | (0.4) | (0.7) | (1.0) |
| *Нэмэлт үзүүлэлтүүд:* | | | | | | | | | |
| Хүн амын хувийн жин (%) | 100.0 | 1.9 | 6.7 | 16.9 | 27.4 | 21.6 | 12.7 | 6.7 | 6.1 |
| Ядуурлын шугамаас доогуур хүн амын | 100.0 | 0.5 | 2.6 | 10.4 | 23.6 | 23.7 | 17.2 | 10.1 | 12.0 |
| Хүн ам зүйн ачаалал (%) | 38.9 | 50.4 | 41.0 | 33.5 | 38.7 | 38.8 | 40.1 | 38.2 | 40.2 |
| Хүүхдийн тоо (% өрхийн ам бүлд) | 26.4 | 0.3 | 9.8 | 24.1 | 33.8 | 34.7 | 35.5 | 33.5 | 35.5 |
| Өрхийн тэргүүний нас | 44.9 | 53.5 | 49.9 | 42.2 | 41.6 | 43.8 | 45.6 | 48.4 | 50.1 |
| Эрэгтэй тэргүүнтэй өрх (%) | 78.0 | 45.3 | 60.7 | 75.1 | 86.5 | 90.3 | 87.5 | 84.4 | 77.8 |

*Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав*

Өрхийн ам бүлийн байдалд дүн шинжилгээ хийх хоёр дахь арга бол хүн ам зүйн ачааллын харьцаа юм. Өрхийн ам бүлийн бүтцийг судлахад энэ үзүүлэлтийг өргөн ашигладаг бөгөөд өрхийн хөдөлмөрийн бус насны гишүүдийг өрхийн нийт гишүүдийн тоонд харьцуулсантай тэнцэнэ.[18] Тиймээс энэ нь өрхөд байгаа **“**тэжээлгэгчдийн**”** хувийн жинг илэрхийлнэ. Зураг 2.1-д ядуурлын хамралтын хүрээ болон хүн ам зүйн ачааллын хоорондын хамаарлыг харуулав. Хүн ам зүйн ачааллын харьцаа их байх тусам тухайн өрх ядууралд илүү өртөмтгий байна. Өрхийн ам бүлийн тоонд хүүхэд, өндөр настны эзлэх хувийн жин хөдөлмөр эрхэлж байгаа гишүүдийн хувийн жинтэй харьцуулахад өндөр байх нь “орлого олж буй” гишүүд өөрөөсөө гадна тодорхой тооны хүнийг тэжээж байгааг харуулах бөгөөд өрхийн гишүүн бүрт ногдох орлого ба хэрэглээний түвшин буурч ядуурал нэмэгдэнэ. Энэ харьцаа нь ихэвчлэн 70 хувь хүртэлх утгыг авдаг бөгөөд үүнээс дээш байгаа тохиолдолд ядуурал буурч байна. Энэ үзүүлэлт ингэж харьцангуй өндөр байгаа нь тухайн өрхөд байгаа тэжээгдэгчдийн хувийн жин өндөр байгааг илэрхийлж байгаа боловч эдгээр өрх нь ихэвчлэн ажил эрхэлж буй, эсвэл тэтгэвэр, хамаатнуудаас өгөх тусламж зэрэг тогтмол орлоготой өндөр настнуудаас бүрдсэн байдаг тул ядууралд өртөх нь багасаж байгааг дээрх үр дүн харуулж байна.**[19]**

**Зураг 2.1. Ядуурал ба хүн ам зүйн ачааллын харьцаа**




[18] Үүний зэрэгцээ хөдөлмөрийн бус насны хүн ам ба хөдөлмөрийн насны хүн амын харьцаа буюу ерөнхийдөө 15 ба түүнээс доош насны ба 64-өөс дээш насны хүн амыг 15-64 насны хүн амд харьцуулсан харьцаагаар тодорхойлж болно. Тиймээс энэ нь өрхийн “орлогоологч” бүрт хэдэн “тэжээгдэгч” байгааг илэрхийлдэг. Гэхдээ Монгол улсын нөхцөлд хөдөлмөрийн насыг тодорхойлохдоо өөр ангилал баримталдаг бөгөөд 16-59 насны эрэгтэйчүүд, 16-54 насны эмэгтэйчүүдийг хөдөлмөрийн насны хүн амд тооцдог.

[19] Жишээ нь хүн амын ачааллын түвшин 70 õóâèас өндөр өрхүүдийн гуравны хоёрынх нь өрхийн тэргүүлэгч нь тэтгэвэр авдаг өндөр настнууд байна. Үүнийг 70 õóâèàñ бага үзүүлэлттэй өрхүүдийн аравны нэгийнх нь өрхийн тэргүүлэгч тэтгэвэр авдаг өндөр настан байгаатай харьцуулахад сонирхолтой юм.

## 2.4 Өрхийн тэргүүлэгчийн шинж байдал

Ядуурлын талаархи зарим харьцуулалтыг хийхийн тулд өрхийн тэргүүлэгчийн тодорхой шинж байдлаар нь өрхүүдийг ангилах нь практикт элбэг байдаг[20]. Зарим сул тал байдаг ч энэ нь өрх хоорондын харьцуулалтыг хийх энгийн бөгөөд чухал аргын нэг мөн юм[21]. Өрхийн эдийн засгийн гол эх үүсвэр болон амьжиргааны байдлыг ихэнх тохиолдолд тодорхойлж байдаг өрхийн тэргүүлэгчдийн шинж байдалтай тухайн өрхийн ам бүлийн байдал, амьжиргааны түвшний асуудал нь зайлшгүй хамааралтай. Жишээлбэл, дээд боловсролтой тэргүүлэгчтэй өрхүүд хотод амьдарч улмаар энэ өрхүүд улсын дунджаас цөөн хүүхэдтэй байх магадлалтай. Энэ бүлэгт өрхийн тэргүүлэгчийн нас, хүйс, боловсролын түвшин, ажил эрхлэлт, шилжилт хөдөлгөөний байдлыг ядууралтай холбон авч үзэв.

### 2.4.1 Нас

Өрхийн тэргүүлэгчийн нас ядууралтай ямар хамааралтай байна вэ? Хүснэгт 2.5-д өрхийн тэргүүлэгчийн насыг таван бүлэг болгон хуваах харгалзах ядуурлын хэмжүүрүүдийг нь үзүүлэв. Гучаад насны бүлэгт ядуурал өсөж, дөч гарахаар буурч, тавь гарахаар бүр илүү буурсаар жар гарахаар тогтворжиж байгаа дүр зураг ажиглагдаж байна. Нийт өрхийн тавны гурав нь дундаж насны тэргүүлэгчтэй, аравны гурав нь өндөр настай, харин аравны нэг шахам нь залуу өрхийн тэргүүлэгчтэй байна. Ядуучуудын тархалт нь хүн амын тархалттай харьцангуй дүйж байна. Ядуурлын хандлаганд энэ бүлгүүдийн хэрэглээний зөрөө нөлөөлсөн байж болох талтай. Жишээ нь өрхийн тэргүүлэгч гуч гарах үед өрхийн ам бүлийн тоо нэгээр буюу шинэ хүүхдээр нэмэгддэг учраас энэ бүлэгт ядуурал нэмэгдсэн байна. Түүнчлэн илүү өндөр насны бүлэгт өрхийн тэргүүлэгч нь эмэгтэй байх магадлал нэмэгдэж байна.

---

[20] ӨНЭЗС-нд өрхийн тэргүүлэгчийн хувьд маш нарийн тодорхойлолтыг ашигласан. Өрхийн тэргүүлэгч гэдэг нь өрхийн бусад гишүүдийн хүлээн зөвшөөрсөн, бусдыг зохион байгуулахад гол үүрэг гүйцэтгэдэг, өрхийн бэрхшээлтэй асуудлуудад ихэнх хариуцлагыг хүлээдэг, өрхийн санхүүгийн асуудлыг ихэвчлэн шийдвэрлэдэг гишүүн юм.

[21] Сул талын тухай ярихад жишээлбэл, хэдийгээр өрхийн хамгийн өндөр настай гишүүн дээрх тодорхойлолтонд тохирохгүй ч гэсэн түүнд хүндлэл үзүүлж өрхийн тэргүүн гэж тооцдог. Бас нэгэн жишээ бол бэлэвсэн эмэгтэй өрхийн тэргүүний үүрэг гүйцэтгэж байгаа боловч хамгийн том хүүгээ өрхийн тэргүүн гэж нэрлэх нь Монголчуудын дунд түгээмэл заншил юм.

**Хүснэгт 2.5. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн насаар**

| | Улсын дундаж | <30 | 30 - 39 | 40 - 49 | 50 - 59 | >=60 |
|---|---|---|---|---|---|---|
| Ядуурлын хамралтын хүрээ | 35.2 | 33.9 | 38.3 | 36.3 | 31.9 | 31.6 |
| | (0.8) | (1.6) | (1.2) | (1.1) | (1.5) | (1.6) |
| Ядуурлын гүнзгийрэлт | 10.1 | 9.4 | 10.9 | 10.7 | 9.4 | 8.5 |
| | (0.3) | (0.6) | (0.4) | (0.5) | (0.6) | (0.5) |
| Ядуурлын мэдрэмж | 4.0 | 3.6 | 4.2 | 4.4 | 3.8 | 3.2 |
| | (0.2) | (0.3) | (0.2) | (0.3) | (0.3) | (0.3) |
| *Нэмэлт үзүүлэлтүүд:* | | | | | | |
| Хүн амын хувийн жин (%) | 100.0 | 11.0 | 28.0 | 31.3 | 16.4 | 13.4 |
| Ядуурлын шугамаас доогуур хүн а | 100.0 | 10.5 | 30.5 | 32.2 | 14.8 | 12.0 |
| Өрхийн ам бүлийн тоо | 3.9 | 3.2 | 4.0 | 4.4 | 4.1 | 3.1 |
| Хүн ам зүйн ачаалал (%) | 38.9 | 32.2 | 44.8 | 25.7 | 21.9 | 71.9 |
| Хүүхдийн тоо (% өрхийн ам бүлд | 26.4 | 30.1 | 43.2 | 24.5 | 13.5 | 11.1 |
| Өрхийн тэргүүлэгчийн нас | 44.9 | 25.7 | 34.7 | 44.4 | 53.8 | 69.2 |
| Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%) | 78.0 | 87.7 | 85.1 | 80.0 | 72.7 | 60.4 |

*Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав*

*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-2008*

## 2.4.2 Хүйс

Өрхийн судалгааны дүнгээр эмэгтэй тэргүүлэгчтэй өрхүүдийн ядуурлын хамралтын хүрээ нь эрэгтэй тэргүүлэгчтэй өрхүүдийнхтэй ойролцоо байна. (Хүснэгт 2.6)

**Хүснэгт 2.6 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр**

Хэдийгээр хот суурин газарт эрэгтэй тэргүүлэгчтэй өрхүүдийн ядуурал арай бага байгаа боловч хөдөөд бол бараг ялгарахааргүй байна. 6 өрх тутмын нэг нь эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй бөгөөд энэ үзүүлэлт хотод тавны нэг болж өсөж хөдөөд наймны нэг болж буурч байна. Ядуучуудын тархалтыг хүйсээр ажиглахад бараг адилхан хувь хэмжээтэй байна. Гэвч бид эрс өөр өөр бүтэц бүхий өрхүүдийг үнэлж байгаа гэдгийг дээр үр дүнгүүдийг ашиглахдаа бодолцох ёстой. Өрхүүдийн хүн ам зүйн гурван онцлогийг үүнтэй холбогдуулан дурдаж болох юм. Нэгдүгээрт, таван эмэгтэй тэргүүлэгч тутмын бараг дөрөв нь бэлэвсэн, салсан эсвэл тусгаарласан байхад арван эрэгтэй тэргүүлэгч тутмын ес нь хань ижилтэй байна. Хоёрдугаарт, эмэгтэй тэргүүлэгчтэй өрхүүдийн дундаж ам бүл нь 3 байхад эрэгтэй тэргүүлэгчтэй өрхүүдийн дундаж ам бүл үүнээс олон буюу 4 байна. Эцэст нь тэмдэглэхэд, өрхийн тэргүүлэгчүүдийн хүйсэнд насны зөрөө тод ажиглагдаж байна. Эмэгтэй өрхийн тэргүүлэгчийн дундаж нас эрэгтэй өрхийн тэргүүлэгчийнхээс 8-аар өндөр байна.

### 2.4.3 Боловсрол

Хүний нөөцийн нэг үндсэн үзүүлэлт бол боловсрол юм. Иймээс хүн амын амьжиргааны түвшинг нэмэгдүүлэх нэгэн чухал хүчин зүйл нь боловсролын асуудал гэж үзэж болно. Боловсролгүй эсвэл бага боловсролтой хүн мэргэжлийн ур чадвар шаардахгүй ажил буюу бүтээмж муутай, цалин багатай ажил хийж улмаар хүндрэл, бэрхшээлд илүү өртөмтгий байдаг. Боловсролын түвшин өндөр байх нь ажилд орох боломжуудыг нэмж өгөхөөс гадна эрүүл мэнд сайтай байхын ач холбогдол, нийгэмдээ илүү идэвхитэй оролцоотой байх зэрэг аж байдлын бусад чухал талуудыг ойлгоход тусалдаг.

Хүснэгт 2.7-д ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг өрхийн тэргүүлэгчийн эзэмшсэн боловсролын дээд түвшнээр харуулав. Боловсролын түвшин ба ядуурлын хоорондын хамаарлын талаар дүгнэлт хийхийн өмнө өрхийн тэргүүлэгчдийн боловсролын ерөнхий түвшин харьцангүй өндөр буюу улсын хэмжээгээр долоон хүн бүрийн зургаа нь наад зах нь ЕБС-ийн 8 дугаар анги төгссөн буюу бүрэн бус дунд[22] болон түүнээс дээш боловсрол эзэмшсэн тэргүүлэгчтэй өрхөд, харин долоон хүн тутмын нэг нь л боловсролгүй эсвэл бага боловсролтой тэргүүлэгч бүхий өрхөд амьдарч байна гэдгийг хэлэх нь зүйтэй.[23] Бидний таамаглаж байсанчлан, өрхийн тэргүүлэгчийн эзэмшсэн боловсролын түвшин өндөр байх тутам тухайн өрх ядууралд өртөх магадлал багатай байна.

Өрхийн тэргүүлэгч бүрэн дундаас дээш боловсролтой байх нь ядууралд өртөх магадлалыг бууруулж байгаа буюу ийм өрхөд амьдардаг хүн амын ядуурлын хамрах хүрээ 35 байна. Бүрэн дундаас бага боловсролтой тэргүүлэгчтэй өрхүүдийн хувьд ядуурлын хамралтын хүрээ ойролцоогоор 50 хувь, харин бүрэн дундаас дээш боловсролтой тэргүүлэгчтэй өрхүүдийн хувьд 16 хувь байна. Энэ хоёр том бүлэг тус бүрийн доторх ялгааг дээрх тоо баримт харуулж чадахгүй байна. Боловсролгүй өрхүүд ядууралд хамгийн их өртөж байхад, бага боловсролтой буюу бүрэн бус дунд боловсролтой тэргүүлэгчтэй өрхүүдийн хувьд ядуурлын хамралтын хүрээ ойролцоо байна.

Дипломын дээд боловсрол бүхий тэргүүлэгчтэй өрхүүд болон бакалаврын зэрэгтэй өрхүүдийн ядуурлын хамралтын хүрээ бараг ижилхэн байгаа нь 2002-2003 оны үр дүнгээс эрс өөр байна. Харин мэргэжлийн боловсролтой тэргүүлэгчтэй өрхүүдийн ядуурлын хамралтын хүрээ нь бусад дунд

---

[22] Бүрэн бус дунд боловсролын сургалтын жилийн тоо нь төгссөн оноос хамаарч байна. 1963 он хүртэл бүрэн бус дунд боловсрол нь 7 жилийн сургалттай байсан. 1964-2004 оон хүртэл 8 жил, 2005 оноос 9 жилийн сургалттай болоод байна.

[23] 2002-2003 оны мэдээлэлтэй харьцуулахад зарим ¿ð ä¿íã тайлбарлахад õ¿íäðýëòýé áàéãàà áèëýý. Жишээ нь өрхийн тэргүүлэгч нь бүрэн дуíд боловсролтой өрхөд амьдарч байгаа хүн амын тоо 18.8 хувиас 31.4 хувь болж өс÷, харин өрхийн тэргүүлэгч нь дээд боловсролтой буюу эсвэл дипломын дээд боловсролтой өрхөд амьдарч байгаа хүн амын тоо 25 хувиас 16 хувь болж буурчээ. Гэтэл өрхийн тэргүүлэгчийн тодорхойлолт болон боловсролын түвшингийн тухай асуултууд энэ хоёр судалгаанд яг адилхан байгаа билээ.

боловсролтой тэргүүлэгчтэй өрхүүдийнхээс бага байгаа нь тодорхой боловч харин дипломын дээд боловсролтой болон бакалаврын боловсролтой тэргүүлэгчтэй өрхүүдийнхээс их байна. Хот, хөдөөд дээрх дүгнэлт адилхан хамаатай ч ялгарал нь хотод илүү байна.

## Хүснэгт 2.7. Ядуурал ба өрхийн тэргүүлэгчийн эзэмшсэн боловсролын дээд түвшин

| | Улсын хэмжээнд | Боловсролгүй | Бага | Бүрэн бус дунд | Бүрэн дунд | Мэргэжлийн | Дипломын дээд | Бакалавр | Бусад |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ядуурлын хамралтын хүрээ | 35.2 | 58.0 | 51.5 | 48.1 | 34.6 | 25.3 | 9.5 | 8.8 | 6.1 |
| | (0.8) | (2.8) | (1.7) | (1.4) | (1.2) | (1.6) | (1.1) | (1.4) | (4.5) |
| Ядуурлын гүнзгийрэлт | 10.1 | 19.8 | 16.0 | 14.1 | 9.3 | 6.9 | 2.1 | 2.3 | 0.6 |
| | (0.3) | (1.4) | (0.7) | (0.5) | (0.4) | (0.5) | (0.3) | (0.5) | (0.4) |
| Ядуурлын мэдрэмж | 4.0 | 8.9 | 6.7 | 5.6 | 3.5 | 2.6 | 0.6 | 0.8 | 0.1 |
| | (0.2) | (0.9) | (0.4) | (0.3) | (0.2) | (0.3) | (0.1) | (0.2) | (0.0) |
| *Нэмэлт үзүүлэлтүүд:* | | | | | | | | | |
| Хүн амын хувийн жин (%) | 100.0 | 3.9 | 11.9 | 23.1 | 31.4 | 13.0 | 10.0 | 6.0 | 0.6 |
| Ядуурлын шугамаас доогуур хү | 100.0 | 6.5 | 17.4 | 31.6 | 30.9 | 9.4 | 2.7 | 1.5 | 0.1 |
| Өрхийн ам бүлийн тоо | 3.9 | 3.3 | 3.6 | 4.2 | 4.0 | 4.0 | 3.7 | 3.3 | 3.6 |
| Хүн ам зүйн ачаалал (%) | 38.9 | 52.8 | 49.6 | 37.4 | 35.8 | 36.7 | 38.6 | 32.6 | 30.4 |
| Хүүхдийн тоо (% өрхийн ам бү | 26.4 | 22.3 | 20.9 | 29.6 | 30.1 | 25.1 | 19.7 | 26.0 | 24.7 |
| Өрхийн тэргүүлэгчийн нас | 44.9 | 52.8 | 52.6 | 42.7 | 40.9 | 47.1 | 50.0 | 37.9 | 39.8 |
| Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%) | 78.0 | 59.9 | 71.2 | 85.5 | 80.9 | 72.2 | 80.1 | 74.7 | 80.9 |

*Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав*

*Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав*

*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-2008*

### 2.4.4 Ажил эрхлэлт

Өрхийн аж байдлыг тодорхойлогч нэгэн чухал хүчин зүйл бол өрхийн гишүүдийн, нэн ялангуяа өрхийн тэргүүлэгчийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, тухайлбал хөдөлмөр эрхлэх боломж, эрхэлж байгаа ажлын төрөл болно. Хүснэгт 2.8-д ядуурлын талаарх мэдээллийг ажиллах хүчний оролцоо, ажил эрхлэлтийн үндсэн салбараар харуулав.[24]

Өрхийн тэргүүлэгч нь ажил эрхэлж байгаа өрхөд амьдарч байгаа хүн амын амьжиргааны түвшин, өрхийн тэргүүлэгч нь ажилгүй өрхүүдийн хүн амын амьжиргааны түвшнээс өндөр, харин ажиллах хүчнээс гадуурх өрхийн тэргүүлэгчтэй өрхүүдийнхтэй ойролцоо байна. Ажил эрхэлж байгаа тэргүүлэгчтэй өрхүүдийн дундаас үйлчилгээний салбарт ажиллаж байгаа тэргүүлэгчтэй өрхийн ядуурлын түвшин аж үйлдвэрийн салбарт өрхийн тэргүүлэгч нь ажилладаг өрх болон хөдөө аж ахуйд ажиллаж байгаа тэргүүлэгчтэй өрхөөс (энэ тохиолдолд нилээд хэмжээгээр) доогуур байна. Ядуучуудын тавны хоёр нь өрхийн тэргүүлэгч нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ажилладаг, тавны нэг нь үйлчилгээний салбарт ажилладаг, долооны нэг нь аж үйлдвэрийн салбарт ажилладаг тэргүүлэгчтэй өрхөд амьдарч байгаа бөгөөд дөрөвний нэг орчим нь өрхийн тэргүүлэгч нь сүүлийн нэг жилийн хугацаанд огт ажил эрхлээгүй өрхөд амьдарч байна. Хөдөө аж ахуйд ажиллагсдын хувийн жин буурч, үйлчилгээний салбарынх өсч байгааг эс тооцвол нийт хүн амын тархалт үүнтэй ойролцоо байна.

[24] Хэрэв тухайн хүн сүүлийн жил ажил эрхэлсэн, ажил эрхлээгүй боловч байнгын ажилтай, эсвэл ажилгүй бөгөөд ажил хайсан бол ажиллах хүчинд орно. Хэрэв үгүй бол ажиллах хүчинд тооцогдохгүй. 2002-2003 онд сүүлийн долоо хоногт ажил эрхэлсэн эсэх талаар асууж байсан бол энэ удаа сүүлийн нэг жилийн хугацааг сонгосон нь ихээхэн ялгаа үүсгэж байна.

## Хүснэгт 2.8 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн ажиллах хүчний оролцооны байдлаар

| | Улсын дундаж | Ажилтай | | | | | Ажилгүй | Ажиллах хүчнээс гадуур | Бусад |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт | Хөдөө аж ахуй | Аж үйлдвэр | Үйлчилгээ | Бусад | | | |
| Ядуурлын хамралтын хүрээ | 35.2 | 34.3 | 49.1 | 32.8 | 20.9 | 36.1 | 54.4 | 34.9 | 35.9 |
| | (0.8) | (0.9) | (1.5) | (1.7) | (1.0) | (3.6) | (2.8) | (1.5) | (9.6) |
| Ядуурлын гүнзгийрэлт | 10.1 | 9.4 | 13.7 | 9.3 | 5.3 | 10.8 | 19.6 | 10.7 | 8.8 |
| | (0.3) | (0.3) | (0.5) | (0.6) | (0.3) | (1.5) | (1.4) | (0.6) | (3.2) |
| Ядуурлын мэдрэмж | 4.0 | 3.6 | 5.2 | 3.7 | 2.0 | 4.6 | 9.1 | 4.4 | 3.7 |
| | (0.2) | (0.1) | (0.3) | (0.3) | (0.2) | (0.9) | (0.9) | (0.3) | (1.9) |
| *Нэмэлт үзүүлэлтүүд:* | | | | | | | | | |
| Хүн амын хувийн жин (%) | 100.0 | 75.7 | 28.5 | 14.5 | 30.3 | 2.4 | 4.2 | 19.9 | 0.3 |
| Ядуурлын шугамаас доогуур хүн амын | 100.0 | 73.6 | 39.7 | 13.5 | 18.0 | 2.5 | 6.5 | 19.7 | 0.3 |
| Өрхийн ам бүлийн тоо | 3.9 | 4.0 | 4.0 | 4.1 | 3.9 | 4.2 | 4.1 | 3.5 | 3.4 |
| Хүн ам зүйн ачаалал (%) | 38.9 | 35.4 | 40.0 | 32.5 | 32.2 | 38.6 | 34.1 | 51.4 | 37.2 |
| Хүүхдийн тоо (% өрхийн ам бүлд) | 26.4 | 29.3 | 29.3 | 29.7 | 28.7 | 35.8 | 31.6 | 15.6 | 30.5 |
| Өрхийн тэргүүлэгчийн нас | 44.9 | 41.0 | 42.2 | 39.8 | 40.6 | 39.3 | 38.6 | 58.8 | 43.2 |
| Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%) | 78.0 | 83.3 | 89.1 | 87.1 | 77.6 | 63.9 | 86.0 | 59.4 | 54.2 |

*Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав*

*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-2008*

Ядуурал болон ажил эрхлэлтийн хамаарлыг өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн салбараар нь нарийвчлан судалж болно. Хүснэгт 2.9-д өрхийн тэргүүлэгчийг мал маллadag, хувийн салбар, төсвийн байгууллага, мөн төрийн өмчийн аж ахуйн нэгжид ажилладагаар нь ялган харуулав[25]. **Т**үүнчлэн ажиллах хүчнээс гадуур байгаа хүн амыг тэтгэвэр авагч болон бусад гэж ангилсан. Энэ хүснэгтээс дараах дүгнэлтүүдийг хийж болно. Нэгдүгээрт, өрхийн тэргүүлэгч нь бусад салбарт ажиллаж байгаа өрхүүдтэй харьцуулахад мал аж ахуй эрхэлдэг тэргүүлэгчтэй өрх ядууралд илүү их өртсөн байна. Хоёрдугаарт, төрийн болон төсвийн байгууллага ялангуяа төрийн өмчийн аж ахуйн газарт ажиллаж байгаа тэргүүлэгчтэй өрхүүдийн амьжиргааны түвшин илүү сайн байна. Эдгээр өрхүүдэд нийт хүн амын 15 хувь нь амьдарч байна. Гуравдугаарт, өрхийн тэргүүлэгч нь хувийн хэвшилд ажиллаж байгаа өрхүүдийн амьжиргааны түвшин дээрх хоёрын дунд нь байгаа боловч улсын салбарт ажиллагчдаас илүү мал аж ахуй эрхлэгчдийн амьжиргааны түвшинтэй ойр байна.

[25] Улсын үйлдвэрийн газруудын ихэнх нь тээвэр, уул уурхай, эрчим хүч, ахуйн үйлчилгээ зэрэг цөөхөн салбарт үйл ажиллагаа явуулж байна.

## Хүснэгт 2.9 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн салбараар

| | Улсын хэмжээгээр | Ажил эрхэлдэг | | | | | Ажил эрхлээгүй | Ажилах хүчнээс гадуур | | Бусад |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Малчин | Хувийн | Улсын | Төрийн өмчит үйлдвэр | Бусад | | Тэтгэмж авагч | Бусад | |
| Ядуурлын хамралтын хүрээ | 35.2 | 49.0 | 29.2 | 22.4 | 14.6 | 44.6 | 54.4 | 32.0 | 43.7 | 35.9 |
| | (0.8) | (1.6) | (1.1) | (1.6) | (2.3) | (4.2) | (2.8) | (1.6) | (2.7) | (9.6) |
| Ядуурлын гүнзгийрэлт | 10.1 | 13.4 | 8.0 | 5.7 | 4.5 | 15.0 | 19.6 | 9.4 | 14.9 | 8.8 |
| | (0.3) | (0.6) | (0.4) | (0.6) | (0.9) | (2.0) | (1.4) | (0.6) | (1.2) | (3.2) |
| Ядуурлын мэдрэмж | 4.0 | 5.0 | 3.1 | 2.1 | 1.9 | 7.0 | 9.1 | 3.7 | 6.8 | 3.7 |
| | (0.2) | (0.3) | (0.2) | (0.3) | (0.5) | (1.3) | (0.9) | (0.3) | (0.7) | (1.9) |
| *Нэмэлт үзүүлэлтүүд:* | | | | | | | | | | |
| Хүн амын хувийн жин (%) | 100.0 | 24.4 | 34.7 | 11.4 | 3.4 | 1.8 | 4.2 | 14.9 | 5.0 | 0.3 |
| Ядуурлын шугамаас доогуур хүн | 100.0 | 34.0 | 28.8 | 7.3 | 1.4 | 2.2 | 6.5 | 13.5 | 6.2 | 0.3 |
| Өрхийн ам бүлийн тоо | 3.9 | 3.9 | 4.1 | 3.9 | 3.9 | 3.7 | 4.1 | 3.3 | 4.0 | 3.4 |
| Хүн ам зүйн ачаалал (%) | 38.9 | 40.8 | 33.0 | 30.7 | 32.2 | 42.4 | 34.1 | 58.3 | 25.9 | 37.2 |
| Хүүхдийн тоо (% өрхийн ам бүл | 26.4 | 29.6 | 29.8 | 26.9 | 28.6 | 34.3 | 31.6 | 13.7 | 22.9 | 30.5 |
| Өрхийн тэргүүлэгчийн нас | 44.9 | 42.0 | 39.9 | 42.3 | 41.0 | 40.3 | 38.6 | 63.6 | 41.1 | 43.2 |
| Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%) | 78.0 | 89.5 | 82.4 | 75.0 | 90.1 | 56.2 | 86.0 | 55.2 | 74.7 | 54.2 |

*Санамж: Тэтгэмж авагч гэдэгт төрөөс ямарваа төрлийн тэтгэвэр, тэтгэмж авч байгаа бүх өрхийн тэргүүлэгчийнг хамрууллаа.*

*Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав*

*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-2008*

Дөрөвдүгээрт, өрхийн тэргүүлэгч нь ажил эрхлээгүй өрхүүдийн хувьд ядууралд өртөх магадлал 50 хувиас их байна. Гэхдээ тэд нийт ядуучуудын 7 хүрэхгүй хувийг эзэлж байна. Тавдугаарт, дээрх өрхүүдээс маш ялгаатай хоёр бүлэг байгаа нь өрхийн тэргүүлэгч нь хөдөлмөрийн зах зээлд оролцоогүй өрхүүд (тэтгэвэр авагчид ба тэтгэвэр авдаггүй хүмүүс) юм. Энэ хоёр бүлгийн хувьд өрхийн тэргүүлэгч нь тэтгэвэр авдаг өрхүүдийн ядууралд хамрагдах магадлал нь тэтгэвэр авдаггүй өрхүүдтэй харьцуулахад бага буюу тус бүр 32 хувь, 44 хувь байна. Гэвч өрхийн тэргүүлэгч нь тэтгэвэр авдаг бүлэг ядуучуудын илүү өндөр хувь буюу 14 хувийг бүрдүүлж байхад нөгөө бүлэг нь дөнгөж 6 хувийг бүрдүүлж байна. Зургаадугаарт, хүн ам зүйн үзүүлэлт нь зарим сонирхолтой мэдээллийг өгч байна. Тэтгэвэр авагчид нь бусад бүлгүүдтэй харьцуулахад ганцаараа онцгойрч байна. Жишээ нь өрхийн тэргүүлэгчийнх нь дундаж нас бусад бүлгүүдийнхээс нэлээн өндөр, харин өрхийн ам бүлийн тоо, хүүхдийн тоо нь нэлээн бага байна. Мөн ийм өрхүүдийн дунд эмэгтэй тэргүүлэгчтэй байх магадлал хамгийн өндөр байгаа сонирхолтой үр дүн байна.

### 2.4.5 Шилжих хөдөлгөөний байдал

Хүмүүс ажил эрхлэх боломж хайж, гэрлэлт, зах зээлд болон төрөл төрөгсөдтэйгээ ойр амьдрах зэрэг голлох шалтгаануудаар өөр нутаг оронд шилжин суурьшсаар байгаа тул шилжилт хөдөлгөөний далайц буураагүй байна. Өрхийн судалгаагаар бараг таван хүн тутмын хоёр нь шилжин суурьшсан өрхийн тэргүүлэгчтэй өрхөд амьдарч байгаа бөгөөд байршлаар тооцож үзэхэд энэ хувь хэмжээ нь хотын хүн амын тэн хагас, харин хөдөөгийн хүн амын тавны нэгтэй тэнцэж байна.[26] Ядуурал, шилжих хөдөлгөөн хоёрын хооронд ямар хамаарал байна вэ? Шилжин суурьшигч тэргүүлэгчтэй өрхүүдийн дунд ядуурал шилжин суурьшигч бус тэргүүлэгчтэй өрхүүдийнхээс бага буюу тус бүр 28 хувь, 40 хувь байна. (Хүснэгт 2.10 ) Энэ дүр зураг хөдөөд мөн адилхан байгаа боловч харин хотод шилжин суурьшигч өрхийн тэргүүлэгчтэй байх нь ядуурлын байдалд онц нөлөөлөхгүй байна. Шилжин суурьшигчид хаана нутаглаж байна вэ? Шилжин суурьшигчид нь хот сууринд голлон амьдарч байгаа буюу тавны дөрөв нь хотод амьдарч байна. Үүнтэй адилаар ядуучуудын гуравны нэг нь шилжин суурьшигч өрхийн тэргүүлэгчтэй байгаа бөгөөд үүнээс дөрөвний гурав нь хотод байна. Эцэст нь шилжин суурьшигч өрхийн тэргүүлэгч нь шилжин суурьшигч бус өрхийн тэргүүлэгчээс ялангуяа, хотод насаар ахимаг бөгөөд мөн эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байх магадлал хөдөөд шилжин суурьшигч тэргүүлэгчтэй өрхүүдэд илүү байна.

[26] Энэ тодорхойлолт одоогийн амьдарч байгаа сумаас өөр сумд төрсөн, төрсөн сумаасаа шилжин яваад буцаж шилжиж ирсэн хүн амыг оруулна. Энэ тоо нь 2002-2003 онд 12.3 хувь гэж гарч байснаас үлэмж өссөн байна. Судалгааны түүвэрлэлтэнд ашигладаг өрхийн жагсаалтыг илүү нарийн, оновчтой бэлдэж улмаар орон нутгийн засаг захиргаанаас тогтмол шинэчилж, ҮСХ-ноос хянаж байдаг болсонтой энэ зөрөө холбоотой болов уу.

**Хүснэгт 2.10** Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өрхийн тэргүүлэгчийн шилжин суурьшсан байдлаар

| | Улсын дундаж | | Хот | | Хөдөө | |
|---|---|---|---|---|---|---|
| | Шилжин суурьшигч биш | Шилжин суурьшигч | Шилжин суурьшигч биш | Шилжин суурьшигч | Шилжин суурьшигч биш | Шилжин суурьшигч |
| Ядуурлын хамралтын хүрээ | 40.1 | 27.8 | 27.6 | 26.3 | 49.4 | 33.9 |
| | (1.0) | (1.2) | (1.4) | (1.3) | (1.3) | (2.3) |
| Ядуурлын гүнзгийрэлт | 11.7 | 7.7 | 8.0 | 7.4 | 14.4 | 9.1 |
| | (0.4) | (0.4) | (0.5) | (0.5) | (0.5) | (0.8) |
| Ядуурлын мэдрэмж | 4.6 | 3.1 | 3.3 | 2.9 | 5.6 | 3.5 |
| | (0.2) | (0.2) | (0.3) | (0.2) | (0.3) | (0.4) |
| *Нэмэлт үзүүлэлтүүд:* | | | | | | |
| Хүн амын хувийн жин (%) | 60.6 | 39.4 | 44.9 | 55.1 | 81.8 | 18.2 |
| Ядуурлын шугамаас доогуур хүн | 68.9 | 31.1 | 46.2 | 53.8 | 86.7 | 13.3 |
| Өрхийн ам бүлийн тоо | 3.9 | 3.9 | 3.8 | 3.9 | 3.9 | 3.8 |
| Хүн ам зүйн ачаалал (%) | 38.2 | 40.0 | 34.0 | 40.3 | 41.3 | 38.7 |
| Хүүхдийн тоо (% өрхийн ам бү. | 27.5 | 24.6 | 25.6 | 24.6 | 29.0 | 24.8 |
| Өрхийн тэргүүлэгчийн нас | 43.2 | 47.4 | 43.2 | 47.8 | 43.3 | 45.9 |
| Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%) | 79.9 | 75.1 | 73.5 | 73.9 | 84.7 | 79.8 |

*Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав*

*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-2008*

## 2.5 Хөрөнгө

Хөрөнгө өмчлөлийн байдал нь хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлох бас нэг чухал хүчин зүйл билээ. Хөрөнгийн чадавхитай байх нь айл өрхийн эдийн засгийн тогтворгүй байдал, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дэх улирлын өөрчлөлт, нөлөөллийг арилгах боломжийг олгоно. Хэрэв өрхийн үндсэн орлого ологч нь гэнэт ажилгүй болох, цас зуд, ган гачиг, усны үер зэрэг байгалийн гэнэтийн гамшиг тохиолдох зэрэг эрсдэлд орох үед өрхийн хэрэглээгээ хангахын тулд өрх нь хөрөнгөө ашигладаг. Жишээлбэл, малаа нядалж зарах, эсвэл хадгаламжнаас мөнгөө авах зэрэг алхамууд хийж болох юм. Үндсэн хөрөнгө нь ерөнхийдөө зээлийн зах зээлд оролцоход маш чухал үүрэгтэй. Тиймээс баялгийн энэ үзүүлэлтийг тухайн өрхийг эрсдэлд өртөхөөс хамгаалдаг даатгал гэж ойлгож болох юм. Энд мал, газар, санхүүгийн гэсэн гурван төрлийн хөрөнгийн талаар авч үзье.

### 2.5.1 Мал

Монголд мал сүрэг нь айл өрхүүдийн амин чухал хөрөнгө мөн хөдөө аж ахуйн салбарын үндсэн үйлдвэрлэл болдог давхар ач холбогдолтой . Ажил эрхэлдэг таван хүн тутмын хамгийн багадаа хоёр нь мал маллах болон түүнтэй холбоотой хөдөлмөр эрхэлж байна. Таван хошуу малын төрөл тус бүр нь өрхийн амьжиргаанд өөр өөр дэмжлэг, боломжийг олгодог. Ямаатай байвал ноолуурын бизнест оролцох, хонь эсвэл тэмээтэй байх нь ноосны худалдаа хийх, үхэр, адуутай байх нь мах, сүү, цагаан идээ боловсруулах гэх мэт боломжуудыг бий болгодог.

Малтай өрхийг таван хошуу малын төрөл болон хот хөдөөгөөр Хүснэгт 2.11-д харуулав. Арван хүн тутмын бараг дөрөв нь малтай байна. Хүн амын ойролцоогоор дөрөвний нэгээс гуравны нэг орчим нь үхэр, адуу, ямаа, хоньтой байхад хорины нэг хүрэхгүй нь тэмээтэй байна. Энэ байдал байршлаар өөр өөр байх ба хотын хүн амын 10 хүрэхгүй хувь нь малтай байхад хөдөөгийн хүн амын бараг дөрөвний гурав нь малтай байна. Улаанбаатарт малтай өрхийн тоо хамгийн цөөн буюу 3 хувь ч хүрэхгүй байна. Харин хөдөө нутагт хүн амын бараг 90 орчим хувь нь ямар нэг төрлийн малтай байна. Малтай өрхийг бүс нутгаар нь хувааж үзэхэд ийм эрс ялгаа байхгүй бөгөөд Баруун бүсэд малтай хүмүүсийн эзлэх хувь хэмжээ хамгийн өндөр, хонь, ямаатай хүмүүсийн эзлэх хувь хэмжээ бүр өндөр байна. Эдгээр нь 2002-2003 оны байдалтай тун ойролцоо байгаа бөгөөд гэхдээ малын өмчлөл Баруун бүсэд 54 хувиас 70 хувь болж нэлээн нэмэгдсэн байхад харин Зүүн бүсэд 54 хувиас 47 хувь болж буурчээ.

Малчдын дунд *бод*-од шилжүүлснээр нэг хүнд ногдох малын тоо 10 бод буюу 10 адуутай тэнцүү байна. [27] (Хүснэгт 2.11) 2002-2003 онд малтай хүмүүсийн хувийн жин манай судалгааны үеийнхтэй адилхан байсан боловч харин малын дундаж тоо нь 7 бод байсантай харьцуулахад их ахиц гарчээ. Хөдөөд малтай нэг хүнд ногдох малын дундаж тоо хотынхоос хоёр дахин их байгаа нь зүй ёсны хэрэг юм. Суурьшлуудаар бол тухайн суурьшил хөдөөгийнх байх тусам малын дундаж тоо их болж байна. Бүсээр бол Зүүн бүсэд нэг хүнд ногдох малын тоо хамгийн их байгаа бөгөөд энэ бүс нутагт үхэр, адуутай хүний хувь хэмжээ их байгаа нь үүнд ямар нэг хэмжээгээр нөлөөлж байна. Энэ бүс нутаг нь өргөн уудам тал нутаг, өвс ногоо ихтэй бэлчээртэй учир мал маллахад хамгийн тохиромжтой билээ. Нөгөө талаас, Баруун бүсэд таван хошуу мал тус бүрийн өмчлөлийн хэмжээ буюу малтай хүний хувийн жин хамгийн их боловч малтай нэг хүнд ногдох малын тоо хамгийн бага байна. Эцэст нь ядуу бус хүмүүсийг бодвол олон ядуу хүн мал маллаж байгаа ч тэдний өмчилж байгаа малын дундаж тоо нь ядуу бус хүмүүсийн малын дундаж тооноос хамаагүй цөөн байна. Малын бүх төрөл тус бүрт дээрхитэй төстэй дүр зураг ажиглагдаж байна.

[27] Малын тоог нэгтгэн тоолохын тулд бодод шилжүүлэх коэффициентийг хэрэглэв. Малын тоог бодод шилжүүлэх коэффицент: 1 бод=1 адуу = 1 үхэр = 0.67 тэмээ = 6 хонь = 8 ямаа

## Хүснэгт 2.1 Мал аж ахуй эрхлэлт

| | Үхэр | | Адуу | | Тэмээ | | Хонь | | Ямаа | | Бод | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Малчид (%) | Малын дундаж тоо | Малчид (%) | Малын дундаж тоо | Малчид (%) | Малын дундаж тоо | Малчид (%) | Малын дундаж тоо | Малчид (%) | Малын дундаж тоо | Малчид (%) | Малын дундаж тоо |
| Улсын дундаж | 28.8 | 3.3 | 26.0 | 3.3 | 4.1 | 1.4 | 30.8 | 21.0 | 33.2 | 19.5 | 37.2 | 10.2 |
| Хот | 5.5 | 2.7 | 3.5 | 2.9 | 0.2 | 1.7 | 5.0 | 15.3 | 5.7 | 15.4 | 8.2 | 6.0 |
| Хөдөө | 60.5 | 3.4 | 56.6 | 3.3 | 9.4 | 1.4 | 65.8 | 21.6 | 70.6 | 19.9 | 76.5 | 10.8 |
| Улаанбаатар | 2.4 | 3.1 | 0.8 | 5.4 | 0.0 | 5.0 | 0.9 | 17.3 | 1.0 | 13.1 | 2.8 | 5.6 |
| Аймгийн төв | 10.5 | 2.5 | 7.9 | 2.5 | 0.5 | 1.7 | 11.6 | 15.1 | 13.3 | 15.7 | 17.0 | 6.1 |
| Сумын төв | 40.6 | 2.7 | 30.5 | 2.5 | 2.0 | 1.1 | 39.4 | 12.6 | 45.4 | 12.8 | 54.2 | 6.4 |
| Хөдөө нутаг | 74.3 | 3.7 | 74.6 | 3.6 | 14.5 | 1.5 | 84.0 | 24.5 | 88.0 | 22.5 | 92.0 | 12.6 |
| Баруун | 52.2 | 2.3 | 47.3 | 2.0 | 10.0 | 0.9 | 59.5 | 18.7 | 66.8 | 21.6 | 70.2 | 8.4 |
| Хангай | 49.1 | 4.0 | 45.8 | 3.3 | 2.4 | 1.8 | 52.9 | 21.1 | 55.3 | 16.2 | 59.8 | 10.9 |
| Төв а/ | 27.6 | 3.4 | 24.9 | 4.3 | 6.3 | 2.6 | 31.8 | 24.3 | 34.3 | 24.6 | 41.8 | 11.0 |
| Зүүн | 42.5 | 3.9 | 39.5 | 5.1 | 10.3 | 0.9 | 38.5 | 23.4 | 41.2 | 16.8 | 47.1 | 13.1 |
| Ядуу бус | 24.6 | 4.0 | 22.4 | 4.1 | 3.8 | 1.7 | 26.4 | 26.7 | 28.0 | 24.4 | 31.7 | 12.7 |
| Ядуу | 36.6 | 2.6 | 32.7 | 2.2 | 4.6 | 1.0 | 38.7 | 14.0 | 42.9 | 13.6 | 47.3 | 7.1 |

*а/ Улаанбаатар хотыг оруулаагүй.*

*Санамж: Малын тоог бодод шилжүүлсэн. Ингэхэдээ малыг адуутай адилтгаж тооцдог.*

*Нэг бод нь нэг адуу, нэг үхэр, 0.67 тэмээ, 6 хонь, буюу 8 ямаатай тэнцүү гэж тооцдог. Сарлагийг үхэрт тооцсон.*

Мал аж ахуй эрхлэлт, амьжиргааны түвшний хооронд ямар хамаарал байна вэ? Хүснэгт 2.12-т ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг мал аж ахуй эрхэлдэг өрхүүдээр, хот хөдөөгөөр, малын төрөл бүр дээр харьцуулж харуулав. Мал аж ахуй эрхлэлтийн байдал хот, хөдөөгөөр маш ялгаатай байна. Хот, суурин газарт мал аж ахуй эрхэлж байгаа өрх ядуурал д өртөх нь өндөр байгаа нь хот, суурин газарт зөвхөн хөдөө аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх нь хангалттай биш бөгөөд өрхүүд амьжиргаагаа дээшлүүлэхийн тулд олон төрлийн үйл ажиллагааг зэрэг эрхлэх хэрэгтэйг харуулж байна.

Харин мал аж ахуй эрхлэх нь хөдөөгийн хүн амын аж байдлын түвшинг нэмэгдүүлж байгаа ба мал аж ахуй эрхэлж байгаа хүн амыг малгүй хүн амтай харьцуулахад ядуурлын хамралтын хүрээ ойролцоо боловч, ядуурлын гүнзгийрэлт, ядуурлын мэдрэмж хоёр бага байна. Бүс нутгуудын хувьд Зүүн ба Төвийн бүсийн малчдын амьжиргааны түвшин нь мал малладаггүй хүн амынхаас өндөр байгаа бөгөөд үүнээс Зүүн бүсийн малчдын ядуурлын хамралтын хүрээ нь мал малладаггүй хүн амынхаас анхаарал татахуйц бага байна. Харин Хангайн болон Баруун бүс хоёрт мал малладаггүй хүн амын ядуурлын хамралтын хүрээ нь бага байгаа бөгөөд Хангайн бүсэд бүр нэлээн бага байна.

## Хүснэгт 2.2 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, мал аж ахуй эрхлэлтийн байдлаар

| | Улсын дундаж | | Хот | | Хөдөө | |
|---|---|---|---|---|---|---|
| | Малчин | Малчин бус | Малчин | Малчин бус | Малчин | Малчин бус |
| Ядуурлын хамралтын хүрээ | 29.6 | 44.8 | 26.4 | 31.7 | 46.2 | 46.7 |
| | (1.0) | (1.3) | (1.1) | (3.0) | (2.1) | (1.4) |
| Ядуурлын гүнзгийрэлт | 8.8 | 12.3 | 7.6 | 8.0 | 15.0 | 12.9 |
| | (0.4) | (0.5) | (0.4) | (0.9) | (0.8) | (0.5) |
| Ядуурлын мэдрэмж | 3.7 | 4.6 | 3.1 | 2.8 | 6.5 | 4.8 |
| | (0.2) | (0.2) | (0.2) | (0.4) | (0.4) | (0.3) |
| *Тэмдэглэл:* | | | | | | |
| Хүн амын хувийн жин (%) | 62.8 | 37.2 | 91.8 | 8.2 | 23.5 | 76.5 |
| Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (% | 52.7 | 47.3 | 90.3 | 9.7 | 23.3 | 76.7 |
| Өрхийн ам бүлийн тоо | 3.8 | 4.0 | 3.9 | 4.1 | 3.6 | 4.0 |
| Хүн ам зүйн ачаалал (%) | 37.2 | 41.8 | 36.9 | 43.6 | 38.5 | 41.6 |
| Хүүхдийн тоо (% өрхийн ам бүлд) | 25.0 | 28.9 | 24.9 | 27.2 | 25.6 | 29.1 |
| Өрхийн тэргүүлэгчийн нас | 45.3 | 44.0 | 45.5 | 47.5 | 44.4 | 43.5 |
| Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%) | 73.2 | 86.4 | 72.9 | 83.6 | 74.8 | 86.8 |

*Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав*

*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-2008*

Эндээс бид хөдөөд мал аж ахуй эрхлэх нь ядуурлаас хамгаалж чадахгүй байна гэсэн дүгнэлт хийж болно. 2002-2003 онд хөдөөгийн малчдын дунд ядуурлын хамралтын хүрээ нь хөдөөгийн мал малладаггүй хүмүүсийнхээс үлэмж бага байсан нь энэ судалгаагаагаар өөрчлөгдсөн үр дүн гарч байна. Малын тоо толгойн нөлөө хэр байна вэ? Зураг 2.2-т нэг малчинд ногдох малын тооноос ядуурлын хамралтын хүрээ хэрхэн хамаарч байгааг харуулав. Хот, хөдөө аль алинд нь малтай нэг хүнд ногдох малын тоо өсөхөд ядуурлын хамралтын хүрээ буурч байгаа нь харагдаж байна. Хэдийгээр хот, хөдөө аль алинд нь малтай өрхүүдийн амьжиргаа нь малгүй өрхүүдийнхөөс дээгүүр байгаа бөгөөд малтай өрхүүдийнхээ дунд бол малын тоо олон байх тусам амьжиргааны түвшин нь сайжирч байна. Олон малтай байх тусам бүтээмж дээшлэх бөгөөд, мөн аль болох олон төрлийн үйл ажиллагаа явуулснаар зөвхөн тодорхой нэг төрлийн үйл ажиллагаан дээр түшиглэхэд зарим төрлийн сөрөг үзэгдэл, нөлөөллүүдийн учруулах хохирол их байдгаас сэргийлэх боломжтой болдог гэсэн нэг тайлбар нэлээн үндэслэлтэй. Малчдын 75 хувь нь доод тал нь (5 хошуу малын) гурван төрлийн малтай байгаа бодит байдлаас энэ таамаглалыг дэвшүүлж байна.[28]

**Зураг 2.2: Ядуурал ба малын тоо**




*Санамж: Жигнээгүй үр дүн.*
*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-2008.*

---

[28] **Өөр нэг байж болох нөхцөл бол хэрэв өрх зөвхөн 1-2 төрлийн мал бүхий сүрэгтэй байх нь тэдэнд эдгээр үйл ажиллагаанд мэргэших болон үйлдвэрлэлийн процесст эдийн засгийн тодорхой түвшинд хүрэх боломжийг олгодог.**

## 2.5.2 Газар

Газар нь өрхүүдийн, ялангуяа хөдөө аж ахуй эрхэлдэг өрхүүдийн хувьд хамгийн чухал хөрөнгийн нэг юм. Гэхдээ Монголд газар тариалан хязгаарлагдмал хөгжсөн учир мал аж ахуйтай харьцуулбал ач холбогдол багатай. Газар тариалан муу хөгжсөний шалтгаан болсон цөөн хэдэн хүчин зүйл бий. Нэгдүгээрт, уур амьсгалын эрс тэс нөхцөлд газар тариалан эрхлэхэд тохиромжгүй, цаг агаарын хүндрэл үүсэхэд ургац алдах болдог. Хоёрдугаарт, хөрсний чанар муу, нийт газрын тун бага хувийг усжуулсан учраас бүтээмжид сөргөөр нөлөөлдөг, Гуравдугаарт, газар тариаланд мал аж ахуйг бодвол хөдөлмөр, капитал аль алинд нь илүү их хөрөнгө шаарддаг байж болох талтай. Дөрөвдүгээрт,  өрхүүд газар тараиаланг мал аж ахуй шиг уламжлан эрхэлж байгаагүй, саяхныг хүртэл газар тариалангийн үйл ажиллагаа бараг бүхэлдээ  нь улсын хэвшилд хамаардаг байсан. Тавдугаарт, уламжлалт аргаар мал маллахад зайлшгүй нүүдэллэн амьдрах болдог тул газар тариалан эрхлэхэд тохиромжгүй байдаг.

Өрхийн судалгааны дүнгээр арван хүн тутмын нэг нь тариалангийн газар өмчилдөг буюу эсвэл тариалангийн зорилгоор газар ашигладаг өрхөд амьдарч байна. Хот, хөдөөд энэ үзүүлэлт ойролцоо байна. Хэдийгээр улсын хэмжээгээр бол газар эзэмшигч нь газар эзэмшдэггүй хүмүүсээс амьжиргаа доогуур байгаа хэдий ч хот, хөдөөд аль алинд нь газар өмчлөх буюу эзэмших нь ядуурлын хамралтын хүрээнд нөлөөлж байна гэж хэлэх үндэслэл харагдахгүй байна. Газар өмчлөгч таван хүн тутмын дөрөв нь газраа бүгдийг нь буюу зарим хэсгийг тариа, ногоо тарихад ашиглаж байгаа буюу газар өмчлөгчдийн дийлэнх  нь газраа үр ашигтайгаар ашиглаж байна. Эцэст нь тэмдэглэхэдэ ядуу хүн газар тариалангийн ажил эрхлэх магадлал нь ядуу биш хүнийхээс бага зэрэг их буюу тус бүр 9.6 хувь, 7.5 хувь байна.

### Хүснэгт 2.3 Ядуурал ба газар өмчлөл

| | Улсын дундаж | | Хот | | Хөдөө | |
|---|---|---|---|---|---|---|
| | Газаргүй | Газартай | Газаргүй | Газартай | Газаргүй | Газартай |
| Ядуурлын хамралтын хүрээ | 34.7 | 41.1 | 26.9 | 27.0 | 46.3 | 48.1 |
| | (0.8) | (2.5) | (1.1) | (3.8) | (1.3) | (3.0) |
| Ядуурлын гүнзгийрэлт | 10.0 | 11.7 | 7.6 | 8.3 | 13.4 | 13.4 |
| | (0.3) | (0.9) | (0.4) | (1.4) | (0.5) | (1.1) |
| Ядуурлын мэдрэмж | 3.9 | 4.6 | 3.1 | 3.4 | 5.2 | 5.2 |
| | (0.2) | (0.4) | (0.2) | (0.7) | (0.2) | (0.6) |
| *Нэмэлт үзүүлэлтүүд:* | | | | | | |
| Хүн амын хувийн жин (%) | 91.8 | 8.2 | 95.2 | 4.8 | 87.1 | 12.9 |
| Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%) | 90.4 | 9.6 | 95.2 | 4.8 | 86.7 | 13.3 |
| Өрхийн ам бүлийн тоо | 3.8 | 4.4 | 3.9 | 4.3 | 3.8 | 4.4 |
| Хүн ам зүйн ачаалал (%) | 38.9 | 38.2 | 37.4 | 38.3 | 41.1 | 38.2 |
| Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх хувийн жин) | 26.3 | 27.6 | 25.1 | 24.4 | 28.1 | 29.2 |
| Өрхийн тэргүүлэгчийн нас | 44.9 | 44.9 | 45.6 | 47.3 | 43.8 | 43.6 |
| Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%) | 77.5 | 84.9 | 73.4 | 80.6 | 83.4 | 87.1 |

*Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав*

*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-2008*

### 2.5.3 Санхүүгийн хөрөнгө

Өрхийн баялгийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь санхүүгийн хөрөнгө билээ. Хэрэв орлого нь зарлагаа давж байвал хүмүүс хадгаламж хуримтлуулдаг, харин өдөр тутмын хэрэгцээнд дөнгөж хүрэлцэх төдий орлоготой бол хадгаламж үүсэхгүй нь тодорхой, Монголын хүн амын дөрөвний нэг нь санхүүгийн байгууллагад мөнгөн хадгаламжтай өрхөд амьдарч байна.[29] 2002-2003 онд 7 хувь байсныг бодвол энэ үзүүлэлт ихээхэн өссөн байна.[30] Санхүүгийн идэвхи ингэж сайжирсанд олон шалтгаан байгаагийн дотор 2003 онд шинэ хууль батлагдсанаар иргэдээс хадгаламж авах эрхтэй санхүүгийн байгууллага олноор үүсэн бий болсон ( Жишээлбэл хадгаламж, зээлийн хоршоод), банкууд олон салбар нээж олон төрлийн санхүүгийн үйлчилгээ санал болгох болсон, нийгмийн халамж, тэтгэлгийн мөнгийг шууд дансанд хүлээн авах бололцоотой болсны зэрэгцээ хүн амын зарим хэсгийн аж байдал сайжирч хадгаламж хуримтлуулах чадвартай болсон зэргийг дурдаж болно.

Хот сууринд хүн амын дөрөвнйи нэг нь хадгаламжтай бол хөдөөд энэ үзүүлэлт буурч тавны нэг болж байна. Хүснэгт 2.14-д үзүүлсэн мэдээллээс хадгаламжтай байх, ядуурлын хамралтын хүрээ хоёр хүчтэй урвуу хамааралтай байгаа нь маш тодорхой харагдаж байгаа бөгөөд ялангуяа Улаанбаатар болон аймгийн төвүүдэд хадгаламж эзэмшигчдийн ядуурлын хамралтын хүрээ нь хадгаламжгүй хүмүүсийнхээс гурав дахин бага байна. Сумын төв болон хөдөө нутагт, арван хадгаламж эзэмшигч тутмын гурав нь харин хадгаламжгүй хүмүүсийн тэн хагас нь ядуу байна. Ядуурлын өөр 2 хэмжүүрийг харьцуулж үзэхэд энэ нийтлэг дүр зураг улам тодорхой болж байна. Эцэст нь, ядуучууд, ядуу бус хүмүүсийг бодвол санхүүгийн системийг бага ашигладаг байна ( тус бүр 13 хувь, 31 хувь)

---

[29] Өрхийн судалгаагаар өрхүүдээс мөнгөн хадгаламжийнх нь төрлийг асуудаггүй, гэхдээ өрхүүд хадгаламжийн тухай хариулахадаа банканд болон хадгаламж зээлийн хоршоонд хадгалуулсан мөнгөө дурдаж байна гэж ойлгох бүрэн үндэслэлтэй. Жишээ нь хуримтлуулсан мөнгөө гэртээ хадгалах нь ховор байдаг.

[30] 2002-2003 оны судалгаанд дээрх үзүүлэлт 12 хувьтай байсан боловч энэ нь нийт хүн ам доторхи хувьцаа эзэмшдэг 5 хувийг агуулсан байсан.

## Хүснэгт 2.4 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, хадгаламж эзэмшсэн байдлаар

| | Улсын дундаж | | Хот | | Хөдөө | |
|---|---|---|---|---|---|---|
| | Хадгаламжтай | Хадгаламжгүй | Хадгаламжтай | Хадгаламжгүй | Хадгаламжтай | Хадгаламжгүй |
| Ядуурлын хамралтын хүрээ | 40.6 | 18.3 | 32.6 | 10.7 | 51.0 | 30.6 |
| | (0.9) | (1.1) | (1.2) | (1.1) | (1.3) | (1.9) |
| Ядуурлын гүнзгийрэлт | 11.9 | 4.5 | 9.5 | 2.6 | 15.0 | 7.7 |
| | (0.3) | (0.3) | (0.5) | (0.4) | (0.5) | (0.6) |
| Ядуурлын мэдрэмж | 4.8 | 1.6 | 3.8 | 0.9 | 6.0 | 2.6 |
| | (0.2) | (0.2) | (0.2) | (0.2) | (0.3) | (0.3) |
| *Нэмэлт үзүүлэлтүүд:* | | | | | | |
| Хүн амын хувийн жин (%) | 75.8 | 24.2 | 74.0 | 26.0 | 78.3 | 21.7 |
| Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%) | 87.4 | 12.6 | 89.6 | 10.4 | 85.7 | 14.3 |
| Өрхийн ам бүлийн тоо | 3.8 | 4.0 | 3.9 | 3.9 | 3.8 | 4.1 |
| Хүн ам зүйн ачаалал (%) | 38.9 | 38.7 | 37.5 | 37.2 | 40.7 | 41.3 |
| Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх хувийн жин) | 25.0 | 30.9 | 23.6 | 29.0 | 26.7 | 34.2 |
| Өрхийн тэргүүлэгчийн нас | 45.6 | 42.4 | 46.6 | 43.3 | 44.5 | 40.8 |
| Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%) | 76.7 | 82.4 | 71.6 | 80.0 | 83.1 | 86.7 |

*Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав*

*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-2008*

## 2.6 Сууц

Эзэмшиж байгаа сууцны төрөл болон дэд бүтцийн үндсэн үйлчилгээнд хамрагдах боломж нь хүн амын амьжиргааны түвшнийг тодорхойлох гол үзүүлэлтийн нэг юм. Өрхийн сууцны нөхцөл, ахуйн үйлчилгээ сайжирснаар өрх, хүн ам нь эмзэг байдлаас гарах улмаар тэдний сонголт хийх боломж нь нэмэгдэж аж байдлаа хурдан дээшлүүлнэ. Дэд бүтцийн хөгжил сайн байх нь өрхийн гишүүдийн бүтээмжийг нэмэгдүүлэх бололцоог олгодог. Тухайлбал дэргэдээсээ эсвэл төвлөрсөн усан хангамжийн системтэй холбогдож ундны шаардлага хангасан усаа авч хэрэглэж байгаа өрх, хүн амыг гэрээсээ хагас цаг гаруй явж хэрэглээний усаа авч байгаа өрх, хүн амтай харьцуулахад мэдээж ахуйн давуутай нөхцөлд амьдарч байгаа юм. Энд өрх, хүн амын сууцны төрөл болон тэдний дэд бүтцийн үндсэн үйлчилгээг хүртэж байгаа байдлын талаар авч үзнэ.

### 2.6.1 Сууцны төрөл

Монгол улсын хүн амын хамгийн нийтлэг хэрэглэдэг сууцны нэг төрөл бол гэр юм. Нийт хүн амын 46 хувь нь гэрт, гуравны нэг нь сууцны тусдаа байшинд, тавны нэг нь нийтийн орон сууцны байшин доторх сууцанд (цаашид, нийтийн тохилог сууц гэнэ) амьдарч байна. Суурьшлаар нь авч үзвэл хотын бараг таван хүн тутмын хоёр нь сууцны тусдаа байшинд, арван хүн тутмын гурав нь нийтийн тохилог сууцанд, мөн арван хүн тутмын гурав нь гэрт амьдарч байна. Харин хөдөөгийн хүн амын гуравны хоёр нь гэрт, дөрөвний нэг нь сууцны тусдаа байшинд, үлдсэн нь нийтийн тохилог сууцанд амьдарч байна. Хүснэгт 2.15-д ядуурал сууцны төрөлтэй ямар хамааралтай байгааг харуулав. Ядуурлын түвшин гэрт амьдран суугчдын дунд харьцангуй өндөр, сууцны тусдаа байшинд амьдрагчдын хувьд үүнээс арай бага, харин нийтийн тохилог сууцанд амьдрагчдын дунд хамгийн бага байна. Хотод ч хөдөөд ч энэ чиг хандлага адил боловч харьцангуй ялгаанууд нь харин эрс ондоо байна.

Жишээ нь, гэрт суугчдын бараг хагас нь хот хөдөөд амьдардгаас үл хамааран ядуу байна. Гэтэл хотод нийтийн тохилог сууцанд амьдрагчдын 7 хувь нь ядуу байхад хөдөөд нийтийн тохилог сууцанд суугчдын 22 хувь нь ядуу байна. Гэрт амьдрагсад илүү ядуу байх хандлагатай буюу таван хүн тутмын гурваас илүү нь ядуу, сууцны тусдаа байшинд амьдрагсдын гуравны нэг, харин сууцны тохилог байранд амьдрагсдын бараг хорины нэг хүрэхгүй шахам нь ядуу байна.

Гэхдээ Улаанбаатар хот болон аймгийн төвд хүн амын 30 хувь нь, харин ядуучуудын тэн хагас нь гэрт амьдарч байхад нитийн тохилог сууцанд аьдардаг хүмүүс яг адилхан гучин хувь болж байгаа ч ядуучуудын дөнгөж 8 хувийг эзэлж байна. Хөдөөд сууцны төрөл тус бүрд ядуучуудын тархалт нь нийт хүн амын тархалттай ойролцоо буюу дөрвөн хүн тутмын гурав нь гэрт, үлдсэн нь байшинд амьдарч байна.

## Хүснэгт 2.5 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, сууцны төрлөөр

| | Улсын дундаж | | | | Хот | | | | Хөдөө | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Гэр | Тохилог сууц | Байшин | Бусад | Гэр | Тохилог сууц | Байшин | Бусад | Гэр | Тохилог сууц | Байшин | Бусад |
| Ядуурлын хамралтын хүрээ | 48.8 | 8.5 | 32.6 | 44.3 | 46.7 | 6.7 | 27.9 | 46.1 | 50.1 | 22.0 | 42.4 | 41.3 |
| | (1.1) | (0.8) | (1.3) | (7.7) | (1.8) | (0.8) | (1.5) | (9.9) | (1.4) | (3.1) | (2.2) | (12.2) |
| Ядуурлын гүнзгийрэлт | 14.6 | 2.2 | 8.6 | 12.9 | 14.2 | 1.9 | 7.4 | 14.7 | 14.8 | 5.0 | 11.4 | 9.6 |
| | (0.4) | (0.3) | (0.4) | (2.7) | (0.7) | (0.3) | (0.5) | (3.6) | (0.6) | (0.9) | (0.7) | (3.8) |
| Ядуурлын мэдрэмж | 5.9 | 0.9 | 3.3 | 4.7 | 5.9 | 0.8 | 2.8 | 5.6 | 5.9 | 1.7 | 4.2 | 3.2 |
| | (0.2) | (0.2) | (0.2) | (1.2) | (0.4) | (0.2) | (0.3) | (1.6) | (0.3) | (0.4) | (0.4) | (1.5) |
| *Нэмэлт үзүүлэлтүүд:* | | | | | | | | | | | | |
| Хүн амын хувийн жин (%) | 45.7 | 20.0 | 33.8 | 0.5 | 28.8 | 30.9 | 39.8 | 0.5 | 68.6 | 5.3 | 25.7 | 0.4 |
| Ядуурлын шугамаас доогуур хүн амын ху | 63.3 | 4.8 | 31.3 | 0.6 | 50.0 | 7.7 | 41.3 | 0.9 | 73.8 | 2.5 | 23.4 | 0.4 |
| Өрхийн ам бүлийн тоо | 3.9 | 3.5 | 4.2 | 3.4 | 4.0 | 3.5 | 4.2 | 3.4 | 3.8 | 3.7 | 4.1 | 3.3 |
| Хүн ам зүйн ачаалал (%) | 41.7 | 35.5 | 37.2 | 34.7 | 40.9 | 35.7 | 36.6 | 31.2 | 42.1 | 34.0 | 38.4 | 40.7 |
| Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх хувийн жин | 28.1 | 23.3 | 26.2 | 25.1 | 27.6 | 22.7 | 25.3 | 23.2 | 28.3 | 27.7 | 28.1 | 28.3 |
| Өрхийн тэргүүлэгчийн нас | 44.2 | 45.1 | 45.6 | 43.3 | 45.4 | 45.5 | 46.1 | 44.4 | 43.6 | 42.1 | 44.6 | 41.3 |
| Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%) | 79.6 | 72.4 | 80.0 | 56.6 | 71.4 | 71.6 | 77.9 | 56.7 | 84.0 | 79.8 | 84.6 | 56.4 |

*Санамж: Бусад сууцанд оюутны дотуур байр, компаний ажилчдын байр болон айл, өрхөд зориулаагүй бусад байшингуудыг оруулав.*

*Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав*

*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-2008*

## 2.6.2 Дэд бүтцийн үйлчилгээ

Сайжруулсан усан хангамж, эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, цахилгаан, эрчим хүч зэрэг дэд бүтцийн үйлчилгээгээр хүн амыг хангаснаар тэдний амьжиргааны түвшин дээшилнэ.[31] Шаардлага хангаагүй усан хангамж болон ариун цэврийн байгууламж нь хүн амын эрүүл мэндэд шууд нөлөөлж, өвчлөл, түүний дэгдэлтийг нэмэгдүүлнэ. Цахилгаан, эрчим хүчний дутагдал нь хүн амын боловсрол, хөрөнгө оруулалтанд сөрөг нөлөө үзүүлнэ. Аж байдлын энэ үзүүлэлт ямар байна вэ?

Ядуурал нь дэд бүтцийн үндсэн үйлчилгээнүүдийн хүртээмжээс хэрхэн хамаарч байгааг Хүснэгт 2.16 ба 2.17-д үзүүлэв. Өрхийн судалгааны дүнгээр есөн хүн тутмын дөрөв нь сайжруулсан усан хангамжтай, есөн хүн тутмын тав нь эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай, дөрвөн хүн тутмын гурав цахилгаан эрчим хүчний хангамжтай бөгөөд нийт хүн амын гуравны нэг нь дээрх гурван үйлчилгээг бүгдийг нь хүртэж байна. Ариун цэврийн байгууламж, цахилгааны хангамж 2002-2003 оныхтой харьцуулахад сайжирсан боловч сайжруулсан усан хангамжийн хүртээмж болон гурван үйлчилгээг бүгдийг нь хүртэж байгаа хүн амын хувь хэмжээний өөрчлөлтийн талаар дүгнэлт хийх боломжгүй байна. Эдгээр үйлчилгээний хүртээмж нь хотод хөдөөгийнхөөс хамаагүй их байна. Жишээ нь хотын хүн амын дөрөвний гурав, хөдөөгийн хүн амын гуравны нэг нь эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай байна. Хотын хүн ам бараг бүгдээрээ цахилгаантай байхад хөдөөд зөвхөн таван хүн тутмын хоёр нь л цахилгаан эрчим хүчний үйлчилгээг авч байна.
.

Энэ хоёр хүснэгтэнд харуулсан мэдээлэл дотор хөдөөд нарны эрчим хүчний хэрэглээ эрс өссөн баримт багтаагүй гэдгийг хэлэх хэрэгтэй. Засгийн газраас малчдыг хямдруулсан үнэ бүхий нарны зайн эх үүсвэрээр хангах бодлого хэрэгжүүлж сүүлийн хэдэн жил ихээхэн амжилт олсон байна. 2002-2003 онд хөдөөгийн хүн амын зөвхөн 4 хувь нь нарны эрчим хүч ашиглаж байсан бол энэ судалгааны дүнгээр 36 хувь болж өсчээ. Хэдийгээр энэ төрлийн эрчим хүч нь цахилгааныг бүрэн орлохгүй хэдий ч одоо хөдөөгийн хүн амын дөрөвний гурав нь нарны эрчим хүч эсвэл цахилгаан, эрчим хүчээр хангагдсан байна. Энэ гурван үндсэн үйлчилгээг бүгдийг нь хотын хүн амын бараг тал хувь нь хүртэж байхад хөдөөд зөвхөн зургааны нэг нь хүртэж байна гэсэн үр дүн манай судалгаанаас гарч байна. Өөр нэг чухал хүчин зүйл буюу үйлчилгээний чанарыг манай судалгаагаар бүрэн хамарч чадсангүй. Хотынхон ерөнхийдөө хөдөөнийнхнөөс илүү чанартай үйлчилгээ хүртэж байна. Жишээ нь хамгаалалттай худаг хүртэл бохирдолд өртөх эрсдэл бий тул гоожуурын ус нь худгийн усаас илүү чанартай гэж үзэж болно.

---

[31]Сайжруулсан усан хангамж гэдэг нь төвлөрсөн усан хангамжинд холбогдсон буюу хамгаалалттай худгаас усаа авч хэрэглэдэг байх (хамгаалалтгүй худаг, гол, булаг, цас мөсний ус хэрэглэдэг бол үүнд орохгүй) гэж тодорхойлсон. Эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламж гэдэг нь хувийн болон дундын /нийтийн бус/ бохир зайлуулах шугам, нүхтэй байхыг хэлнэ. Энэ нь энгийн болон төвлөрсөн бохирын сүлжээ зэрэг байж болно
.

Ус, ариун цэврийн байгууламж, болон цахилгаан зэрэг үйлчилгээг зохих арга замаар хүртэх боломжгүй хүн ам нь тэдгээр үйлчилгээг хүртдэг хүн амаас ядуу байна. Энэ гурван үйлчилгээг бүгдийг нь хүртдэг эсэхээр харьцуулж үзэхэд ялгарал бүр тод харагдаж байгаа буюу гурвууланг нь хүртдэг хүн амын тавны нэг нь ядуу байхад хүртдэггүй хүмүүсийн тавны хоёроос илүү нь ядуу байна. Энэ ерөнхий чиг хандлага хот, хөдөөгийн суурьшилд хоёуланд ажиглагдаж байгаа боловч хөдөөд ялгарал  нь арай бага байна . Өөрөөр хэлбэл дээрх гурван үйлчилгээг бүгдийг нь авдаг эсвэл аль нэгийг нь авдаг хүн амын дунд ядуурлын түвшин нь авдаггүй хүн амынхаас хөдөөг бодвол хотод илүү их буюу нэлээн бага байна.

## Хүснэгт 2.16 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, дэд бүтцийн үйлчилгээний төрлөөр

| | а/ Сайжруулсан усан хангамж | | б/ Ариун цэврийн байгууламж | | Цахилгаан | | Бүгд | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тийм | Үгүй | Тийм | Үгүй | Тийм | Үгүй | Тийм | Үгүй |
| Ядуурлын хамралтын хүрээ | 44.0 | 24.8 | 48.8 | 25.0 | 51.1 | 29.7 | 43.9 | 18.3 |
| | (1.1) | (1.1) | (1.2) | (0.9) | (1.5) | (0.9) | (1.0) | (1.1) |
| Ядуурлын гүнзгийрэлт | 12.6 | 7.1 | 14.4 | 6.8 | 14.8 | 8.5 | 12.7 | 5.0 |
| | (0.4) | (0.4) | (0.5) | (0.3) | (0.6) | (0.3) | (0.4) | (0.4) |
| Ядуурлын мэдрэмж | 4.9 | 2.9 | 5.8 | 2.6 | 5.8 | 3.4 | 5.1 | 1.9 |
| | (0.2) | (0.2) | (0.2) | (0.2) | (0.3) | (0.2) | (0.2) | (0.2) |
| *Нэмэлт үзүүлэлтүүд:* | | | | | | | | |
| Хүн амын хувийн жин (%) | 54.5 | 45.5 | 43.1 | 56.9 | 25.8 | 74.2 | 66.1 | 33.9 |
| Ядуурлын шугамаас доогуур хүн амын | 68.0 | 32.0 | 59.6 | 40.4 | 37.4 | 62.6 | 82.4 | 17.6 |
| Өрхийн ам бүлийн тоо | 4.0 | 3.8 | 3.9 | 3.8 | 3.9 | 3.9 | 4.0 | 3.7 |
| Хүн ам зүйн ачаалал (%) | 40.1 | 37.4 | 40.4 | 37.8 | 41.8 | 37.8 | 40.1 | 36.7 |
| Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх хувийн | 27.3 | 25.4 | 28.2 | 25.1 | 28.6 | 25.6 | 27.4 | 24.6 |
| Өрхийн тэргүүлэгчийн нас | 44.6 | 45.1 | 43.8 | 45.7 | 43.2 | 45.4 | 44.6 | 45.4 |
| Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%) | 80.1 | 75.6 | 81.4 | 75.6 | 85.7 | 75.4 | 79.8 | 74.8 |

*а/ Сайжруулсан усан хангамжтай буюу төвлөрсөн усан хангамж, хамгаалалттай худаг, булаг зэргээс ус алвдаг хүн амын . хувийн жин юм Сайжруулаагүй усан хангамж гэдэгт зөөврийн ус, хамгаалалтгүй худаг, булгийн ус орно.*

*б/ Сувагжуулалт гэдэгт хог гадагшлуулах (хувийн болон нийтийн) бохирын цооног/шугамтай өрхүүдийн хувийн жинг оруулан тооцно Энэ нь сууцны гаднах бие засах газраас эхлээд бохир усны сүлжээнд холбогдсон бие засах газар байж болно.*

*Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав*

*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-2008*

Зураг 2.3-д дэд бүтцийн үйлчилгээний хүртээмжийг хүн амын ядуурлын байдлаар харуулав. Ядуу бус хүн амын дунд ядуучуудыг бодвол сайжруулсан усан хангамж, ариун цэврийн байгууламж болон цахилгаан эрчим хүчний үйлчилгээний хүртээмж илүү байгаа бөгөөд үйлчилгээнүүдийг хамтад нь хүртэж байгаагаар нь нарийвчлан үзвэл ялгарал нь улам нэмэгдэж байна. Дахин хэлэхэд энэ дүр зураг хот, хөдөөд хоёуланд нь ажиглагдаж байна. Гэхдээ ядуу ба ядуу бус хүн амын эдгээр үйлчилгээг хүртэж байгаа байдлын ялгарал нь хөдөөд нэлээн бага байна.

**Зураг 2.3. Дэд бүтцийн үйлчилгээний хүртээмж, ядуурлын байдлаар**



# Хүснэгт 2.6 Дэд бүтцийн үйлчилгээнүүдийн хүртээмж, ядуурлын байдлаар, хот хөдөөгөөр

| | а/ сайжруулсан усан хангамж | | | | б/ Ариун цэврийн байгууламж | | | | Цахилгаан | | | | Бүгд | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хот | | Хөдөө | | Хот | | Хөдөө | | Хот | | Хөдөө | | Хот | | Хөдөө | |
| | Тийм | Үгүй | Тийм | Үгүй | Тийм | Үгүй | Тийм | Үгүй | Тийм | Үгүй | Тийм | Үгүй | Тийм | Үгүй | Тийм | Үгүй |
| Ядуурлын хамралтын хүрээ | 37.7 | 17.7 | 49.8 | 40.1 | 44.4 | 20.4 | 51.2 | 38.0 | 66.3 | 26.4 | 50.7 | 40.6 | 37.7 | 14.3 | 49.5 | 32.7 |
| | (1.6) | (1.3) | (1.4) | (1.8) | (2.1) | (1.1) | (1.5) | (1.7) | (7.0) | (1.1) | (1.6) | (1.7) | (1.5) | (1.2) | (1.3) | (2.2) |
| Ядуурлын гүнзгийрэлт | 10.8 | 5.0 | 14.2 | 11.7 | 13.6 | 5.5 | 14.9 | 10.5 | 24.8 | 7.5 | 14.5 | 11.8 | 10.9 | 3.9 | 14.3 | 8.8 |
| | (0.6) | (0.5) | (0.6) | (0.7) | (0.9) | (0.4) | (0.6) | (0.6) | (4.2) | (0.4) | (0.6) | (0.6) | (0.6) | (0.4) | (0.5) | (0.8) |
| Ядуурлын мэдрэмж | 4.4 | 2.0 | 5.5 | 4.7 | 5.8 | 2.1 | 5.8 | 4.2 | 12.6 | 3.0 | 5.6 | 4.7 | 4.4 | 1.5 | 5.6 | 3.4 |
| | (0.3) | (0.2) | (0.3) | (0.4) | (0.5) | (0.2) | (0.3) | (0.3) | (3.2) | (0.2) | (0.3) | (0.3) | (0.3) | (0.2) | (0.3) | (0.4) |
| *Нэмэлт үзүүлэлт:* | | | | | | | | | | | | | | | | |
| Хүн амын хувийн жин (%) | 45.8 | 54.2 | 66.3 | 33.7 | 26.9 | 73.1 | 65.1 | 34.9 | 1.2 | 98.8 | 59.1 | 40.9 | 53.8 | 46.2 | 82.7 | 17.3 |
| Ядуурлын шугамаас доогуур хү | 64.3 | 35.7 | 70.9 | 29.1 | 44.4 | 55.6 | 71.5 | 28.5 | 3.0 | 97.0 | 64.3 | 35.7 | 75.5 | 24.5 | 87.9 | 12.1 |
| Өрхийн ам бүлийн тоо | 4.1 | 3.7 | 3.9 | 3.8 | 4.2 | 3.8 | 3.8 | 3.9 | 3.7 | 3.9 | 3.9 | 3.9 | 4.1 | 3.7 | 3.9 | 3.9 |
| Хүн ам зүйн ачаалал (%) | 38.5 | 36.6 | 41.6 | 39.2 | 38.7 | 37.0 | 41.2 | 39.9 | 41.1 | 37.4 | 41.9 | 39.2 | 38.5 | 36.4 | 41.4 | 37.7 |
| Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх : | 25.9 | 24.4 | 28.5 | 27.6 | 27.3 | 24.3 | 28.7 | 27.4 | 28.9 | 25.0 | 28.6 | 27.8 | 26.1 | 23.9 | 28.5 | 27.1 |
| Өрхийн тэргүүлэгчийн нас | 46.0 | 45.5 | 43.4 | 44.4 | 45.3 | 45.8 | 43.0 | 45.2 | 43.4 | 45.7 | 43.2 | 44.5 | 45.8 | 45.6 | 43.6 | 44.6 |
| Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%) | 74.1 | 73.5 | 85.5 | 80.4 | 73.6 | 73.8 | 85.4 | 80.8 | 78.2 | 73.7 | 85.9 | 80.8 | 74.1 | 73.4 | 84.5 | 80.3 |

*а/ Сайжруулсан усан хангамжтай буюу төвлөрсөн усан хангамж, хамгаалалттай худаг, булаг зэргээс ус алвдаг хүн амын . хувийн жин юм Сайжруулаагүй усан хангамж гэдэгт зөөврийн ус, хамгаалалтгүй худаг, булгийн ус орно.*

*б/ Сувагжуулалт гэдэгт хог гадагшлуулах (хувийн болон нийтийн) бохирын цооног/шугамтай өрхүүдийн хувийн жинг оруулан тооцно Энэ нь сууцны гаднах бие засах газраас эхлээд бохир усны сүлжээнд холбогдсон бие засах газар байж болно.*

*Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав*

*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-2008*

## 2.7 Нийгмийн Хамгаалал

Нийгмийн хамгаалал нь эдийн засгийн тогтворгүй байдал болон ядуурлыг бууруулахад чухал үүрэгтэй. Гол нь эдийн засаг, нийгэм хүрээлэн байгаа байгаль орчны нөхцөл байдлаас шалтгаалан хувь хүн, өрхөд учрах сөрөг нөлөөллийг багасгах зорилготой. Эдгээр нөлөөлөл нь байнгын (тахир дутуу, хөдөлмөрийн чадваргүй) болон түр зуурын болон ажилгүйдлийн үр дагавартай байж болох юм. Мөн улсын хэмжээнд тохиолдсон, нийгмийн томоохон бүлэг хэсэг өртөгдсөн байгалийн гамшиг бэрхшээл (зуд, ган гэх мэт) болон тэжээгчээ алдах зэргээр зөвхөн тухайн өрхөд хамаарсан байж болно. Тухайн тохиолдол бүрт авах хариу арга хэмжээ нь өөр өөр байх нь бий.

Нийгмийн хамгааллын үндсэн 2 сүлжээ байдаг. Нийгмийн хамгааллын албан бус сүлжээ нь уламжлалт буюу албан бус арга замаар тухайн орон нутгийн хүмүүс, танил тал болон өрхийн гишүүдийн дэмжлэгт тулгуурласан, бусдаас авсан бэлэг, тусламж, хандив хэлбэрээр тодорхойлогддог. Харин нийгмийн хамгааллын албан сүлжээ нь нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст төрөөс туслах, хамгаалахад оршдог.

Монголын хувьд нийгмийн хамгааллын албан сүлжээ нь нэлээд өргөн хүрээтэй байдаг ба ихэвчлэн нийгмийн даатгал, нийгмийн халамжаас бүрддэг[32]. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжихэд хадгалагдан үлдсэн төрийн нийгмийн хамгааллын энэхүү сүлжээ нь одоо хүртэл ихээхэн үүрэгтэй байна. Мөн нийгмийн хамгааллын албан бус сүлжээ буюу албан бус, хувийн тусламж ч түгээмэл байна. Тухайлбал, малчид малын солилцоо хийх гэх мэт хувийн шилжүүлгийн хэлбэрийг ашиглаж байна. Энэ хэсэгт нийгмийн хамгааллын албан болон албан бус (хувийн) хэлбэрийг дэлгэрэнгүй тайлбарлана. Дараа нь өрхийн хүлээн авч байгаа хувийн болон улсаас өгч байгаа мөнгөн шилжүүлэг(тэтгэвэр, тэтгэмж, бэлэн мөнгө), тусламжийн тухай үзнэ.

### 2.7.1 Мөнгөн шилжүүлэг, тусламжийн хэмжээ, түүний ач холбогдол

Хүснэгт 2.18-д мөнгөн шилжүүлэг, тусламж, бэлгийг хүлээн авч байгаагаар нь өрхүүдийг ангилан үзүүлэв. Зарим дүнг энд цохон тэмдэглэх хэрэгтэй гэж үзэж байна. Нэгд, мөнгөн шилжүүлэг, тусламж, бэлэг авах,өгөх нь нэлээд өргөн хүрээг хамарч байгаа бөгөөд 10 өрх тутмын 9 нь ямар нэгэн байдлаар бусдаас мөнгөн шилжүүлэг, тусламж, бэлэг авсан байна. Хоёрт, улсаас болон хувь хүнээс бэлэг, тусламж авсан өрхүүдийн хамрагдалт эрс өөр байна. Арван өрхийн ес нь улсаас, харин таван өрх тутмын нэг нь хувиас мөнгөн шилжүүлэг, тусламж бэлэг авсан байна.

[32] Нийгмийн даатгал нь зарим эрсдлийг хамгаалахын тулд улсаас төлж байгаа өндөр насны тэтгэвэр, ажилгүйдлийн, өвчтэй байсны тэтгэмж гэх мэтээс бүрдэнэ. Нийгмийн халамж нь хамгаалал тусламж зайлшгүй шаардагдаж байгаа тухайн бүлэг хүмүүст зориулсан байдаг. Үүнд тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэмж болон нөхөн олговор хамаарна.

Гуравт, улсын мөнгөн шилжүүлэг нь нийт шилжүүлсэн дүнгийн дөрөвний гурваас илүүг бүрдүүлж байна. Дөрөвт, Улсын мөнгөн шилжүүлгийн гол хоёр бүрэлдэхүүн хэсэг нь өндөр насны тэтгэвэр, хүүхдийн мөнгө байна. Өндөр насны тэтгэврийг дөрвөн өрх тутмын долоо нь хүртэж байгаа бөгөөд нийт дүнгээрээ улсын мөнгөн шилжүүлгийн талаас илүү хувийг эзэлж байна. Хүүхдийн мөнгийг нь арван өрх тутмын долоо нь хүлээн авч байгаа бөгөөд улсын мөнгөн шилжүүлгийн дөрөвний нэгийг эзэлж байна. Үнэндээ хүүхдийн мөнгө авах өрх хамгийн олон байгаа нь улсын мөнгөн шилжүүлэг 2002-03 онд улсын мөнгөн шилжүүлэг нь нийт өрхийн тавин хувьд өгөгддөг байснаас эрс өссөний гол шалтгаалах хүчин зүйл болж байна. Тавд, хувиараа өгч байгаа нийт мөнгөн шилжүүлэг, бэлэг, тусламжийн аравны есийг хүлээн авч байгаа хүмүүс нь гэр бүлийнхэн, найз нөхөд нь байна. Зургаад, хэдийгээр хувиасаа гадаадаас өгч байгаа шилжүүлэг, тусламж, бэлэг нь хувиас мөнгөн шилжүүлэг, тусламж бэлэг авч байгаа нийт өрхийн тавны дөрөвт очиж байгаа боловч нийт дүнгээрээ хувийн эх үүсвэрийхээ дөнгөж тавин хувьтай л тэнцэж байна. Эцэст нь, улсаас өгч байгаа мөнгөн шилжүүлэг, бэлэг,тусламжийн хэмжээ тухайн өрхүүдийн хэрэглээний тавны нэгээс арай ихийг, харин хувиас авч байгаа хэмжээ нь бараг тавны нэг шахмыг бүрдүүлж байна.

### Хүснэгт 2.7 Өрхийн хүлээн авсан шилжүүлэг, бэлэг, тусламж

| | Шилжүүлэг бүхий өрхүүд (%) | Шилжүүлэг бүхий хүн ам (%) | Шилжүүлэг хүлээн авч байгаагаас | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Өрхийн авсан дундаж шилжүүлэг (сард, төгрөгөөр) | Хэрэглээнд эзлэх хувь (%) | нийт шилжүүлгэнд эзлэх хувь (%) |
| Нийт | 91.5 | 94.5 | 72,917 | 25.9 | 100.0 |
| Нийгмийн хамгаалал, халамж | 88.9 | 93.1 | 58,242 | 22.2 | 77.7 |
| Өндөр насны | 27.1 | 25.0 | 101,980 | 41.5 | 41.5 |
| Тахир дутуугийн | 7.8 | 8.5 | 52,000 | 19.9 | 6.1 |
| Тэжээгчээ алдсаны | 3.4 | 3.7 | 51,841 | 19.5 | 2.6 |
| Жирэмсний болон амаржсаны | 5.3 | 6.4 | 12,201 | 3.9 | 1.0 |
| Нярай хүүхэд асарсны | 4.1 | 5.1 | 11,344 | 4.1 | 0.7 |
| Хүүхдийн | 70.7 | 81.2 | 19,406 | 6.7 | 20.6 |
| Бусад а/ | 13.0 | 15.3 | 26,803 | 9.2 | 5.2 |
| Бэлэг, тусламж | 21.8 | 20.2 | 68,229 | 17.9 | 22.3 |
| Гэр бүл, найз нөхдөөс | 18.9 | 17.1 | 74,474 | 19.5 | 21.1 |
| Бусад б/ | 3.6 | 3.9 | 22,135 | 6.3 | 1.2 |
| Дотоодоос | 4.7 | 4.4 | 158,646 | 35.4 | 11.1 |
| Гадаадаас | 17.7 | 16.4 | 42,360 | 12.8 | 11.2 |

*а/ Нөхөн олговор, ажилгүйдлийн тэтгэмж, хөдөлмөрийн чадвар түр алдсаны мөнгө, оршуулгын тэтгэмж болон бусад тэтгэвэр, тэтгэмжүүд орно.*

*б/ Төр, улсын болон хувийн компани, байгууллагууд, ТББ-ууд гадаадын байгууллага, хувь хүний болон бусад эх үүсвэр орно.*

*Эх сурвалж: ӨНЭЗС 2007/08.*

## 2.7.2 Өрхийн хүлээн авч байгаа мөнгөн шилжүүлэг, бэлэг, тусламж

Нийгмийн хамгааллын үндсэн зорилгын нэг нь эмзэг бүлгийнхэнд туслах, учрах эдийн засаг, нийгмийн сөрөг нөлөөллийг багасгахад оршдог. Хүснэгт 2.19-д ядуурлын түвшин болон улсын эсвэл хувийн мөнгөн шилжүүлэг, тусламж, бэлгийг хүлээн авч байгаа болон аваагүй өрхүүдийн хоорондын хамаарлыг үзүүлэв. Хувийн мөнгөн шилжүүлэг, бэлэг, тусламж авч байгаа хүн амын ядуурлын түвшин бага байна. Ийм дүр зураг хотод мөн ажиглагдаж байхад хөдөөд мөнгөн шилжүүлэг, тусламж, бэлэг авч байгаа болон авахгүй байгаа хүн амын ядуурлын түвшин ойролцоо байна. Өөр хоёр үр дүнг мөн цохон тэмдэглэх хэрэгтэй. Нэгдүгээрт, нийт ядуучуудын зөвхөн долооны нэг нь л хувийн мөнгөн шилжүүлэг, тусламж бэлэг авч байна. Хоёрдугаарт эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхүүд хувийн мөнгөн шилжүүлэг, тусламж бэлэг авах магадлал өндөр байна. Улсаас мөнгөн шилжүүлэг, бэлэг, тусламж авч байгаа болон авахгүй байгаа хүн амын бүлгүүдийн хоорондын харьцуулалтыг маш болгоомжтой хийх хэрэгтэй. Улсаас авч байгаа хүн амын дунд ядуурлын түвшин өндөр байгаа нь мөнгөн шилжүүлэг, бэлэг тусламжийн зорилтот бүлэг зөв сонгогдож байгааг харуулж байж болох талтай. Гэхдээ бараг бүх хүн ам ямар нэг хэлбэрийн мөнгөн шилжүүлэг, бэлэг, тусламжийг улсаас авч байгаа баримт нь дээрх цогц үзүүлэлтүүдийн гаргаж ирж байгаа мэдээллийн ач холбогдолд сөргөөр нөлөөлж байна.

### Хүснэгт 2.19 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улсын болон хувийн шилжүүлэг, бэлэг тусламжаар

| | Хувийн | | | | Улсын | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хот | | Хөдөө | | Хот | | Хөдөө | |
| | Тийм | Үгүй | Тийм | Үгүй | Тийм | Үгүй | Тийм | Үгүй |
| Ядуурлын хамралтын хүрээ | 28.2 | 23.3 | 46.7 | 45.4 | 9.9 | 28.3 | 20.7 | 48.1 |
| | (1.2) | (1.8) | (1.3) | (2.7) | (1.6) | (1.1) | (2.3) | (1.2) |
| Ядуурлын гүнзгийрэлт | 8.2 | 6.4 | 13.3 | 14.2 | 2.9 | 8.1 | 5.6 | 13.9 |
| | (0.4) | (0.6) | (0.5) | (1.2) | (0.7) | (0.4) | (0.9) | (0.5) |
| Ядуурлын мэдрэмж | 3.3 | 2.6 | 5.1 | 6.3 | 1.2 | 3.2 | 2.3 | 5.4 |
| | (0.2) | (0.3) | (0.2) | (0.7) | (0.4) | (0.2) | (0.5) | (0.2) |
| *Нэмэлт үзүүлэлтүүд:* | | | | | | | | |
| Хүн амын хувийн жин (%) | 72.5 | 27.5 | 89.6 | 10.4 | 7.9 | 92.1 | 5.6 | 94.4 |
| Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн | 76.2 | 23.8 | 89.8 | 10.2 | 2.9 | 97.1 | 2.5 | 97.5 |
| Өрхийн ам бүлийн тоо | 4.0 | 3.6 | 3.9 | 3.5 | 2.6 | 4.1 | 2.2 | 4.0 |
| Хүн ам зүйн ачаалал (%) | 35.6 | 41.9 | 40.8 | 40.9 | 3.7 | 42.0 | 1.8 | 45.0 |
| Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх хувийн жин) | 25.7 | 23.6 | 28.6 | 25.5 | 2.1 | 28.2 | 0.7 | 31.2 |
| Өрхийн тэргүүлэгчийн нас | 44.8 | 47.8 | 43.7 | 44.4 | 41.4 | 46.3 | 39.5 | 44.2 |
| Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%) | 77.5 | 64.8 | 85.3 | 72.4 | 70.3 | 74.2 | 86.5 | 83.5 |

*Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав*

*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-2008*

## 2.7.3 Өндөр насны тэтгэвэр

Улсаас өгч байгаа мөнгөн шилжүүлэг, тусламж чухал ач холбогдолтой гэж үзэж байгаа тул түүний томоохон бүрэлдэхүүн хэсэг болох өндөр насны тэтгэвэр болон ядуурлын хоорондын хамаарлыг судалж үзлээ. (Хүснэгт 2..20) Улсын хэмжээнд тэтгэвэр авагчтай өрхийн амьжиргаа нь тэтгэвэр авдаггүй өрхүүдийнхтэй харьцуулахад илүү сайн байна.[33] Гэвч энд хот хөдөөгийн ялгаатай байдал тодорч харагдахгүй байна. Үнэндээ. хөдөөгийн тэтгэвэр авагчтай өрхийн ядуурлын түвшин үлэмж доогуур байхад хот суурин газарт тэтгэвэр авагчтай, авагчгүй өрхийн ядуурлын түвшин ялгаагүй байна. Энэ үр дүнгийн боломжит тайлбар нь улирлын онцлогоос үл хамаардаг тогтмол орлогын эх үүсвэр болох тэтгэвэр авдаг гишүүнтэй байх нь сумын төв болон хөдөө нутагт амьдарч байгаа өрхийн амьжиргааг сайжруулж байгаа байж болох юм. Тэтгэвэр авдаг, авдаггүйгээр нь судалж үзэхэд ядуучуудын тархалт нь нийт хүн амын тархалтай нягт уялдаатай харагдаж байгаа буюу улсын дунджаар нийт ядуу хүн амын дөрөвний нэг нь тэтгэвэр авагчтай өрхийн ам бүл байгаа бол ойролцоогоор гуравны нэг нь хот, тавны нэг орчим нь хөдөө дэх тэтгэвэр авагчтай өрхийн ам бүл байна. Хүн ам зүйн үзүүлэлтүүд ч гэсэн маш тодорхой хандлагуудыг харуулж байна. Хүүхдийн тоо улсын дунджаар тэтгэвэр авагчтай өрхөд цөөн байгаа хэдий ч хүн ам зүйн ачаалал өндөр буюу өндөр настай хүмүүсийн тоо олон байна. Эдгээр өрхийн тэргүүлэгчийн дундаж нас нь нэлээд ахимаг, голдуу эмэгтэйчүүд байна.

### Хүснэгт 2.20 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, өндөр насны тэтгэвэр

| | Улсын дундаж | | Хот | | Хөдөө | |
|---|---|---|---|---|---|---|
| | Тийм | Үгүй | Тийм | Үгүй | Тийм | Үгүй |
| Ядуурлын хамралтын хүрээ | 36.3 | 32.1 | 26.5 | 27.7 | 48.0 | 40.9 |
| | (0.9) | (1.3) | (1.2) | (1.7) | (1.3) | (1.9) |
| Ядуурлын гүнзгийрэлт | 10.5 | 8.8 | 7.8 | 7.5 | 13.8 | 11.6 |
| | (0.3) | (0.5) | (0.5) | (0.6) | (0.5) | (0.7) |
| Ядуурлын мэдрэмж | 4.2 | 3.3 | 3.2 | 2.8 | 5.4 | 4.4 |
| | (0.2) | (0.2) | (0.2) | (0.3) | (0.2) | (0.4) |
| *Нэмэлт үзүүлэлтүүд:* | | | | | | |
| Хүн амын хувийн жин (%) | 75.0 | 25.0 | 71.0 | 29.0 | 80.5 | 19.5 |
| Ядуурлын шугамаас доогуур хүн амын хувийн жин (%) | 77.3 | 22.7 | 70.0 | 30.0 | 82.9 | 17.1 |
| Өрхийн ам бүлийн тоо | 4.0 | 3.6 | 3.9 | 3.8 | 4.1 | 3.1 |
| Хүн ам зүйн ачаалал (%) | 32.0 | 57.4 | 30.0 | 55.4 | 34.5 | 60.6 |
| Хүүхдийн тоо (ам бүлд эзлэх хувийн жин) | 31.4 | 12.8 | 29.4 | 14.6 | 34.0 | 10.0 |
| Өрхийн тэргүүлэгчийн нас | 39.0 | 60.8 | 39.5 | 60.5 | 38.2 | 61.2 |
| Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх (%) | 83.6 | 63.0 | 78.6 | 62.1 | 89.9 | 64.6 |

*Санамж: Судалгааны зохиомжоос хамаарсан стандарт алдааг хаалтанд харуулав*

*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-2008*

[33]. Өндөр насны тэтгэвэр нь нийгмийн халамжийн нэг хэлбэр бус харин ажилчид тэтгэврийн санд хуримтлуулсан мөнгөнөөсөө авч байгаа юм гэдгийг мартаж болохгүй.

# Ашигласан материал

Датт, Г болон Раваллион. М, 1992 “Ядуурлын хэмжүүр дэх өөрчлөлтийн өсөлтийн ба дахин тархалтын бүрэлдэхүүн хэсгүүд, Хөгжлийн эдийн засгийн онолын сэтгүүл 38, 275-295

Деатон, Ангус, 1997, “Өрхийн судалгааны дүн шинжилгээ: хөгжлийн бодлогын микро эконометрикийн арга” Дэлхийн Банк, Жон Хопкинсийн Их сургуулийн хэвлэл, Балтимор, Лондон
.
Деатон, Ангус, Жон Мьюллбауер, 1986, “Хүүхдийн зардлыг хэмжих тухай: ядуу орнуудад хэрэглэх аргууд”, Улс төрийн эдийн засгийн сэтгүүл, 94(4), 720-44.

Деатон, Ангус, Салман Зайди, 2002, “Аж байдлын дүн шинжилгээ хийхэд хэрэглээний иж бүрдэл байгуулах заавар” АТТС-ны ажлын баримт бичиг 135, Дэлхийн Банк, Вашингтон, ДС.

Фостер, Ж, Греер, ба Торбеке. Е, 1984, “Ядуурлын цогц хэмжүүрүүдийн анги”, Эконометрика 52 (3), 761-766.

Хенчел, Жеско, Петр Ланжоу, 1996, “Ядуурлын шинжилгээ хийхэд хэрэглээний үзүүлэлтийг байгуулах: Эквадорийн зарчмууд болон жишээнүүд” АТТС-ны ажлын баримт бичиг 124, Дэлхийн Банк, Вашингтон, ДС.

Хоуес, Стевен, Жан Олсон Ланжоу, 1997, “Ядуурлын харьцуулалт болон өрхийн судалгааны загвар” АТТС-ны ажлын баримт бичиг 129, Дэлхийн Банк, Вашингтон, ДС.

Ланжоу, Петр, Бранко Милановик, Стефано Парерностро, 1998, “Ядуурал ба Эдийн засгийн шилжилт: Эдийн засгийн хэмжүүрийн өөрчлөлт өрхүүдийн ядуурлын түвшинд хэрхэн нөлөөлж байна вэ?” Бодлого судалгааны ажлын баримт бичиг 2009, Дэлхийн Банк, Вашингтон, ДС.

Монгол Улсын Үндэсний Статистикийн Газар, 2004. Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгааны үндсэн тайлан. 2002-2003 он. Улаанбаатар

Монгол улсын Үндэсний Статистикийн Газар, 2007. “Монгол улсын статистикийн эмхтгэл” Улаанбаатар

Раваллион, М, 1996. “Ядуурлыг загварчлах, хэмжих тухай асуудлууд”, Эдийн засгийн сэтгүүл 106, 1328-1343

Раваллион, М. 1998. “Ядуурлын шугам онол, амьдрал дээр”. АТТС-ны ажлын баримт бичиг 133. Дэлхийн банк, Вашингтон. ДС

# ХАВСРАЛТ A. Өрхийн нийгэм эдийн засгийн 2007-2008 оны судалгаа

Энэ хавсралтанд 2007-2008 онд хийгдсэн Өрхийн Нийгэм Эдийн Засгийн Судалгааны (ӨНЭЗС) ерөнхий шинж байдал, судалгааны түүврийн зохиомж, мэдээллийн чанарын талаархи зарим нарийвчилсан үнэлгээг хийж тусгав.

### А.1. ӨНЭЗС-ны талаарх товч танилцуулга

2007-2008 онд хийгдсэн ӨНЭЗС нь хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын байдлыг тодорхойлохоос гадна өрхийн орлого, зарлагыг тооцох, хэрэглээний үнийн индекст ашигладаг сагс болон жинг шинэчлэх, ДНБ-ийг хэрэглээний аргаар тооцоход шаардлагатай мэдээлэл гаргах зорилготой улсын хэмжээнд төлөөлөх чадвартай судалгаа юм. ӨНЭЗС-г ҮСХ-ноос тогтмол явуулж байгаа бөгөөд аливаа 12 сарын хугацааг нь сонгон авч дүн шинжилгээ хийж болно. Энэ тайланд мэдээлэл цуглуулах ажлын эхний 12 сар буюу 2007 оны 7-р сараас 2008 оны 6-р сарыг хамарсан хугацааны дүн шинжилгээг хийнэ. Амьжиргааны түвшнийг тодорхойлох судалгааны хэвшмэл хэд хэдэн модулийг урьд нь явагддаг байсан ӨОЗС-нд хамтатгасан тул ӨНЭЗС-г АТТС-ны сайжруулсан хувилбар гэж нэрлэгдэж болохоор билээ. Энэ судалгаа нь дараах 16 гол модулиас бүрдэж байна. Үүнд: өрхийн гишүүдийн тухай нийгэм эдийн засгийн үндсэн мэдээлэл, боловсрол, эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрүүл мэнд, шилжилт хөдөлгөөн, ажил эрхлэлт, цалинтай ажил, ажил хайлт, газар тариалан ба мал аж ахуй, өрхийн аж ахуйн болон бусад орлого, хадгаламж зээл, сууц ба эрчим хүч, удаан эдэлгээт бараа, хүнсний бус зарлага, хүнсний хэрэглээ болно.

## А.2. Түүвэрлэлтийн зохиомж

ӨНЭЗС-ны түүвэрлэлтэнд 2005 оны засаг захиргааны бүртгэлийн тоо мэдээн дээр үндэслэн ҮСХ-ноос боловсруулсан түүврийн хүрээг ашигласан. Сүүлийн жилүүдэд хүн амын газарзүйн байршлын тархалт эрс өөрчлөгдөж 2000 оны тооллого дээр үндэслэсэн аливаа хүрээний зохицол алдагдсан тул энэхүү шинэчилсэн түүврийн хүрээ нь маш их ач холбогдолтой болж байна. [34]

Судалгааны зохиомжид Улаанбаатар, аймгийн төвүүд, хөдөө нутаг болон сумын төвүүд гэсэн гурван илэрхий бүлгийг ашигласан. Мөн Улаанбаатар хотод түүврийг дүүрэг, хороодоор харин хөдөөд аймгуудаар хуваарилсан. Аймгийн төв бүр нэг дэд бүлэг гэдэг нь тодорхой юм.

[34] Монгол улс 21 аймагт хуваагддаг. Нийслэл хот нь Монгол улсын хамгийн том засаг захиргааны нэгж бөгөөд 9 дүүрэг, 121 хороо, 1,035 хэсэгт хуваагддаг. Хэсэг бүрт ойролцоогоор 200 орчим өрх харьяалагддаг. Улаанбаатар хотоос бусад хэсэг нь аймаг, сум, багуудад х уваагддаг. Аймаг бүрийн төвийг мөн сум гэж тооцох бөгөөд бусад нь хөдөөний сум юм.

Энэ сонголтын стратеги нь бүлэг тус бүрд өөр байсан буюу хотод хоёр үе шаттай, хөдөөд гурван үе шаттай процессоор хэрэгжүүлсэн. Улаанбаатар хотод эхлээд 360 хэсэг, хэсэг тус бүрээс 10 өрх сонгосон. Аймгийн төвүүдэд эхлээд 12 эсвэл 24 баг сонгож баг тус бүрээс 10 өрх сонгож авсан. [35] Хөдөөд эхлээд 52 сум сонгож сум тус бүрээсээ 12 баг, баг тус бүрээсээ 8 өрх сонгосон. Нийт 1248 түүврийн анхан шатны нэгж буюу кластерийг (хэсэг, баг эсвэл сум) хэмжээтэй нь пропорциональ магадлалаар сонгосон бөгөөд судалгааны мэдээлэл цуглуулах 12 сарын хугацаанд нь санамсаргүйгээр хуваарилсан. Ингэснээр судалгаагаар сар бүр 104 түүврийн анхан шатны нэгжээс бүрдэх санамсаргүй дэд түүврээс мэдээлэл цуглуулсан болно.

Түүвэрлэлтийн энэ аргачлалаар Монгол улсын өөр нутаг дэвсгэрт амьдарч байгаа өрхүүд өөр өөр магадлалаар сонгогдсон. Иймд бүлэг тус бүр болон нийт улсын хэмжээнд төлөөлөх чадвартай статистикийн мэдээ баримт цуглуулахын тулд түүвэрлэлтийн жинг ашиглах нь чухал болсон. Уг жинг түүврийн стратегийг ашиглан сонголтын магадлалтай нь урвуугаар авч өрх бүрд оноолоо.

11,232 өрхөөс 3,600-г Улаанбаатар хотод, 2,640-ийг аймгийн төвүүдэд, 4,992-ыг сумын төвүүд болон хөдөө нутагт хуваариллаа. Гэхдээ энэ тайланд ашигласан бодит түүвэр нь үүнээс арай бага буюу Улаанбаатар хотод 3571 өрх, аймгийн төвд 2621 өрх, сумын төв болон хөдөө нутагт 4,980 өрх байлаа. Бүрэн мэдээлэл байхгүйгээс шалтгаалан 60 өрх хасагдсан тул дээрх зөрүү гарсан.

**Хүснэгт A1. 2007-08 оны ӨНЭЗС-ны түүвэр, ТАШН-ээр, ярилцлага авсан сараар**

| | Улаанбаатар | Аймгийн төв | Хөдөө | Улсын хэмжээгээр |
|---|---|---|---|---|
| 2007 оны 7 сар | 297 | 216 | 408 | 921 |
| 8 сар | 297 | 217 | 412 | 926 |
| 9 сар | 297 | 219 | 412 | 928 |
| 10 сар | 298 | 220 | 407 | 925 |
| 11 сар | 299 | 219 | 423 | 941 |
| 12 сар | 295 | 220 | 415 | 930 |
| 2008 оны 1 сар | 293 | 220 | 411 | 924 |
| 2 сар | 299 | 220 | 420 | 939 |
| 3 сар | 298 | 220 | 416 | 934 |
| 4 сар | 300 | 211 | 425 | 936 |
| 5 сар | 300 | 219 | 416 | 935 |
| 6 сах | 298 | 220 | 415 | 933 |
| Нийт | 3,571 | 2,621 | 4,980 | 11,172 |

## A.3. Мэдээллийн чанар

Мэдээллийн чанарын стандарт сайн хангагдсан гэж үзэж байна. Нэг талаас, ӨНЭЗС-аар өрхүүдээс асар их мэдээлэл цуглуулах болсон тул

[35] Зөвхөн Дархан Уул, Орхон хоёр аймгаас 24 баг сонгосон.

өмнөх АТТС-тай харьцуулахад үйл ажиллагааны стратеги болон мэдээллийн удирдлагад шинэ шаардлагууд тавигдах болсон. Бүх арга ажиллагаа нь цэгц дараалаар, төвлөрсөн байдлаар хийгдэх болсноор мэдээллийн чанарт эерэг нөлөө үзүүлсэн байх магадлалтай. Нөгөө талаас мэдээллийн уялдааны шалгалтыг гурван үе шатанд буюу мэдээлэл шивж оруулахад, анхдагч тоо мэдээллийг боловсруулах үед, гуравдугаарт энэ тайланг бэлдэх үед гүйцэтгэлээ. Бүх тохиолдолд эдгээр шалгалтанд ашиглаж байгаа жагсаалтуудыг өрхүүдийн нөхсөн маягтууд дээрх мэдээлэлтэй тулгасан (Зарим тохиолдолд эхний шатны шалгалтын үед зарим өрхүүд дээр дахин очиж шалгасан.) бөгөөд алдаа илэрсэн тохиолдолд шууд залруулж байсан.

# ХАВСРАЛТ Б. ЯДУУРЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭНД АШИГЛАСАН АРГА ЗҮЙ.

**Я**дуурлын дүн шинжилгээ х**ий**хэд 3 бүрэлдэхүүн хэсэг шаардлагатай байдгийг юуны өмнө тэмдэглэе. Үүнд:

*Нэгдүгээрт*: хэмжигдэж, хүлээн зөвшөөрөгдөж болохуйц, хүн амыг эрэмбэлэх боломжтой аж байдлын үзүүлэлтүүд;

*Хоёрдугаарт:* хүн амыг ядуу ба ядуу бусаар ангилах сонгогдсон үзүүлэлттэй харьцуулах тохиромжтой ядуурлын шугам;

*Гуравдугаарт:* аж байдлын бие даасан үзүүлэлтүүдийг нэгтгэн ядуурлын ерөнхий дүр төрхийг харуулах цогц хэмжүүрүүд.

Хугацаагаар харьцуулах боломжийг хангахын тулд энэ удаагийн судалгаа шинжилгээний арга зүйд 2002-2003 оны ӨОЗАТТС-ны ядуурлын шинжилгээнд[36] баримталсан арга зүйг аль болох авч ашиглахыг бодлоо.

Энэ хавсралтанд ядуурлын хэмжүүр үзүүлэлтүүд, ядуурлын шугамыг тогтоосон байдал, хэрэглээний хэмжээг тодорхойлон бүрдүүлэх боловсруулалтын бүх шатыг тайлбарлана. I бүлэгт хэрэглээг аж байдлын үзүүлэлт болгон сонгон авсан талаар авч үзнэ. II бүлэгт өрхийн нэрлэсэн хэрэглээг тооцох аргыг харуулна. III, IV бүлэгт өрхийн суурьшил, судалгаанд хамрагдсан он, сар, өдөр болон ам бүлийн бүтцийг засварласанаар хэрхэн бодит хэрэглээний хэмжигдхүүнийг тооцсон талаар тайлбарлах болно. III бүлэгт газар зүйн байрлалын болон цаг хугацааны үнийн засварлалт, IV бүлэгт өрхийн хүн амын бүтцийн засварлалт, V бүлэгт ядуурлын шугамыг тодорхойлсон аргачлалыг нарийвчлан харуулна. Сүүлчийн VI бүлэгт энэхүү тайланд хэрэглэсэн ядуурлын хэмжүүрүүдийг тайлбарлав.

## Б.1. Аж байдлын үзүүлэлтийн сонголт

Ядуурал нь эрүүл мэнд муутай байх, хүний чадавхи муутай байх зэргээс гадна дэд бүтцийн үйлчилгээг хүртэх боломж хязгаарлагдмал байх, хоол тэжээлийн доройтол, бараа үйлчилгээний дутагдал, шашин шүтлэг, улс

[36] Бүрэн аргачлалыг нъөрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгааны үндсэн тайлан, ҮСХ 2004 номноос харж болно.

төрийн үзэл бодлоо илэрхийлэх чадваргүй байх гэх мэт олон төрлийн хязгаарлалтыг өөртөө агуулдаг. Энэ бүгд нь тус бүрдээ аж байдлын үзүүлэлтүүдийн ялгаатай бүрэлдэхүүн хэсгийг илэрхийлэх тул нэг бүрчлэн анхаарч судлах шаардлагатай бөгөөд бодлого боловсруулагч нарыг ядуурлын янз бүрийн байдал дээр анхаарлаа хандуулахад тус болдог. Ядуурлын эдгээр ялгаатай бүрэлдэхүүн хэсгүүд хосолсон байх тохиолдол элбэг байдаг. Жишээлбэл хоол тэжээлийн дутагдалд үргэлж орсон хүн голдуу боловсрол багатай, эрүүл мэндийн тусламж авах боломжгүй байдаг.

Сүүлийн жилүүдэд ядуурлын судалгааг хийхдээ амьжиргааны түвшний талаарх эдийн засгийн хэмжигдэхүүнүүдийг ашиглах тал дээр зарим нэг ерөнхий зөвшилцөлд хүрч байгаа бөгөөд энэ нь ядуурлын дүн шинжилгээнд тогтмол хэрэглэгдэж байна. Түүнчлэн орлогод суурилсан ядуурлын үзүүлэлтүүд нь юуны түрүүнд Мянганы хөгжлийн зорилтуудыг хянах үндэс болж байна. Хэдийгээр эдгээр үзүүлэлтүүд нь аж байдлын бүх талын хүрээг хамарч чадахгүй ч амьжиргааны түвшний аливаа үнэлгээний үндсэн гол хэсгийг илэрхийлдэг. Орлого, хэрэглээ хоёрын алиныг нь аж байдпын хэмжүүр үзүүлэлт болгож сонгож авахыг шийдэх нь маш чухал юм . Хэрэглээ нь амьжиргааны түвшнийг орлогоос арай илүү нарийн хэмжиж тодорхойлдог илүү ач холбогдолтой буюу зохимжтой үзүүлэлт юм. Онолын хувьд ч мөн практик дээр ч амьжиргааны түвшнийг хэрэглээгээр тодорхойлох нь орлогоор тодорхойлсноос илүү зохимжтой гэж үздэг байна.[37]

Ийм шийдэлд хүрэхийн тулд онолын дагуу эхний авч үзэх асуудал бол хэрэглээ ба орлого гэдэг нь чухам юу гэсэн ойлголт вэ гэдгийг тодорхойлох юм. Хэдийгээр энэ хоёр нь өөр ойлголтууд боловч хоёул сэтгэл ханамжийг ямар нэг байдлаар илэрхийлдгээрээ төстэй. Хэрэглээ нь хувь хүн бүр бодитоор юутай байсныг хэмждэг бол орлого нь хөрөнгийн хамт хүний чадварыг хэмждэг. Хоёрдугаарт амьжиргааны түвшинг судлах цаг хугацааны үеийн сонгох шаарддлагатай болдог. Хүний бүхэл амьдралын турш гэх мэт урт хугацааны амьжиргааны түвшинг судлахыг сонирхож байгаа тохиолдолд орлого ба хэрэглээний алийг сонгох нь ялгаагүй. Харин богино хугацааны буюу жишээ нь нэг жилийн хувьд орлогыг бодвол хэрэглээ нь илүү тогтвортой, өөрчлөлт багатай байна. Өрхүүд зээл авах, хадгаламж ашиглах боломж болон ирээдүйн орлогын урсгалын тухай мэдээлэл, төсөөлөл дээрээ үндэслэн хэрэглээгээ аль болох жигд хуваарилах чадвартай байдаг. Мөн түүнчлэн хэрэглээ нь орлоготой харьцуулахад улирлын хэлбэлзэл багатай байдаг. Тухайлбал газар тариалан эрхэлж байгаа өрхийн орлогын түвшин нь ургац хураалт, тариалалтын үетэй холбоотойгоор маш хэлбэлзэлтэй байдаг ба тийм ч учраас энэ үзүүлэлтийг ашигласанаар амьжиргааны түвшинг үлэмж хэмжээгээр ихэсгэж, багасгаж бодитой бусаар тооцоолох магадлал бий.

Нөгөө талаас, практик үүднээс анхаарч үзвэл зохих асуудлууд байдаг. Үүнд нэгдүгээрт, мэдээлэгчдэд ойлгоход тодорхой байх. Хэрэглээ нь мэдээлэл өгөгчдөд орлогоос илүү хялбар ойлголт байдаг. Ялангуяа

[37] Деатон, Зайди нарын илтгэл (2002)

орлого нь хувиараа хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанаас орж байгаа бол хэрэглээг мэдээлэхэд илүү хялбар байна. Жишээлбэл албан ёсны бүртгэлтэй салбарт ажиллаж байгаа хүмүүс орлогын үндсэн эх үүсвэрээ буюу жишээлбэл цалин хөлсөө тодорхой мэдээлэхэд ямар нэг хүндрэл учрахгүй. Харин албан бус сектор, эсвэл хөдөө аж ахуйд ажилладаг хүмүүс, хувиараа хөдөлмөр эхлэгчид орлогоо нарийн тодорхойлоход бэрхшээлтэй байдаг бөгөөд өрхийн болон бизнесийн ажил гүйлгээ холилдон бүртгэгддэг. Хоёрдугаарт, өмнө хэлж байснаар жилийн орлогын тоон мэдээллийг тооцоолоходоо улирлын нөлөөлий бодолцох ёстой. Эцэст нь мэдээллийн үнэн бодитой байдлыг харгалзан үзэх нь гол асуудал болно. Өрхүүд орлогоосоо илүүгээр хэрэглээгээ мэдээлэхдээ дуртай байдаг. Тэд орлогын талаарх мэдээллийг нь өөр зорилгоор, тухайлбал татварын түвшинг тодорхойлох үүднээс цуглуулж магадгүй гэж болгоомжилдог, эсвэл орлогын талаар асуух нь таатай бус гэж үздэгтэй ч холбоотой юм. Мөн өрхийн гишүүд нь өрхийн орлого, түүний эх үүсвэрээс илүүтэйгээр хэрэглээгээ сайн мэдэх магадлалтай.

## Б.2. Хэрэглээний бүрэлдэхүүн хэсгийг тогтоох нь

Хэрэглээний бүрэлдэхүүн хэсгийг тогтоохдоо онол практикийн үүднээс мөн авч үздэг. Нэгдүгээрт, байгаа мэдээллийг ашиглан аль болох дэлгэрэнгүй байх, хүн амын аж байдлыг тодорхойлохгүй, эрэмбэлэхэд нөлөө үзүүлэхгүй зарим нэг хэсгийг оруулахгүй байх ёстой. Хоёрдугаарт худалдан авалт нь энэ үзүүлэлтийн цорын ганц бүрэлдэхүүн хэсэг биш учир зах зээлийн болон зах зээлийн бус гүйлгээг хоёуланг нь оруулна. Гуравдугаарт, зардал бол хэрэглээ биш. Удаан хадгалахад тохиромжгүй,, ялангуяа хүнсний бүтээгдэхүүний хувьд худалдан авснаа бүгдийг нь хэрэглэдэг гэж үзэх нь түгээмэл байдаг. Харин орон сууц, удаан эдэлгээт бараа гэх мэт бусад бараа үйлчилгээний хувьд засварлалт хийх шаардлагатай.

Эцэст нь хэлэхэд хүнс, хүнсний бус, сууц, удаан эдэлгээт бараа, эрчим хүч гэсэн 5 үндсэн бүрэлдэхүүн хэсгээс хэрэглээний иж бүрдэл бүрдэнэ. Бүрэлдэхүүн хэсэг бүр тодорхой нэр төрлүүдээс бүрдэх ба эдгээр нэр төрөл бүрийн хэрэглээний үнэлгээг хийх аргачлалыг доор товч тайлбарлав.

**Хүнсний бүрэлдэхүүн хэсэг**

Хүнсний хэрэглээг тооцохдоо нэгдсэн нэг цаг хугацаанд шилжүүлэн хүнсний бүх бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрийн хэрэглээг нэмж бүрдүүлэх бөгөөд дараа нь өрх бүрийн бүх хүнсний барааг нэгтгэдэг. 2007-2008 оны ӨНЭЗС-гаар гурил, гурилан бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн, загас болон далайн бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг, төрөл бүрийн өөх тос, жимс, жимсгэнэ, чихэр, жимсний чанамал, хүнсний бусад бүтээгдэхүүн, цай, кофе, цэвэр ус ундаа, жимсний шүүс, согтууруулах ундаа, тамхи гэсэн 13 бүлэг болгон ангилсан 122 нэр төрлийн бүтээгдэхүүний хүнсний хэрэглээний мэдээллийг өрхийн түвшинд цуглуулсан.

Хот, хөдөөд мэдээлэл цуглуулах арга болон хугацаа нь өөр байсан. Хотод буюу Улаанбаатар болон аймгийн төвүүдэд мэдээллийг өрхийн өдөр тутмын бүртгэл дээр үндэслэн цуглуулсан бөгөөд тоологч нар сард гурван удаа буюу арав хоног бүр очиж мэдээллийг нэгтгэж байв. Өөрөөр хэлбэл өрх тус бүрийн хувьд хүнсний мэдээллийн хамрах хугацаа нь нэг сар байлаа. Сумын төвд сүүлийн долоо хоногийн хэрэглээг эргэн санах аргыг ашигласан. Ийм хоёр өөр арга хэрэглэсэн нь гурван шалтгаантай юм. Нэгдүгээрт, тоологч нар аймгийн төвд амьдардаг бөгөөд аймгийн төвүүд ихэнхидээ хөдөөгөөс нэлээн алс зайд оршдог учир хөдөөгийн өрхүүдэд арав хоног бүр очих боломж байхгүй. Хоёрдугаарт малчин өрхүүд тогтмол нүүдэллэдэг учраас хоёрдох, гуравдах очилтоор зорьсон өрхөө олоход хүндрэл учрах магадлал их. Гуравдугаарт, хотын хүн амыг бодвол хөдөөний хүн ам нь өрхийн өдөр тутмын бүртгэлээ нөхөхөд илүү бэрхшээлтэй байдаг.

Хэрэглээний энэ бүрэлдэхүүн хэсгийг боловсруулахад хэд хэдэн үндсэн зарчмыг хэрэглэсэн. Нэгдүгээрт, хэрэглээний бүх боломжит эх үүсвэрийг оруулав. Өөрөөр хэлбэл хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ нь зах зээлийн газраас худалдан авсан эсвэл гэрээс гадуур хэрэглэсэн хүнснээс гадна гадна өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн, бусдаас авсан, бэлэг, бараа солилцоогоор авсан бүтээгдэхүүн зэргээс бүрдэнэ. Хоёрдугаарт, Худалдан авсан болон өөрийн аж ахуйгаас авсан бүх хүнсний бүтээгдэхүүнийг биш тухайн хугацаанд хэрэглэсэн бүтээгдэхүүнүүдийг л хэрэглээний бүтцэд багтаасан.

Гуравдугаарт мөнгөөр худалдан аваагүй хүнсний зүйлийг үнэлж аж байдлын хэмжигдэхүүнд оруулах хэрэгтэй. ӨНЭЗС-гаар өрхийн хүнсний зөвхөн худалдан авалтын хувьд дундаж үнийн дүн, тоо хэмжээний талаар мэдээлэл цуглуулагдсан бөгөөд бусад эх үүсвэрийн хувьд зөвхөн тоо хэмжээний мэдээллийг авсан. Худалдан аваагүй хүнсний зүйлийн мөнгөн үнэ цэнийг тооцоходоо дундаж үнийн энэ мэдээллийг ашиглалаа.

Ихэнх хүнсний бүтээгдэхүүнүүд харгалзах бүлэг дотроо нэлээд дэлгэрэнгүй нэр төрлөөр орсон учир нэр төрөл тус бүр нь харьцангуй нэгэн жигд болсон. Гэхдээ нэгжийн үнэ нь бодит үнэ биш боловч барааны чанарын ялгааг илэрхийлнэ. Энэ нөлөөллийг багасгаж, газар зүйн байрлалын болон цаг хугацааны зөрүүг авч үзэхийн тулд хэд хэдэн түвшинд ( өрх, түүврийн нэгж, аймаг, суурьшил, улирал) үнийн голч утгыг тооцсон болно. Иймээс тухайн өрх хүнсний бүтээгдэхүүн худалдан авсан бол уг худалдан авсан барааны харгалзах голч үнийг өөрийн аж ахуйн болон солилцоогоор авсан барааг үнэлэхэд ашиглана. Хэрвээ өрх ямарваа нэг нэр төрлийн бүтээгдэхүүнийг огт худалдан аваагүй боловч хэрэглэсэн бол хэрэглээг нь үнэлэхэд түүний дээд түвшний (өрхийн харьяалагдах түүврийн нэгжийн гэх мэт) үнийг ашиглана.

2002-03 оны ӨОЗАТС, 2007-2008 оны ӨНЭЗС-ны хүнсний хэрэглээний хэсэг нь мэдээлэл цуглуулах арга, мэдээллийн хамрах хугацаа, болон хүнсний модульд багтсан нэр төрлүүдийн тоо гэсэн гурван зүйлээр ялгарч байна. 2002-03 онд өрхийн бүртгэл ашиглан “нөөцөлсөн, зарлагадсанаар” нь шахаж тооцоолох арга хэрэглэсэн. Өрхүүдээс тухайн

нэр төрлийн хугацааны эхний үлдэгдэл, худалдан авалт, өөрийн аж ахуйгаас бэлтгэсэн, бусдаас үнэгүй авсан, болон бусад үнэгүй өгсөн, хугацааны эцсийн үлдэгдлийг асуугаад эдгээр бүрдэл хэсгүүдийн нийлбэр, ялгавраар нь тухайн хугацааны нийт хэрэгцээг тооцоолон гаргасан. Харин 2007-2008 оны хүнсний хэрэглээний бүтцэд худалдан авсан, бусдаас үнэгүй авсан болон өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн тоо хэмжээг авч үзсэн. Гэвч энэ хоёр аргаас шалтгаалан анхаарал татахуйц ялгаа үүсээгүй байна.[38]

2002-03 оны судалгаанд хүнсний мэдээллийн хамрах хугацаа нь нэг сар байсан бөгөөд гэхдээ өрхүүдээс дараалсан гурван сарын турш ярилцлага авч байсан. Мэдээллийг сар бүрийн эцэст нэгтгэж байсан тул энэ арга нь 2007-2008 оны хүнсний мэдээллийн хамрах хугацаанаас онц их ялгаатай биш юм. [39] Мэдээлэл цуглуулсан хүнсний нэр төрлийн тоо нь өөр байгаа нь энэ хоёр судалгааны бас нэг буюу сүүлийн ялгаа юм. 2002-03 онд 92 хүнсний нэр төрлийн мэдээлэл цуглуулсан бол 2007-2008 онд 122 болж өсчээ. 2002-03 оны хүнсний сагс нь хангалттай олон төрлийг багтааж байсан тул ингэж нэмэгдсэн нь хүнсний тооцоололд анхаарал татахуйц нөлөөлөл үзүүлээгүй байна. Ерөнхийдөө дээрх гурван ялгааны аль нь ч цаг хугацаарх харьцуулалтад ноцтой нөлөөлөхгүй гэж үзэж байна.

## Хүнсний бус бүрэлдэхүүн хэсэг

.
Хүнсний бус хэрэглээг хүнсний хэрэглээтэй адилаар шууд, хялбархан тооцоолдог. Хүнсний хэрэглээтэй адилаар нэгдсэн нэг хугацаанд шилжүүлэн тэгшитгэсэн хэрэглээний бүхий л эх үүсвэрийг оруулах ёстой. Хүнсний бус хэрэглээний өргөн хүрээний буюу эрэгтэй, эмэгтэй, хүүхдийн хувцас, гутал, бэлэг дурсгал, үнэт эдлэл, бөс бараа, боловсрол, эрүүл мэнд, амралт чөлөөт цаг, соёлын зардал, гоо сайхан, ариун цэврийн бараа үйлчилгээ, гэр ахуйн бараа, удаан эдэлгээт бараа, орон сууцны зардал, тээвэр, холбоо, даатгал татвар зэрэг 38 бүлгийн 371 нэр төрлийн бүтээгдэхүүний мэдээллийг цуглуулсан. Хүнсний бус барааны ихэнх нэр төрөл нь дотроо яг ижил бус буюу зарим ялгаатай олон бүтээгдэхүүнийг агуулж нэгжийн үнийг нь тооцоход бэрхшээлтэй байдаг тул ӨНЭЗС-гаар тоо хэмжээний мэдээллийг цуглуулдаггүй. Удаан эдэлгээт бараа, сууц, эрчим хүчнээс бусад хүнсний бус барааны хэрэглээг энэ бүлэгт авч үзнэ.

Хэрэглээг бүрдүүлэхэд мөн тухайн нэр төрлийг оруулах эсэх, судалгааны үеийг тодорхойлох гэсэн үндсэн 2 бэрхшээл байдаг. Нэгдүгээрт зөвхөн хэрэглээнд ордог нэр төрлүүдийг л судалгаанд багтаах ёстой гэсэн алтан дүрэм бий. Тухайлбал хувцас, гутал, гоо сайхны бараа бүтээгдэхүүн, амралт чөлөөт цагт зарцуулсан зардал гэх мэт зүйлс хамрагдана.

---

[38] 2007-08 оны ӨНЭЗС-нд 2002-03 оны ӨОЗ-АТС-тай зэрэгцүүлэх боломжийг ихэсгэхийн тулд бие даасан модуль оруулж "нөөцөлсөн, зарлагадсан"-аар нь шахах арга хэрэглэж нэг сарын эргэн санах хугацааг ашигласан. 2007-08 оны хүнсний тусдаа хоёр модулиаар тооцсон хүнсний хэрэглээний түвшин болон хүнсний бүтэц тун ойролцоо гарсан. Хүнсний хэрэглээний мэдээлэл цуглуулдаг шинэ арга нь хэрэглэхэд хялбар илүү үр өгөөжтэй учир цаашид дараа дараагийн судалгаанд хэрэглэхээр сонгосон бөгөөд ингэснээр цаашид харьцуулагдах боломж нь баталгаатай болох юм.

[39]. Өрхүүдийг дараалсан гурван сар судалгаанд хамруулснаар өрх дотор болон өрх хоорондын хүнсний хэрэглээний хэлбэлзэл бага байсан гэж хэлж болно.

Татварын хэмжээг оруулаагүй бөгөөд учир нь хэрэглээний өндөр түвшинтэй уялдахгүй, өөрөөр хэлбэл татвар илүү төлсөнөөрөө тухайн өрх улсаас илүү их үйлчилгээ авдаггүй. Хөрөнгийн урсгал буюу санхүүгийн хөрөнгө худалдан авах, өр, зээлийн хүүгийн төлбөрийг мөн оруулдаггүй. Гэнэтийн эсвэл бөөн дүнгээр гардаг хурим, төрөлт, оршуулгын зардлын хувьд бүр ч бэрхшээлтэй байдаг. Эдгээр зардлыг он жилүүдэд тархаан, тэгшитгэж тооцох нь хамгийн оновчтой хувилбар юм..Тэгшитгээгүй тохиолдолд тухайн өрхийн хэрэглээний түвшин бодит хэмжээнээс илүүтэйгээр тооцогдоно. Гэвч бидэнд ингэж тооцох хангалттай мэдээлэл байхгүй тул эдгээр хэрэглээнүүдийг тооцоонд оруулаагүй. Мөн бэлэг хүлээн авч байгаа тал нь тооцоонд орсон тул, тооцоог давхардуулахгүй байх үүднээс бусдад өгсөн бэлэг, тусламж, шилжүүлгийг тооцоонд оруулаагүй. Эдгээрийг оруулбал амьжиргааны дундаж түвшинг хиймлээр өсгөнө.

Хүнсний бус бүрэлдэхүүн хэсэг дотроос хоёр зүйл буюу эрүүл мэнд, боловсролын тооцооны хувьд онцгойлон үзэх шаардлагатай. Нэгдүгээрт, боловсрол нь хөрөнгө оруулалт тул хэрэглээ биш хадгаламж гэж үзэх ойлголт байдаг. Боловсролын үр өгөөжийг зөвхөн сурч байх тухайн үедээ бус бүхий л амьдралынхаа турш авдаг. Хоёрдугаарт, хэрвээ удаан хугацааны үеийг авч үзэж байгаа бол боловсролын зардал нь хүний амьдарлын тодорхой үед л гардаг. Сургалтандаа яг ижил хэмжээний зардал гаргасан бөгөөд нэг нь одоо суралцаж байгаа нөгөө нь нилээд хэдэн жилийн өмнө сургуулиа төгсчихсөн хоёр хүнийг харьцуулья. Одоо суралцаж байгаа нь амьжиргаа дээгүүртэй мэт санагдах боловч энэ үр дүн нь зөвхөн насны хувьд хамаатай бөгөөд жинхэнэ аж байдлын түвшний ялгааг харуулж чадахгүй. Энэ зардлыг  амьдралынх нь нийт хугацаанд тэгшитгэн хуваарилах нь хамгийн оновчтой арга юм. Гуравдугаарт, улсын сургуульд суралцах боломжийг авч үзэх хэрэгтэй. Хэрэв бүх хүн ам үнэ төлбөргүй эсвэл өндөр татаас бүхий боловсрол эзэмших боломжтой бөгөөд харин чанарыг нь харгалзан үзэж хувийн сургуулийн сонгон төлбөр төлж суралцдаг бол боловсролын зардлын ялгаатай байдал нь аж байдлын ялгаатай байдалтай холбогдох бөгөөд ийм  тохиолдолд тухайн зардлыг оруулах нь зүйтэй гэж үздэг. Энэ судалгаанд стандарт практикийн дагуу боловсролын зардлыг хэрэглээний бүтцэд оруулсан. Эдгээр зардлыг оруулахгүй байх нь сургуулийн насны хүүхдүүдтэй хоёр өрхийн зөвхөн нэг нь хүүхдээ сургуульд сургах боломжтой бол энэ ялгааг гаргаж чадахгүйд хүрнэ.

Эрүүл мэндийн зардал ч зарим талаараа боловсролтой адил юм. Урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт зарцуулсан зардал нь мөн хөрөнгө оруулалт адил тооцогдоно. Төрөөс хангадаг үйлчилгээг харилцан адилгүй хүртдэг байх нь өрхүүдийн хоорондын харьцуулалтыг буруу үр дүнд хүргэнэ. Хүн амын зарим хэсэг нь үнэ төлбөргүй, эсвэл улсаас ихэнх зардлыг нь даадаг эмнэлгийн үйлчилгээнд хамрагдаж байхад нөгөө хэсэг нь хувийн салбарын үйлчилгээнд хамрагдаж байвал зардлын энэ ялгавартай байдал аж байдлын ялгааг харуулахгүй. Үүнд анхааран үзэх хэд хэдэн зүйл бий. Нэгдүгээрт, эрүүл мэндийн зардал нь байнга бус тодорхой цаг хугацаанд бөөнөөр гардаг. Хоёрдугаарт, эрүүл мэндийн зардал нь өрхийн гишүүн өвчтэй байсантай холбогдон гарсан зардлыг авч үзэж байгаа аж байдлын үзүүлэлт буюу “харамсалтай шаардлага”

болох бөгөөд энэ тохиолдолд өрхийн аж байдал муудах боловч зардал гарсан учир аж байдал өссөн мэт харагддаг. Гуравт, эрүүл мэндийн даатгал нь харьцуулалтыг буруу үр дүнд хүргэдэг. Учир нь даатгалтай өрхийн гишүүн нь өвдөхдөө бага хэмжээний мөнгө зарцуулсан байхад даатгалгүй нь ихийг зарцуулна. Уг судалгааны хувьд эрүүл мэндийн зардлыг мөн оруулахаар болсон. Боловсролтой адилаар эрүүл мэндийн зардлыг хассанаар хоёул өвчтэй хүнтэй боловч нэг нь эмчилгээнд мөнгө зарцуулах чадваргүй байгаа өрхүүдийн ялгааг харуулж чадахгүй.

Хүнсний бус хэрэглээтэй холбоотой хоёр дахь бэрхшээлтэй асуудал нь хэрэглээг тооцох хугацааг сонгох юм. Үүнд худалдан авалт хийх давтамж, өрхийн хэрэглээгээ буцаж санах хугацааны хоорондын хамаарал орно. Ариун цэврийн хэрэгсэл, гоо сайхны бараа, орон сууцны төлбөрөөс бусад олон хүнсний бус бараа бүтээгдэхүүний хувьд долоо хоног, сард ямар нэгэн худалдан авалт гараагүй байдаг тул буцаж санах хугацааг ихэнхидээ сүүлийн улирал юм уу сүүлийн жилээр сонгодог.

ӨНЭЗС нь сүүлийн сар ба сүүлийн жил гэсэн судалгааны хоёр үеийг хамарсан мэдээлэл цуглуулсан. Аль үеийг сонгох нь хэрэглээний бүтцэд үлэмж нөлөөтэй байдаг. Өрхүүд сар бүр хүнсний бус бараа, бүтээгдэхүүн худалдан аваад байдаггүй учраас олон өрхийн хувьд ямар ч хэрэглээ мэдээлэхгүй байх магадлалтай гэсэн үндэслэлээр зөвхөн ганц сар гэсэн сонголтыг хассан. Хэдийгээр сүүлийн нэг сарыг сонгосноор сүүлийн нэг сарын дундаж хэрэглээг ойролцоогоор тооцоолж болох ч сүүлийн нэг сарын хугацаанд худалдан авалт хийгээгүй өрхүүдийг ядуурлын шинжилгээгээр хэрэглээ багатайд тооцон улмаар ядуу ангилалд оруулах магадлалтай. Сүүлийн нэг жилийг эргэн санах хугацаа болгон авбал хүнсний бус бараа, бүтээгдэхүүний хувьд илүү үндэслэлтэй хугацаа болох учир дээрх бэрхшээл арилна. Гэвч эргэн санах хугацааг уртасгахаар нэг сул тал үүсдэг.

Зарлагаа мэдээлэх өрхийн тоо нь нэмэгдэх боловч ингэж цуглуулахад дундаж зарлага нь эргэн санах хугацаа богинотой зардлаас багасаж гарч ирдэг. [40] Энэ хоёр сонголтын давуу, сул талыг нь харгалзаж үзсэн гуравдах сонголт нь эргэн санах хоёр хугацааг хоёуланг нь хослуулах арга юм. Энэ тохиолдолд хэрэв тухайн өрх сүүлийн нэг сард хүнсний бус

[40] 2007-08 оны ӨНЭЗС-нд үнэхээр ийм байдал ажиглагдсан. Удаан эдэлгээт бараа, сууц, эрчим хүчийг хассан бусад хүнсний бус íýð ò°ðëèéí хувьд сүүлийн сарын мэдээлэгдсэн гүйлгээний тоо нь сүүлийн жилийн мэдээлэгдсэн гүйлгээний тооны дөнгөж 40 хувьтай тэнцэж байсан. Нөгөө талаас сүүлийн сарыг мэдээллийн хамрах хугацаа болгож сонгон авахад зарлагын дундаж нь сүүлийн жилийнхээс 150 хувиар илүү байсан. Үүний нэг шалтгаан нь нэг талаас "давших" мартагналаас (эргэн санах хугацаа урт байх тусам өрхүүд зарлагаа эргэн санахад бэрхшээлтэй болох учраас өрхүүдийн хэрэглээ буурч тооцогдох магадлалтай.) Нөгөө талаас "телескопинг" -оос (өрхүүд эргэн санах хугацаанаас өмнөхан авсан зүйлээ ялангуяа тэр нь үнэтэйхэн буюу ач холбогдолтой эдлэл байвал зарлагадаа багтаан оруулах явдал бий тул зарцуулалт нэмэгдэж тооцогдох магадлалтай) үүдэлтэй гэж тайлбарлаж болох юм

бараа, бүтээгдэхүүн худалдан авсан бол тухайн мэдээллийг нь авч, харин сүүлийн нэг сарын хугацаанд хүнсний бус бараа бүтээгдэхүүн худалдан аваагүй бол сүүлийн нэг жилийнх нь мэдээллээс авдаг. Энэ хувилбар нь тухайн өрхийн хэрэглээг илүү бодитой харуулна гэж тооцсон бөгөөд 2002-2003 онд хэрэглэсэн сүүлийн гурван сарын хамрах хугацааг бодвол илүү дээр сонголт гэж үзэж байна.

ӨНЭЗС-нд боловсрол, эрүүл мэндийн тусгай модулиуд багтсан тул эдгээрийн зардлыг тооцох хоёрдахь эх сурвалжийг санал болгож байна.Энэ мэдээлэл нь стандарт хүнсний бус бүрэлдэхүүн хэсгийн модулиас хоёр зүйлээр ялгагдаж байна. Нэгдүгээрт мэдээллийг хувь хүний түвшинд цуглуулж байгаа бол стандарт бүлэгт өрхийн түвшинд цуглуулдаг. Өрхийн түвшинд мэдээлэл цуглуулах үед өрхийн гишүүн бүрээс ижил сэдвийг асууснаас асуулт нь илүү ерөнхий болдог. Ерөнхийдөө бол өрхийн зардлын тухай аль болох дэлгэрэнгүй асуух тусам илүү нарийн мэдээлэл цугладаг учир тусгайлсан модуль ашиглах нь зүйтэй гэж үздэг. Нөгөө талаас энэ хоёр тусгайлсан модулиар зөвхөн нэг судалгааны үеийг буюу боловсролын хувьд сүүлийн 12 сарыг харин эрүүл мэндийн хувьд сүүлийн нэг сарын хугацааг хамруулж байна. Өрхийн аж байдлын дүр төрхийг урт хугацаанд илүү сайн харуулна гэж үзсэн учраас бид тусгайлсан модуль ашиглахаар шийдсэн билээ.

## Удаан эдэлгээтэй бараа

Өрхийн эзэмшиж байгаа удаан эдэлгээт бараа нь амьжиргааны түвшнийг тодорхойлох чухал бүрэлдэхүүн хэсэг болдог. Эдгээр бараа нь удаан хугацаанд ашиглагддаг учир худалдан авсан үнэ нь хэрэглээг тодорхойлох тохиромжтой үзүүлэлт болохгүй. Тооцоо хийх хамгийн зөв арга нь тухайн хугацаанд эзэмшиж байгаа удаан эдэлгээт бараанаас авч байгаа үйлчилгээний түвшинг тооцоход оршино. Энэхүү авч байгаа ханамжийн хэмжээ нь биетээр ажиглагдахгүй ч үнийн дүнтэй шууд пропорциональ бөгөөд элэгдлийн түвшин гэсэн үзүүлэлтээр тодорхойлогдоно. Бараа бүрийн элэгдлийн түвшинг тооцох үйл ажиллагаа ӨНЭЗС-гаар авсан удаан эдэлгээт барааны одооны зах зээлийн үнэ, ашигласан (мэдээлэл нь өрхийн эзэмшиж буй удаан эдэлгээт барааны тоо ширхэгийн хамт цуглуулагдсан) хугацаанд үндэслэнэ.[41]

Энэ бүрэлдэхүүн хэсгийн тооцоог 3 үе шаттайгаар хийнэ. Нэгдүгээрт, удаан эдэлгээт бараанаас хэрэглээний бүрэлдэхүүнд орох нэр төрлийг сонгоно. ӨЭНЭЗС-гаар гэр ахуйн хэрэгслээс эхлүүлээд тавилга хүртэлх 42 нэр төрлийн удаан эдэлгээт барааны талаар мэдээлэл цуглуулсан. Гэхдээ нийт удаан эдэлгээт барааны 1/3 болох өрхийн бизнест ашиглагдах бараа эсвэл үнэт эдлэл, сууц болон “бусад” гэж ангилагдсан бараануудыг тооцоонд оруулаагүй. Хоёрдугаарт, хэрэглээний бүрэлдэхүүнд сонгон оруулсан удаан эдэлгээт барааны хувьд элэгдлийн түвшинг тооцохдоо нэгжийн үнэ ба (хувьсах хэмжигдэхүүн), ашигласан хугацаанд үндэслэсэн шугаман регресс тооцсон. Энэхүү тооцооны арга

[41] Инфляцийн түвшин болон нэрлэсэн хүүгийн түвшинг ашиглан улам боловсронгуй болгож болно

нь нэг барааны хувьд хэрэглэсэн хугацаанаас хамааран өөр, өөр элэгдлийн түвшин бодох боломжийг олгодог. (Жишээ нь удаан эдэлгээт бараа нь шинэ бол элэгдлийн түвшин буюу бараанаас авч буй ханамж өндөр байна.) Эцэст нь хэрэглээг тооцохдоо тухайн барааны нэг жилийн өмнөх үнийг элэгдлийн хувиар үржүүлэн эдгээр хэрэглээг өрхөөр нэгтгэж гаргасан.

## Сууц

Хүмүүсийн амьжиргааны түвшний гол үзүүлэлт нь орон сууцны нөхцөл юм. Хөгжиж байгаа орнуудын хувьд орон сууцны түрээсийн зах зээл хязгаарлагдмал эсвэл байдаггүй учир тооцоо хийх, хэрэглээний бүтцэд оруулахад нэлээд бэрхшээлтэй байдаг. Хэрэглээний бүтцэд оруулах зорилго нь удаан эдэлгээт бараатай адилаар тухайн орон сууцыг эзэмшиж байгаагаас авах ханамжийн хэмжээг тооцож оруулахад оршино. Хэрвээ тухайн өрх байр түрээслэн амьдарч байгаа бол төлбөрийн хэмжээ нь энэ ханамжийн үнэлгээ болно. Монгол орны хувьд орон сууц түрээслэн амьдарч байгаа өрхийн тоо цөөн, мөн түрээсийн өртөг хэтэрхий өндөр байдаг учир уг мэдээлэл дээр үндэслэн өөрийн сууцанд сууж байгаа өрхийн сууцнаасаа авч байгаа ханамжийг хэмжээг буюу түрээсийн зардлыг тооцох боломжгүй юм.[42] Хэдий тийм боловч ӨНЭЗС-гаар тухайн өрх хэрвээ сууцаа түрээслэвэл хэдээр түрээслэх (хийсвэр түрээс) болон орон сууцаа худалдах үнийг нь судалсан. Бодит түрээсийн утга бүртгэгдээгүй тохиолдолд хийсвэр түрээсийн утгыг ашиглан тооцооны түрээс тооцож хэрэглээний иж бүрдэлд оруулж болно. Тооцооны түрээсийн утгыг таамаглаж гаргадаг учраас зарим тохиолдолд ашиглах боломжгүй ч байх талтай.[43] Мөн хүн амын тал орчим хувь нь гэрт амьдардаг тул түрээсийн утгыг тооцоход бүр илүү хүндрэлтэй байсан.

Тооцооны түрээсийн утгыг тооцохын тулд сууцны худалдах үнийг хамааргч хувьсагч болгон сонгож сууцны регресс тооцсон. [44] Үл хамаарах хувьсагчдаар орон сууцны нөхцлийг тодорхойлогч шал, хана, дээврийн үндсэн материалын төрөл, өрөөний тоо, усан хангамж, цахилгаан, дулаан, байршил зэргийг авсан. Орон сууцны төрлөөр гэр, сууцны тусдаа байшин, нийтийн тохилог сууцны хувьд уг тооцоог тус тусад нь хийв. Үр дүнгээс нь харахад орон сууцны худалдах үнийн мэдээлэл нь сууцны нөхцөлтэй нягт хамааралтай буюу илүү бодитой байна. Энэ нь тухайн өрх сууц түрээслэдэггүй боловч сууцны үнийн хувьд өөрсдөө барьсан эсвэл худалдаж авсан байдгаас таамагласан хийсвэр түрээсийн үнээс илүү найдвартай дүнг хэлсэн гэдгээр тайлбарлагдана.

Гэхдээ сууцны үнийг ашиглаж сууцнаас авч байгаа үйлчилгээний тооцоог гаргахад нэмэлт тооцоо хийх буюу сууцны элэгдлийн түвшинг тодорхойлох шаардлагатай болдог. Сууцны тусдаа байшин болон нийтийн тохилог сууц 33 жилийн дараа, гэр 17 жилийн дараа бүрэн элэгдэнэ гэж тооцлоо. Тиймээс хэрэглээний бүтцийг байгуулахадаа бид сууцнаас авч буй үйлчилгээний тооцоонд сууцны үнийг ашиглан бодсон тооцооны хийсвэр түрээсийг оруулсан бөгөөд гэхдээ мэдээж хэрэв бодит

[42] Судалгаанд хамрагдсан 11,172 өрхөөс зөвхөн 183 өрх байна.

[43]. Өрхүүдийн гуравны хоёр нь ийм мэдээлэл өгдөггүй нь бэрхшээл үүсгэдэг.

[44] Арван өрх тутмын ёс нь ийм мэдээлэл өгсөн.

түрээсийн мэдээлэл тухайн өрхийн хувьд байгаа тохиолдолд түүнийг нь ашигласан.

### Түлш, эрчим хүч

Эцсийн анхааран үзэх хүнсний бус хэрэглээний бүрэлдэхүүн хэсэг нь эрчим хүчний буюу голлон халаалт, цахилгааны зардал юм. Монгол Улс бол өвөл нь -40, зун нь +30 хэмийн температурт хүрдэг эрс тэс уур амьсгалтай орон. Хэдийгээр зуны улиралд байгаль цаг уурын нөхцөл харьцангуй тааламжтай хэдий ч өвлийн улирал нь онцгой хүнд нөхцөл үүсгэдэг. Өвлийн улирал бараг 6 сар үргэлжлэн, голдуу хасах градустай байдаг бөгөөд нэг, хоёрдугаар сарын дундаж темпаратур -25 байдаг. Энэ нь орон даяар халаалт болон түлш өрхийн хэрэглээний зайлшгүй, нэн чухал хэрэгцээ болохыг илэрхийлж байгаа бөгөөд зарим тохиолдолд хэрэглээний иж бүрдлийн маш том, чухал бүрэлдэхүүн хэсэг ч болдог.

ӨНЭЗС-гаар зөвхөн худалдан авалт болон өөрсдөө бэлтгэсэн түлш эрчим хүчний зардлыг өрхүүдээр өөрсдөөр нь үнэлүүлэн мэдээллийг нь цуглуулсан. Зарчмын хувьд ийм мэдээлэл нь түлш, эрчим хүчний хэрэглээг бодитойгоор үнэлэхэд хангалттай байх ёстой. Гэвч ингэж чадахгүй байна гэж үзэх үндэслэл бий. Гэтэл өөрсдөө бэлдсэн түлшний тоо хэмжээний талаар ямар ч мэдээлэл байхгүй нөхцөлд энэ хэрэглээний утгыг тооцох боломжгүй болно. Харин өрх халаалт, гэрэлтүүлэгтээ түлш буюу мод, нүүрс, аргал хэрэглэдэг бол худалдан авалтаа мэдээлж харин өөрсдийн бэлтгэсэн түлшээ мэдээлэхгүй орхих нь элбэг. Өөрсдөө бэлдсэн түлшний тоо хэмжээний талаар мэдээлэл олч авч чадаагүй бол хэрэглээг нь ямар нэг байдлаар тооцох боломжгүй болно. Ингэснээр тухайн өрхийн эрчим хүчний хэрэглээ дутуу тооцогдох бөгөөд ялангуяа өрхүүд өөрсдөө түлш бэлдэж халаалтандаа хэрэглэх нь түгээмэл хөдөө нутагт энэ гажуудал бүр өндөр хэмжээнд хүрэх магадлалтай юм.

## Б.3. Үнийн засварлалт

Монголд хүнсний бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл өндөр байдаг. Жишээ нь хаврын улиралд хүнсний бүтээгдэхүүний үнэ бусад улирлыг бодвол харьцангуй өндөр болдог. Түүнчлэн бүс нутгуудын хувьд үнэ харилцан адилгүй байдаг. Ялангуяа бусад бүсүүдтэй харьцуулахад Улаанбаатар хотод зарим бараа, бүтээгдэхүүний үнэ өндөр байдаг. Ийм ч учраас амьжиргааны түвшинг бодитойгоор тооцохын тулд үнийн индексийг ашиглан зарлагын дүнг засварлах шаардлагатай байсан юм. Үнийн индекс нь хоёр үндсэн хэсэгтэй : үнэ болон үнийн тохирох түвшинд харгалзах нийт зардалд зэлэх тухайн бараа бүтээгдэхүүний хувь хэмжээ

буюу хэрэглээний хувийн жин. Энэ нь үнийн индекс нь үнийн түвшин, хэрэглээний бүтэц хоёроос хамааран хувьсдагтай холбоотой юм..

Өрхийн судалгаа нь бүх нэр төрлийн хувьд нийт зардалд эзлэх тухайн бараа, бүтээгдэхүүний хувь хэмжээг, харин зөвхөн хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн хувьд өрхийн төлсөн дундаж үнийн мэдээллийг цуглуулдаг. ӨНЭЗС болон улсын хэрэглэгчийн үнийн индексээс авсан мэдээллийг хослуулан ашиглаж түүврийн анхан шатны нэгжийн түвшинд Паашийн үнийн индексийг тооцлоо. Түүврийн анхан шатны нэгжүүд нь хотод 10 өрхөөс, хөдөөд 8 өрхөөс тогтож байгаа. Нэг түүврийн анхан шатны нэгжид харьяалагдаж байгаа өрхүүдийн хэрэглэдэг бараа, үйлчилгээний үнэ болон хэрэглэгээний бүтэц нь ойролцоо байх магадлалтай.

Түүвэрлэлтийн анхан шатны $i$ нэгж дэх Паашийн үнийн индексийг дараахи томьёогоор тодорхойлно:

$$p_i^{\ P} = \left[ \sum_{k=1}^{n} w_{ik} \left( \frac{p_{ik}}{p_{0k}} \right)^{-1} \right]^{-1} \qquad (1)$$

Энд $w_{ik}$ - түүврийн анхан шатны $i$ нэгжийн $k$ нэрийн барааны төсөвт/хэрэглээнд эзлэх хувийн жин;

$p_{ik}$ - түүврийн анхан шатны $i$ нэгжийн $k$ нэрийн барааны дундаж үнэ (үнийн медиан);

$p_{0k}$ - i нэгжийн $k$ нэрийн барааны улсын дундаж үнийн түвшин (үнийн медиан).

Хүнсний хувьд нэр төрөл тус бүрийн нийт хэрэглээнд эзлэх дундаж хувь хэмжээ нь нэгжийн дундаж үнэтэй нь уялдаж байна. ӨНӨЗС энэ хоёр мэдээллийг хоёуланг нь цуглуулсан. Хүнсний бус бүрэлдэхүүн хэсгийн хувьд төсөвт эзлэх дундаж хувь хэмжээг ӨНЭЗС-гаар, харин дундаж үнийг улсын хүнсний бус барааны үнийн индексээр цуглуулсан. Ингэснээр бүх хүнсний бус бараа бүтээгдэхүүнийг нэг багц болгон авч инфляцийн түвшин бүгдэд нь адилхан байснаар тооцож байгаа юм. Үнийн индексийн эцсийн хувилбар нь хүнсний болон хүнсний бус нэр төрлүүдэд хоёуланд нь цаг хугацааны засварлалт оруулж байгаа боловч газар зүйн байршлын засварлалтыг зөвхөн хүнсний бүтээгдэхүүний хувьд оруулж байна. Хүнсний бус бүтээгдэхүүний хувьд газарзүйн байршлын ямар ч ялгаа байхгүй гэж үзвэл ядуурлын тооцоонд хэрхэн нөлөөлөх нь тодорхойгүй байна. Жишээлбэл, ерөнхийдөө сууцнаас бусад ихэнх хүнсний бус бараа, бүтээгдэхүүний үнэ хөдөөд хотоос илүү өндөр байдаг. Хэрэв үнийн индекс нь газарзүйн байрлалын ялгаа байхгүй гэж үзвэл хөдөө нь хотоос харьцангуй чинээлэг амьдралтай гэж гарахаар байна.

Хүнсний бүтээгдэхүүний дундаж утгууд болон нийт үнийн индексийг сараар болон бүлгээр нь Хүснэгт Б.2-т харуулав. Энэ индексээс амьжиргааны өртөг бусад аль ч нутаг дэвсгэрээс Улаанбаатар хотод илүү өндөр байгааг мөн улирлын нөлөөллийг харж болно. Өөрөөр хэлбэл энэ индекс 1, 2-р улиралд хамгийн өндөр бусад улиралд арай бага байна.

Хүснэгт Б1. Түүврийн анхан шатны нэгжийн Паашийн индекс, бүлгээр, ярилцлага авсан сараар

| | Хүнсний Паашийн индекс | | | | Нийт Паашийн индекс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Улаанбаатар | Аймгийн төв | Хөдөө | Улсын дундаж | Улаанбаатар | Аймгийн төв | Хөдөө | Улсын дундаж |
| 2007 он | | | | | | | | |
| 7 сар | 0.86 | 0.83 | 0.78 | 0.82 | 0.91 | 0.89 | 0.83 | 0.87 |
| 8 сар | 0.91 | 0.83 | 0.80 | 0.84 | 0.95 | 0.90 | 0.84 | 0.89 |
| 9 сар | 0.94 | 0.88 | 0.82 | 0.87 | 0.97 | 0.94 | 0.87 | 0.92 |
| 10 сар | 0.95 | 0.89 | 0.84 | 0.89 | 1.00 | 0.96 | 0.91 | 0.95 |
| 11 сар | 0.98 | 0.91 | 0.89 | 0.92 | 1.01 | 0.99 | 0.93 | 0.97 |
| 12 сар | 1.01 | 0.93 | 0.87 | 0.93 | 1.01 | 0.97 | 0.92 | 0.97 |
| 2008 он | | | | | | | | |
| 1 сар | 1.02 | 0.96 | 0.92 | 0.96 | 1.02 | 0.99 | 0.96 | 0.99 |
| 2 сар | 1.08 | 1.03 | 0.95 | 1.01 | 1.05 | 1.02 | 0.98 | 1.01 |
| 3 сар | 1.12 | 1.08 | 0.98 | 1.05 | 1.07 | 1.05 | 0.99 | 1.03 |
| 4 сар | 1.26 | 1.17 | 1.06 | 1.16 | 1.13 | 1.10 | 1.05 | 1.09 |
| 5 сар | 1.33 | 1.26 | 1.22 | 1.27 | 1.16 | 1.15 | 1.14 | 1.15 |
| 6 сах | 1.36 | 1.26 | 1.19 | 1.26 | 1.18 | 1.15 | 1.12 | 1.15 |
| Дундаж | 1.07 | 1.00 | 0.94 | 1.00 | 1.04 | 1.01 | 0.96 | 1.00 |

*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-08*

## Б.4. Өрхийн бүтцийн засварлалт

Аж байдлын үзүүлэлтийг бий болгох эцсийн шат нь өрхийн түвшинд тодорхойлогдсон амьжиргааны түвшний хэмжигдэхүүнүүдийг нэг хүнд ногдох хэмжээнд шилжүүлэх явдал бөгөөд зэрэгцүүлэлтийг өрхөөр биш хувь хүнээр хийдэг. Эрүүл мэнд, боловсролоос бусад зардлыг өрхийн түвшинд цуглуулсан байдаг тул хувь хүний аж байдлын түвшинг тооцохын тулд өрхийн нийт хэрэглээг тухайн өрхийн нийт ам бүлийн тоонд харьцуулан тооцно. Өрхийн гишүүн бүр ижил хувь хэрэглэнэ гэж үзсэн нэгдсэн практик байдаг бөгөөд үүнийг дараа тайлбарлана.

Хэрэглээний бүтэц, хэмжээг 2 аргаар засварладаг. Нэгдүгээрт, өрхийн ам бүлийн бүтцийн засварлалт. Өрхийн гишүүд, тэдгээрийн нас, хүйс, онцлогоос хамааран янз бүрийн хэрэгцээ, шаардлагатай байдаг боловч өөр онцлогуудыг бас авч үзэж болно. Жишсэн хүнд шилжүүлэх арга нь эдгээр ялгаатай байдлыг харгалзан өрхийн гишүүдийг "жишсэн насанд хүрсэн" гэж томьёолсон нэг хэмжээст шилжүүлдэг. Жишээ нь : хүүхдийн хэрэглээ насанд хүрсэн хүнийхээс бага гэж үзвэл ам бүлийн тоо, хэрэглээний түвшин адилхан 2 өрхийн нэг нь хүүхэдтэй, нөгөө нь дан насанд хүрсэн хүмүүстэй бол хүүхэдтэй өрхийн нэг хүнд ногдох амьжиргааны түвшин илүү дээр байна. Харамсалтай нь шилжүүлэх коеффициентийг тооцох нэгдсэн аргачлал байдаггүй. Зарим нь хоол тэжээлийн хэрэглээнд үндэслэн тооцоо хийж, хүүхэд, насанд хүрсэн хүний хүнсний хэрэглээний 50 хувийг л хэрэглэдэг гэж тооцсон байдаг боловч хүнсний бус хэрэглээний хувьд адилхан хэмжүүр хэрэглэх нь тодорхой бус юм. Хүүхэд боловсрол, хувцас хунарт харьцангуй их зардал гаргадаг байж болох талтай. Зарим арга нь өрхийн хэрэглээний бүтцэд

үндэслэсэн байдаг хэдий ч шинжилгээнд ашиглахад төдийлөн бүрэн эх сурвалж болж бас чаддаггүй.[45]

Хоёр дахь засварлалт нь хэрэглээнд байгаа эдийн засгийн хэмжүүрийг засварлахад оршино. Үүнийг хэрэглэх шалтгаан нь өрхийн хэрэглэсэн зарим бараа, үйлчилгээ "нийтийн бараа" гэсэн онцлогтой байдаг. Өрхийн нэг гишүүний тухайн барааг хэрэглэх нь нөгөө нэг гишүүний хэрэглэх боломжийг хаахгүй бол тухайн барааг нийтийн гэнэ. Эдгээр барааны жишээ бол сууц, удаан эдэлгээт бараа юм. Жишээ нь: өрхийн нэг гишүүний телевизор үзэх нь нөгөө гишүүнийг үзэхийг хориглохгүй. Үүнийг харгалзан үзвэл олон ам бүлтэй өрх, цөөн ам бүлтэй өрхийг бодоход илүү амьжиргааны түвшинтэй болж харагдах магадлалтай юм. Тиймээс өрхийн хэрэглээнд эзлэх нийтийн хэрэглээний барааны хувь өндөр байх тусам эдийн засгийн хэмжүүр их байна. Нөгөө талаас хувийн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнийг өрхийн нэг гишүүн хэрэглэсэн бол нөгөө гишүүн хэрэглэх боломжгүй байдаг. Хүнсний бүтээгдэхүүн нь хувийн хэрэглээний сонгомол жишээ юм. Ядуу эдийн засагтай орны хувьд хүн амын хэрэглээний түвшинд хүнсний эзлэх хувь өндөр байдаг тул эдийн засгийн хэмжүүр бага байдаг. Дээрх 2 төрлийн хэмжүүрийн засварлалтыг доорх аргаар хийнэ.

$$AE = (A + \alpha K)^{\theta}$$

Энд AE -өрхийн жишсэн ам бүлийн тоо. A – насанд хүрсэн хүний тоо. K-хүүхдийн тоо, $\alpha$ -хүүхдийг насанд хүрэгчтэй харьцуулсан харьцангүй өртгийг хэмжих параметр, $\theta$ -эдийн засгийн хэмжүүрийн зэрэг.[46]
Энэ 2 параметрийн утга нь 0-1 ийн хооронд байна. Хөгжиж байгаа орны хувьд хүүхдийн хэрэглээний түвшин насанд хүрсэн хүнийхтэй харьцуулахад доогуур байдаг учир $\alpha$ – гийн түвшин доогуур ойролцоогоор 0.3 байдаг бол хөгжингүй орны хувьд 1-тэй ойролцоо байдаг.[47] Үүний зэрэгцээ ядуу улс орны хувьд хувийн хэрэглээний үндсэн хэсэг болох хүнсний хэрэглээ нь нийт өрхийн хэрэглээний дийлэнх хувийг эзэлдэг учир нийтийн хэрэглээний барааны эзлэх хувь бага, эдийн засгийн хэмжүүр $\theta$ нь 1-д дөхөж очдог бол баян орны хувьд 0.75 байдаг.

Практикт өрхийн ам бүлийн бүтцийг засварлахад нэг хүнд шилжүүлэх зохицуулалт хийдэг гэдгийг дээр дурдсан бөгөөд энд ч энэ стандартыг дагасан. Энэ нь $\alpha$ болон $\theta$-гийн түвшин хоёул нэгтэй тэнцүү буюу хүүхдийн хэрэглээ, насанд хүрсэн хүний хэрэглээнээс ялгаагүй, эдийн засгийн хэмжүүр байхгүй гэж үзсэн дээрх томьёоны тухайн тохиолдол юм. Өөрөөр хэлбэл гишүүн бүрийн хэрэглээний нийт хэрэглээнд эзлэх хувь адилхан хэмжээтэй, өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тусам зардлын түвшин нэмэгдэнэ гэсэн үг юм. Нэг хүнд ногдох хэрэглээний түвшингээр тооцоо хийснээр олон ам бүлтэй, хүүхэдтэй өрхийн амьжиргааны түвшин

[45] 45 Диатон, Мюлбаири (1986) болон Диатонийг (1997) хар.
[46] Хэрвээ жишсэн хүнд шилжүүлэх мэдрэмж нь "бодит хэмжээс" бол (A+$\alpha$K) нь $\theta$ болно. Эдийн засгийн хэмжүүр нь 1-$\theta$ байна. Эдгээр параметрүүд нь 0-ээс 1 байна.
[47] Диатон болон Зайди (2002)

цөөн ам бүлтэй, хүүхэдгүй өрхтэй харьцуулахад байгаагаасаа доогуур тооцогддог. Үүнд эдийн засгийн болон хүүхдийн өртгийн янз бүрийн хувилбарыг сонгож, ядуурлын үзүүлэлт, түүний дэс дараалал хэрхэн өөрчлөгдөж байгааг судлах нь мэдрэмжийн дүн шинжилгээ хийхэд чухал юм.

## Б.5. Ядуурлын шугам

Ядуурлын шугам нь тодорхой өгөгдсөн цаг хугацаа, оршин байгаа орчинд хувь хүний амьжиргааны түвшинг мөнгөн дүнгээр илэрхийлсэн утга юм (Раваллион 1998). Хэрвээ хэн нэгэн амьжиргааны стандарт доод түвшнээс доогуур хэрэглээтэй бол уг хүнийг ядуу гэж тооцно. Ядуурлын түвшнийг тодорхойлох нь нэлээд бэрхшээлтэй байдаг. Учир нь “амьжиргааны доод түвшин” гэдэгтэй зарим хүмүүс санаа нийлдэггүй. Ядуурлын шугам нь ядуурлыг хянах, түүний талаар бодлого боловсруулахад нөлөөлдөг.

Ядуурлын шугам абсолют (туйлын) байна. Учир нь өгөгдсөн аж байдлын түвшин буюу амьжиргааны түвшин судалгааны суурьшлуудад тогтмол байдаг. Энэ нь цаг хугацааны болон хувь хүмүүсийн хоорондох харьцуулалтыг тогтвортой болгодог. Өөрөөр хэлбэл аж байдлын адилхан түвшинтэй хоёр хүн амьдарч байгаа суурьшлаасаа шалтгаалахгүйгээр адилхан харьцуулагдана. Хоёрдугаарт, шаардлагатай хэрэглээний түвшинг заавал тооцож оруулах хэрэгтэй. Ерөнхийдөө хоол тэжээлийн хэрэгцээг тооцдог бөгөөд тухайлбал эрүүл, идэвхитэй амьдралыг хангахуйц илчлэгийг авч байх ёстой. Эцэст нь, ядуурлын шугам нь энэ шаардлагыг хангах хамгийн бага зардал байхаар тогтоогдоно.

Хүнсний тэжээллэг байдалд үндэслэсэн ядуурлын шугамыг тооцоход үндсэн хэрэгцээний зардлын аргыг хэрэглэсэн. Энэ арга нь үндсэн хэрэглээнд хангалттай гэж үзсэн хэрэглээний сагсанд зарцуулах зардлыг тооцдог. Хэрвээ тухайн хүн уг сагсны зардлыг гаргах чадваргүй бол ядууд тооцогдоно. Нэгдүгээрт, ядуурлын байдал нь тухайн хүн уг хэрэглээний сагсыг авч чадах хөрөнгөтэй эсэхэд анхаарч байхаас биш бодит хэрэглээ нь эдгээр шаардлагыг хангаж байгаа эсэхэд хамаарахгүй гэдгийг санах хэрэгтэй. Хоёрдугаарт, хоол тэжээлийн үзүүлэлтүүдийг хэрэглээний түвшинг тодорхойлоход хэрэглэсэн боловч энэ нь аж байдлын үзүүлэлт биш юм. Эсрэгээр нь үүнийг хүнсний зүйлээс авч буй илчлэгийн хэмжээг тооцоход хэрэглэх бөгөөд ямар ч зардлын тооцоо шаардлагагүй. Гуравдугаарт, хэрэглээний сагсыг нормативаар эсвэл түгээмэл тархсан хэрэглээний бүтцийг тусган байгуулж болно. Түгээмэл тархсан хэрэглээний бүтцийг тусгаж байгуулах нь илүү сайн хувилбар юм. Эцэст нь ядуурлын шугам бол хүнс ба хүнсний бус гэсэн хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

## Хүнсний бүрэлдэхүүн хэсэг

Энэ бүрэлдэхүүн хэсгийг байгуулах эхний алхам нь эрүүл, идэвхитэй амьдралыг хангахад шаардлагатай хүнс тэжээлийн хэмжээг тодорхойлох юм. Мэдээж, хүний эрүүл, идэвхитэй амьдрал гэж юуг хэлэх, үүнийг илчлэгийн хэмжээгээр хэрхэн тодорхойлох нь түвэгтэй асуудал юм. Ихэнхдээ нэг хүний хоногт авч байх ёстой илчлэгийн хэмжээг 2100 калори байхаар жишиг болгож авдаг. Хоёрдугаарт, хүнсний сагсыг сонгох ёстой. Онолын хувьд хүнсний төгсгөлгүй олон янзын сагсаар дээрх илчлэгийн хэмжээг авч болно. Эдгээрээс нэг арга нь тухайн орны жишиг болгон авч байгаа хүн амын хүнсний хэрэглээний бүтцийг харгалзан тогтоодог арга юм. Энэ судалгаанд дээрх аргыг ашиглан, нийт хүн амыг нэг хүнд ногдох хэрэглээгээр нь эрэмбэлэн, доод хэрэглээтэй 40 хувийн хүн амын дундаж хүнсний сагсыг сонгон авсан. Ядуу өрхийн хэрэглээг илүү төлөөлөн илэрхийлдэг учир амьжиргааны түвшний тархалтын хамгийн доод хэсгийн хүн амын хүнсний хэрэглээний сагсыг сонгон авах нь илүү байдаг. Иймээс жишиг болгон авч байгаа хүн ам нь ядуурлын түвшний эхний таамаглал юм. Гуравт, хүнсний сагсыг илчлэгийн хэмжээгээр тодорхойлохдоо хүнсний бүтээгдэхүүний илчлэгийн үзүүлэлтийг ашиглана. Энэ үзүүлэлтийг Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс тогтоодог. Архи, тамхи, өрхөөс гадуур хэрэглэсэн хүнсний хэрэглээг энэхүү тооцооноос хассан. Учир нь архи, тамхи нь зайлшгүй хэрэглээ биш, мөн өрхөөс гадуур хэрэглэсэн хүнсний зүйлийн илчлэгийн хэмжээг тодорхойлоход маш их бэрхшээлтэй билээ. Дөрөвт, нэг калорийн голч үнийг тооцож хүнсний сагсыг үнэлэхэд ашиглана. Нэгжийн үнийг тооцохдоо зөвхөн жишиг болгон авсан хүн амын мэдээлэлд тулгуурлав. Энэ нь ядуучуудын худалдан авч байгаа үнийг илүү сайн илэрхийлэх болно. Тавдугаарт, хүнсний сагсны дундаж илчлэгийн хэмжээг тооцсон бөгөөд ингэснээр хүнсний сагсыг хоногт 1 хүн 2100 калори авахаар хувиарласан. Тухайлбал, Монгол Улсын нийт өрхийн хамгийн бага хэрэглээтэй 40 хувийн нэг хүнд ногдох хоногийн дундаж илчлэгийн хэмжээ 1430 калори, нэг хүний хоногийн хүнсний сагсны зардал 789 төгрөг байсан. Иймээс нэг хүнд ногдох хоногийн хүнсний ядуурлын шугам 1,158 төгрөг ( = 789 төгрөг x 2,100 калори / 1,430 калори) байна. Хүснэгт Б.2-т гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний илчлэгийн түвшин, хүнсний ядуурлын шугамд эзлэх хувийг тодорхойлов.[48]

[48] Хүнсний нэр төрлөөр нь харуулсан илүү дэлгэрэнгүй хүснэгтийг хавралтын төгсгөлд өгөв.

**Хүснэгт Б.2. Нэг хүнд хоногт ногдох хүнсний сагс, хүнсний гол нэрийн бүлгээр**

| | Хоногийн илчлэг | | Үнэ | |
|---|---|---|---|---|
| | Илчлэг | % | Төгрөг | % |
| Нийт | 2,100 | 100 | 1,159 | 100 |
| Гурил, гурилан бүтээгдэхүүн | 1,270 | 60 | 304 | 26 |
| Мах, махан бүтээгдэхүүн | 222 | 11 | 471 | 41 |
| Загас, далайн бүтээгдэхүүн, | 0 | 0 | 1 | 0 |
| Сүү, цагаан идээ, өндөг | 179 | 9 | 169 | 15 |
| Төрөл бүрийн өөх тос | 228 | 11 | 68 | 6 |
| Жимс, жимсгэнэ | 5 | 0 | 9 | 1 |
| Хүнсний ногоо | 67 | 3 | 52 | 5 |
| Чихэр, жимсний чанамал | 106 | 5 | 38 | 3 |
| Хүнсний бусад бүтээгдэхүүн | 4 | 0 | 10 | 1 |
| Цай, кофе | 8 | 0 | 15 | 1 |
| Цэвэр ус, ундаа, жимсний шүүс | 4 | 0 | 7 | 1 |
| Согтууруулах ундаа | 6 | 0 | 15 | 1 |

*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-08*

**Хүнсний бус бүрэлдэхүүн хэсэг**

Ядуурлын шугамын хүнсний бус бүрэлдэхүүнд ямар төрлийн бараа, бүтээгдэхүүнийг оруулах вэ гэдэг дээр санал маш их зөрөлдөөнтэй байдаг. Гэхдээ энэ бүрэлдэхүүн хэсгийг хүнсний хэсгийг сонгоход хэрэглэсэн норматив ойлголттой холбох хэрэгтэй. Эрүүл байж, нийгмийн амьдралд оролцох боломжтой байхын тулд байр сууц, хувцас, эрүүл мэнд, амралт, чөлөөт цаг зэрэгт зардал гаргах шаардлагатай болдог. Ихэнхи тохиолдолд хүнсний ядуурлын шугамыг шаардлагатай хүнсний бус зүйлсийг оруулахаар өсгөнө. Хүнсний ядуурлын шугамыг хүнсэнд зарцуулсан зардлын эзлэх хувийн зарим тооцоонд хувааж гаргана. Энэхүү аргын гол давуутай тал нь жишиг болгож буй хүн амын хэрэглээний бүтцэд тулгуурлан хүнсний бус сагсыг тогтоодог бөгөөд хүнсний бус сагсыг урьдчилан тооцох шаардлагагүй.

Эхний алхамд ядуучуудыг төлөөлөх жишиг бүлгийг сонгож хүнсний бус зүйлд уг бүлгийн гаргаж буй зардлыг тооцоолох хэрэгтэй. Дэлхийн банкны арга зүйг ашиглан хүнсний бус ядуурлын хоёр шугам байгуулж болдог. Өөрөөр хэлбэл хүнсний бус ядуурлын дээд шугам гэдэг нь хүнсний хэрэглээ нь хүнсний ядуурлын шугамтай ойролцоoo хүн амын хүнсний бус зүйлийн дундаж хэрэглээ юм. Энэхүү дээд жишгээр хүн амын бүлэг сонгон авч байгаа нь хэрэв тухайн хүн эрүүл амьдарч, тодорхой түвшний үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай зардлыг хүнсэндээ гаргаж байгаа бол мөн амьдрахын тулд зайлшгүй шаардлагатай хүнсний бус бараа, үйлчилгээг хэрэглэдэг гэсэн таамаглалд тулгуурладаг. Нөгөө талаас хүнсний бус ядуурлын доод шугам нь нийт хэрэглээ нь хүнсний ядуурлын шугамтай ойролцоо хүн амын хүнсний бус зүйлийн дундаж хэрэглээ юм. Үүний цаад агуулга нь хэрэв тухайн хүн эрүүл амьдрахад шаардлагатай зардлыг хүнсэндээ гаргаж байгаа бол мөн амьдрахын тулд

зайлшгүй шаардлагатай хүнсний бус зүйлийг хэрэглэдэг гэсэн таамаглалд тулгуурладаг. Хэрэв энэ хүмүүс хүнснийхээ үндсэн хэрэгцээний зарим хэсгээс татгалзаж түүнийгээ хүнсний бус зүйлд зарцуулж байгаа бол энэ нь мөнгөн дүнгээрээ хүнсний бус зүйлийн зайлшгүй шаардлагатай хамгийн бага зардал гэж бид үзэж байгаа учраас энэ доод жишиг бүлгийг сонгон авч хүнсний бус доод ядуурлын шугамыг тооцоолон гаргадаг.

Хүнсний бус ядуурлын шугамыг тооцоходоо энэ хоёр дээд болон доод жишиг бүлэг тус бүрийн дундаж хэрэглээг биш харин хүнсний хувийн жинг нь ашигладаг өөр нэг арга байдаг. Хүнсний хувийн жинг хоёр өөр аргаар тооцож болно. . Нэгдүгээрт, Энгелийн муруйг тооцох эконометрик аргачлал буюу хүнсний зардал, нийт зардлын хоорондын хамаарлаар тооцно. Нөгөөх нь Равалианы боловсруулсан энгийн параметрт бус тооцооны арга юм. Энэ аргын давуу тал нь Энгелийн муруйн тооцоонд функцын томьёонд үндэслэсэн ямар ч тооцоо хийгдэхгүй бөгөөд хүнсний ядуурлын шугаман хамаарлаар буурах (өөрөөр хэлбэл ядуурлын шугамтай ойр байх тусам тухайн өрхийн хувийн жин их байна) давуу талтай.

Тухайлбал, дээд ядуурлын шугамын хувьд нэгдүгээрт, хүнсний ядуурлын шугамаас нэмэх, хасах нэг хувийн хооронд хүнсний хэрэглээтэй өрхийн хүнсний хувийн жинг тооцно. Үүнийг нэмэх, хасах хоёр хувь, гурван хувь гэх мэтээр арван хувь хүртэл давтан үйлдэнэ. Хоёрдугаарт, эдгээр арван хувийн жинг дундажлан ядуурлын шугамын хүнсний хувийн жинг эцэслэн тооцно. Эцэст нь, хүнсний ядуурлын шугамыг энэ хүнсний хувийн жинд хувааж дээд ядуурлын шугамыг хялбархан тооцоолно. Доод ядуурлын шугамын хувьд арга зүй нь төстэй боловч хоёр ялгаа бий. Нэгдүгээрт нийт хэрэглээ нь хүнсний ядуурлын шугамтай тэнцүү хүн амыг жишиг бүлгээр сонгодог. Хоёрдугаарт хүнсний хувийн жинг хоёроос хасаад хүнсний ядуурлын шугамаар үржүүлэхэд доод ядуурлын шугам гарна. [49]

Энэ тайланд танилцуулж байгаа ядуурлын шугамыг дээд, доод ядуурлын шугамуудын хослол гэж үзэж болно. Нийт хэрэглээ нь шаардлагатай хүнсий хэрэглээтэй ойролцоо хүн амын хүнсний бус хэсгийг авч тооцоолдог учраас доод ядуурлын шугамыг туйлын доод босго гэж тооцдог. Нөгөө талаас нэгэнт хүнсний үндсэн хэрэгцээ хангагдчих юм бол хүнсний хэрэглээ нь нийт хэрэглээтэй шууд хамааралтайгаар өсөхгүй учраас дээд ядуурлын шугаманд хүнсний бус бүрэлдэхүүн хэсэг нь шаардлагагүйгээр илүү тооцогдох магадлал бий. Өөрөөр хэлбэл хэрэглээний тархалтын харьцангуй дээгүүр хэсэгт байрладаг бөгөөд ядууд тооцогдохгүй хүн амын хэрэглээний дүр төрхийг хүнсний бус бүрэлдэхүүн хэсэг нь илэрхийлэх хандлага үүсдэг. Энэхүү тайланд ашигласан ядуурлын шугамын хүнсний бүрэлдэхүүн хэсэг нь дээд, доод ядуурлын шугамуудын хүнсний бүрэлдэхүүн хэсгүүдийн дундаж тул энэ ядуурлын шугамыг энэ хоёр ядуурлын шугамын дундаж шугам гэж үзэж болно. Хүснэгт Б.3-д энэ гурван ядуурлын шугамын хүнсний болон хүнсний бус бүрэлдэхүүн хэсгүүдийг харуулав. Хэдийгээр тайлангийн

---

[49] Say FZ нь хүнсний ядуурлын шугам, FSu нь дээд жишиг бүлгийн хүнсний хувь харин FSl нь доод жишиг бүлгийн хүнсний хувь байг. Тэгвэл дээд ядуурлын FZ/FSu, доод ядуурлын шугамыг FZ*(2-FSl) томъёогоор бодно.

турш энэ дундаж ядуурлын шугамыг ашигласан хэдий ч доод болон дээд ядуурлын шугамуудыг ашигласан тооцооллыг Хавсралт В-д үзүүллээ.

**Хүснэгт Б.3. Нэг хүнд сард ногдох ядуурлын шугам**

| | Доод ядуурлын шугам | | Дунд ядуурлын шугам | | Дээд ядуурлын шугам | |
|---|---|---|---|---|---|---|
| | Төгрөг | % | Төгрөг | % | Төгрөг | % |
| Хүнсний | 35,239 | 70 | 35,239 | 56 | 35,239 | 42 |
| Хүнсний бус | 15,369 | 30 | 27,256 | 44 | 48,574 | 58 |
| Нийт | 50,607 | 100 | 62,494 | 100 | 83,813 | 100 |

*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-08*

## Б.6. Ядуурлын хэмжүүрүүд

Ядуурлын хэмжүүрийн талаар олон ном, товхимол байдаг хэдий ч Фостер, Грээр, Торбек нарын 1984 онд боловсруулсан ядуурлын хэмжүүрийг түлхүү ашигладаг. Үүнийг дараах нэгдсэн томьёогоор тооцдог

$$P_\alpha = (1/n)\sum_{i=1}^{q}\left(\frac{z-y_i}{z}\right)^\alpha$$

энд: $\alpha$- сөрөг бус параметр, z – ядуурлын шугам, y – хэрэглээ, i - хувь хүн, n –ерөнхий олонлогт байгаа нийт хүн амын тоо, q- ядуурлын шугамаас доош хэрэглээтэй хүний тоо

Ядуурлын хамралтын хүрээний индекс ($\alpha$=0) нь нийт хүн амд эзлэх ядуучуудын хувь бөгөөд энэ нь ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын эзлэх хувийг үзүүлнэ. Энэ нь ядуурлыг хэмжих хамгийн энгийн бөгөөд тайлбарлахад амархан үзүүлэлт учраас хамгийн өргөн хэрэглэгддэг ядуурлын хэмжүүр юм. Гэсэн ч үүнд зарим дутагдалтай тал бий. Уг үзүүлэлт нь ядуу хүмүүсийн хэрэглээний түвшин ядуурлын шугамаас хэр зэрэг хол байгаа болон ядуучуудын дунд хэрэглээний тархалт ямар байгааг үзүүлж чаддаггүй. Ядуурлын гүнзгийрлийн индекс нь ($\alpha$=1) ядуурлын шугамаас ядуучуудын хэрэглээ хэр зэрэг доогуур байгааг илэрхийлнэ. Хэрэглээний дутагдал их байх тутам гүнзгийрэл өндөр байх бөгөөд ядуурлын хамралтын хүрээний индексийн эхний дутагдалтай талыг засна. Эцэст нь ядуурлын мэдрэмжийн индекс ($\alpha$=2) нь ядуучуудын дундах хэрэглээний тархалтын мэдрэмж бөгөөд ядуучуудын хоорондоо хийсэн шилжүүлэг нь ядуурлын индекс, ядуурлын гүнзгийрлийг өөрчлөхгүй, харин мэдрэмжийг өөрчилнө. Тухайн ядуу хүний хувьд ядуурлын гүнзгийрэл их байх тутам ихээр жигнэнэ гэсэн үг юм.

Эдгээр хэмжүүр нь зарим давуу талуудтай. Нэгдүгээрт, хувь хүний амьжиргааны үзүүлэлтийг нэгдсэн ядуурлын хэмжүүртэй уялдуулах

боломж олгоно. Хоёрдугаарт, нэгдсэн ядуурлын түвшин нь нийт хүн амын бүлгүүдийн жин тооцсон ядуурлын түвшингүүдийн нийлбэртэй тэнцүү гэдэг санаагаар эдгээр хэмжигдэхүүнүүд аддитив буюу нийлбэрчилж болдог шинж чанартай. Гуравт, ядуурлын гүнзгийрэлтийн болон мэдрэмжийн индексүүдээр хэдийгээр ядуу хүн амын тоо өөрчлөгдөхгүй байсан ч ядуу өрхийн амьжиргаа буурвал ядуурлын хэмжүүр өснө гэсэн зарчмыг хангана. Дөрөвт, ядуурлын мэдрэмжийн индекс нь ядуурлын түвшинд ядуучуудын дундаж хэрэглээ нөлөөлөөд зогсохгүй бас хэрэглээний тархалт нөлөөлнө гэсэн аксиомыг мөрддөг. Ялангуяа, ядуу өрхөөс чинээлэг өрхөд хэрэглээ шилжихэд ядуурлын түвшин өснө. [50]

Эцэст нь тэмдэглэхэд, энэ илтгэлд ядуурлын бүх үзүүлэлт стандарт алдааны хамт хэвлэгдсэн. Бүх тооцоо нь тооллогын бус түүврийн үндсэн дээр тооцогдсон тул стандарт алдаа нь түүврийн зохиомжийн элементүүд болох бүлэглэлт, түүврийн анхан шатны нэгж болон түүврийн жинг тусгах ёстой.[51] Ядуурлын харьцуулалт хийхдээ эдгээрийг орхигдуулах нь нийт хүн ам буюу эх олонлогийн түүврээр үүссэн ялгаатай байдлыг түүврийн үйл явцын ялгаатай холих аюултай. Хавсралт Д-д ядуурлын үндсэн үзүүлэлтийн хувьд итгэмжлэгдэх интервал, түүврийн аргын нөлөөллийг үзүүлэв.

[50] Энгийн болон шилжүүлэх аксиомыг Сэн 1976 онд зохиосон.
[51] Илүү дэлгэрэнгүйг Ховес болон Ланжоун (1997) –аас харж болно.

**Хүснэгт Б.4. Нэг хүнд ногдох хоногийн хүнсний сагс**

| | Нэгжийн илчлэг (ккал) | Шаардлагатай тоо хэмжээ | Авсан илчлэг | Нэгжийн үнэ (төгрөг) | Үнэ (төгрөг) |
|---|---|---|---|---|---|
| Нийт | | | 2,100 | | 1,159 |
| Гурил, гурилан бүтээгдэхүүн | | | | | |
| Талх (1 ширхэг = 670 гм) - ширхэг | 1,589 | 0.121 | 192 | 468 | 57 |
| Цагаан будаа, кг | 3,447 | 0.056 | 192 | 709 | 40 |
| Гурил, дээд зэрэг-кг | 3,617 | 0.006 | 21 | 808 | 5 |
| Гурил, 1-р зэрэг-кг | 3,250 | 0.206 | 669 | 705 | 145 |
| Гурил, 2-р зэрэг-кг | 3,474 | 0.012 | 42 | 587 | 7 |
| Бусад гурил-кг | 3,742 | 0.000 | 1 | 798 | 0 |
| Дотоодын гоймон-кг | 3,505 | 0.004 | 16 | 1,111 | 5 |
| Импортын гоймон-кг | 3,623 | 0.002 | 7 | 1,237 | 2 |
| Гурилан боов-Кг | 4,050 | 0.030 | 122 | 1,228 | 37 |
| Жигнэмэг-Кг | 2,508 | 0.001 | 3 | 1,640 | 2 |
| Бялуу-Кг | 3,096 | 0.001 | 2 | 5,066 | 3 |
| Шар будаа-Кг | 3,513 | 0.001 | 4 | 660 | 1 |
| Бусад будаа-Кг | 3,455 | 0.000 | 1 | 863 | 0 |
| Мах, махан бүтээгдэхүүн | | | | | |
| Хонины мах-кг | 1,083 | 0.083 | 90 | 2,700 | 225 |
| Үхрийн мах-кг | 1,531 | 0.034 | 52 | 2,831 | 96 |
| Ямааны мах-кг | 1,057 | 0.023 | 24 | 2,214 | 51 |
| Адууны мах-кг | 911 | 0.016 | 15 | 2,091 | 34 |
| Тэмээний мах-кг | 1,025 | 0.001 | 1 | 2,126 | 2 |
| Борц-кг | 4,292 | 0.004 | 19 | 8,894 | 39 |
| Тахианы мах-кг | 1,908 | 0.000 | 0 | 3,382 | 0 |
| Гахайн мах-кг | 3,554 | 0.000 | 0 | 3,331 | 0 |
| Гахайн утсан мах- Kg | 4,580 | 0.000 | 0 | 4,806 | 0 |
| Ангийн мах-кг | 1,788 | 0.001 | 1 | 724 | 0 |
| Бусад шувууны мах-кг | 1,908 | 0.000 | 0 | 1,653 | 0 |
| Дотор мах, цувдай-кг | 1,057 | 0.012 | 12 | 1,241 | 14 |
| Хиам-кг | 2,666 | 0.002 | 7 | 2,988 | 7 |
| Зайдас-кг | 1,680 | 0.000 | 0 | 2,732 | 0 |
| Лаазалсан мах-кг | 2,250 | 0.000 | 1 | 2,557 | 1 |
| Загас, далайн бүтээгдэхүүн | | | | | |
| Загас-кг | 821 | 0.000 | 0 | 2,411 | 1 |
| Хатаасан, утсан, давсалсан загас-кг | 2,600 | 0.000 | 0 | 2,226 | 0 |
| Лаазалсан загас-кг | 1,965 | 0.000 | 0 | 3,285 | 0 |
| Сүү, цагаан идээ, өндөг | | | | | |
| Сүү-литр | 671 | 0.169 | 113 | 691 | 117 |
| Тараг-литр | 564 | 0.030 | 17 | 684 | 21 |
| Өндөг-ширхэг | 78 | 0.014 | 1 | 190 | 3 |
| Ааруул-кг | 4,908 | 0.004 | 21 | 2,640 | 11 |
| Гүүний айраг-литр | 487 | 0.006 | 3 | 860 | 5 |
| Аарц-кг | 2,566 | 0.004 | 11 | 769 | 3 |
| Дотоодын бяслаг-кг | 4,733 | 0.001 | 3 | 1,906 | 1 |
| Бяслаг-кг | 3,040 | 0.000 | 0 | 5,384 | 0 |
| Ээзгий, Кг | 4,010 | 0.000 | 2 | 1,736 | 1 |
| Хуурай сүү-Кг | 3,293 | 0.001 | 2 | 3,810 | 2 |
| Өтгөрүүлсэн сүү-кг | 4,850 | 0.000 | 2 | 2,055 | 1 |
| Цөцгий-Кг | 2,495 | 0.002 | 4 | 2,650 | 5 |
| Хуурай өндөг-кг | 5,441 | 0.000 | 0 | 1,629 | 0 |
| Төрөл бүрийн өөх, тос | | | | | |
| Цөцгийн тос-кг | 5,323 | 0.005 | 27 | 2,533 | 13 |
| Маргарин-Кг | 7,448 | 0.000 | 0 | 2,167 | 0 |
| Ургамлын тос-кг | 8,991 | 0.011 | 95 | 2,395 | 25 |
| Өөхөн тос-кг | 8,991 | 0.009 | 77 | 1,537 | 13 |
| Цөцгийн тос-кг | 3,835 | 0.005 | 17 | 2,519 | 11 |
| Өрөм, шар тос-кг | 8,415 | 0.001 | 12 | 3,579 | 5 |
| Оливийн тос-литр | 8,991 | 0.000 | 0 | 11,893 | 0 |
| Жимс, жимсгэнэ | | | | | |
| Алим-Кг | 468 | 0.006 | 3 | 1,029 | 6 |
| Мандарин-Кг | 376 | 0.001 | 0 | 1,295 | 1 |
| Үзэм-Кг | 716 | 0.000 | 0 | 1,854 | 1 |
| Байгалийн жимс-кг | 398 | 0.000 | 0 | 1,700 | 0 |
| Хатаасан жимс-Кг | 2,721 | 0.000 | 1 | 1,627 | 0 |
| Самар-кг | 5,980 | 0.000 | 1 | 1,444 | 0 |
| Хүнсний ногоо | | | | | |
| Төмс-кг | 877 | 0.061 | 54 | 450 | 28 |
| Байцаа--кг | 140 | 0.011 | 2 | 590 | 7 |
| Лууван-кг | 224 | 0.009 | 2 | 528 | 5 |
| Манжин-кг | 208 | 0.003 | 1 | 537 | 2 |
| Сонгино-кг | 336 | 0.011 | 4 | 595 | 7 |
| Сармис-кг | 1 | 0.239 | 0 | 1 | 0 |
| Улаан лооль-кг | 260 | 0.000 | 0 | 1,530 | 0 |
| Өргөст хэмх-кг | 142 | 0.001 | 0 | 1,296 | 1 |
| Пүнтүүз-кг | 3,272 | 0.001 | 4 | 1,259 | 2 |
| Лаазалсан өргөст хэмх-кг | 164 | 0.000 | 0 | 1,507 | 1 |
| Ногооны савласан салат-кг | 1,120 | 0.000 | 0 | 2,078 | 1 |
| Чинжүү-кг | 220 | 0.000 | 0 | 1,619 | 1 |
| Чихэр, жимсний чанамал | | | | | |
| Элсэн чихэр-кг | 3,992 | 0.020 | 78 | 884 | 17 |
| Ёотон-кг | 3,996 | 0.000 | 1 | 1,292 | 0 |
| Сахар орлуулагч-гм | 4 | 0.001 | 0 | 14 | 0 |
| Хатуу чихэр-кг | 3,697 | 0.004 | 14 | 2,505 | 10 |
| Зөөлөн чихэр-кг | 5,200 | 0.001 | 6 | 3,074 | 4 |
| Шоколад-гм | 5 | 0.408 | 2 | 6 | 3 |
| Зөгийн бал-гм | 3 | 0.029 | 0 | 5 | 0 |
| Компот-гм | 1 | 0.260 | 0 | 3 | 1 |
| Жимсний чанамал-гм | 3 | 0.379 | 1 | 3 | 1 |
| Мөхөөлдөс-гм | 2 | 1.259 | 2 | 1 | 2 |
| Бохь-ширхэг | 4 | 0.011 | 0 | 43 | 0 |
| Сироп-кг | 2,644 | 0.000 | 0 | 2,024 | 0 |
| Хүнсний бусад бүтээгдэхүүн | | | | | |
| Давс-гм | 0 | 9.488 | 0 | 0 | 3 |
| Цуу-гм | 1 | 0.144 | 0 | 2 | 0 |
| Кетчуп-гм | 1 | 0.950 | 1 | 1 | 1 |
| Майонез-гм | 6,258 | 0.000 | 2 | 3,591 | 1 |
| Исгэгч-гм | 2 | 0.168 | 0 | 7 | 1 |
| Халуун ногоо-гм | 1 | 0.563 | 0 | 5 | 3 |
| Хүүхдийн хоол-кг | 2,940 | 0.000 | 0 | 3,408 | 0 |
| Цай, кофе | | | | | |
| Ногоон цай-гм | 1 | 7.069 | 8 | 2 | 12 |
| Цай-гм | 1 | 0.276 | 0 | 9 | 3 |
| Кофе-гм | 1 | 0.090 | 0 | 5 | 0 |
| Какао-гм | 3 | 0.002 | 0 | 5 | 0 |
| Цэвэр ус, ундаа, жимсний шүүс | | | | | |
| Ундаа-литр | 342 | 0.008 | 3 | 483 | 4 |
| Жимсний шүүс-литр | 488 | 0.003 | 1 | 1,153 | 4 |
| Савласан цэвэр ус-литр | 0 | 0.001 | 0 | 335 | 0 |
| Согтууруулах ундаа | | | | | |
| Дотоодын архи-литр | 2,750 | 0.002 | 6 | 6,203 | 13 |
| Дотоодын пиво-литр | 240 | 0.000 | 0 | 1,989 | 1 |
| Импортын архи-литр | 2,750 | 0.000 | 0 | 6,914 | 1 |
| Импортын пиво-литр | 240 | 0.000 | 0 | 1,599 | 0 |
| Дарс-литр | 700 | 0.000 | 0 | 4,636 | 1 |

*Эх сурвалж: ӨНЭЗС 2007-08*

# ХАВСРАЛТ В. Доод, дээд ядуурлын тооцоонууд

**Хүснэгт В.1. Нэг хүнд сард ногдох ядуурлын шугам 2002-03, 2002-08 он**

| | 2002/03 | | 2007/08 | |
|---|---|---|---|---|
| | Төгрөг | % | Төгрөг | % |
| Доод | | | | |
| Хүнсний | 14,386 | 70 | 35,239 | 70 |
| Хүнсний бус | 6,022 | 30 | 15,369 | 30 |
| Нийт | 20,408 | 100 | 50,607 | 100 |
| Дундаж | | | | |
| Хүнсний | 14,386 | 58 | 35,239 | 56 |
| Хүнсний бус | 10,357 | 42 | 27,256 | 44 |
| Нийт | 24,743 | 100 | 62,494 | 100 |
| Дээд | | | | |
| Хүнсний | 14,386 | 44 | 35,239 | 42 |
| Хүнсний бус | 17,984 | 56 | 48,574 | 58 |
| Нийт | 32,370 | 100 | 83,813 | 100 |

*Санамж, Ядуурлын шугамуудыг тухайн үеийн үнээр тооцов.*

*Эх сурвалж: ӨОЗС, АТТС 2002-2003, ӨНЭЗС 2007-2008*

**Хүснэгт В.2 Доод ядуурлын тооцоонууд, 2002/03, 2007/08 он**

| | 2002/03 | | | | | 2007/08 | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Ядуурлын | | | Хүн ам | Ядуу | Ядуурлын | | | Хүн ам | Ядуу |
| | Хамралтын хүрээ | Гүнзгийрэлт | Мэдрэмж | (%) | (%) | Хамралтын хүрээ | үнзгийрэлт | Мэдрэмж | (%) | (%) |
| Улсын дундаж | 25.0 | 6.8 | 2.7 | 100.0 | 100.0 | 23.0 | 5.6 | 2.0 | 100.0 | 100.0 |
| Хот | 20.4 | 5.7 | 2.3 | 55.4 | 45.3 | 17.2 | 4.3 | 1.6 | 57.6 | 43.0 |
| Хөдөө | 30.6 | 8.1 | 3.1 | 44.6 | 54.7 | 30.8 | 7.4 | 2.5 | 42.4 | 57.0 |
| Улаанбаатар | 18.1 | 4.9 | 1.8 | 30.2 | 21.9 | 14.0 | 3.6 | 1.4 | 35.6 | 21.7 |
| Аймгийн төв | 23.1 | 6.7 | 2.9 | 25.2 | 23.4 | 22.2 | 5.5 | 1.9 | 22.0 | 21.3 |
| Сумын төв | 32.2 | 9.3 | 3.9 | 16.2 | 20.9 | 28.8 | 7.3 | 2.6 | 17.4 | 21.8 |
| Хөдөө нутаг | 29.7 | 7.4 | 2.7 | 28.4 | 33.8 | 32.3 | 7.4 | 2.4 | 25.1 | 35.2 |
| Баруун | 34.8 | 8.4 | 3.0 | 17.0 | 23.7 | 31.0 | 6.5 | 2.0 | 16.6 | 22.4 |
| Хангай | 29.9 | 7.6 | 2.9 | 24.1 | 28.9 | 31.4 | 7.6 | 2.6 | 23.1 | 31.6 |
| Төв а/ | 22.1 | 6.2 | 2.5 | 19.5 | 17.3 | 18.3 | 4.6 | 1.6 | 16.8 | 13.4 |
| Зүүн | 22.2 | 8.9 | 4.7 | 9.3 | 8.2 | 31.7 | 9.1 | 3.7 | 7.9 | 10.9 |

*а/ Улаанбаатар хотыг оруулаагүй.*

*Эх сурвалж: ӨОЗС, АТТС 2002-2003, ӨНЭЗС 2007-2008*

**Хүснэгт B.3. Дээд ядуурлын тооцоонууд, 2002/03, 2007/08 он**

| | 2002/03 | | | | | 2007/08 | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Ядуурлын | | | Хүн ам | Ядуу | Ядуурлын | | | Хүн ам | Ядуу |
| | Хамралтын хүрээ | Гүнзгийрэлт | Мэдрэмж | (%) | (%) | Хамралтын хүрээ | Гүнзгийрэлт | Мэдрэмж | (%) | (%) |
| Улсын дундаж | 53.6 | 19.0 | 9.0 | 100.0 | 100.0 | 53.5 | 18.9 | 8.8 | 100.0 | 100.0 |
| Хот | 46.5 | 16.1 | 7.6 | 55.4 | 48.2 | 43.9 | 14.8 | 6.7 | 57.6 | 47.3 |
| Хөдөө | 62.3 | 22.5 | 10.8 | 44.6 | 51.8 | 66.4 | 24.5 | 11.5 | 42.4 | 52.7 |
| Улаанбаатар | 42.4 | 14.5 | 6.7 | 30.2 | 23.9 | 37.6 | 12.3 | 5.6 | 35.6 | 25.0 |
| Аймгийн төв | 51.5 | 18.1 | 8.8 | 25.2 | 24.3 | 54.2 | 18.7 | 8.6 | 22.0 | 22.3 |
| Сумын төв | 61.2 | 23.1 | 11.6 | 16.2 | 18.5 | 60.3 | 22.6 | 10.8 | 17.4 | 19.6 |
| Хөдөө нутаг | 62.9 | 22.2 | 10.2 | 28.4 | 33.4 | 70.6 | 25.9 | 11.9 | 25.1 | 33.1 |
| Баруун | 71.1 | 25.5 | 11.8 | 17.0 | 22.5 | 68.5 | 24.3 | 11.0 | 16.6 | 21.2 |
| Хангай | 56.7 | 20.8 | 10.0 | 24.1 | 25.5 | 67.1 | 24.8 | 11.6 | 23.1 | 29.0 |
| Төв a/ | 52.3 | 17.8 | 8.4 | 19.5 | 19.1 | 48.2 | 16.3 | 7.4 | 16.8 | 15.2 |
| East | 52.3 | 19.5 | 10.5 | 9.3 | 9.0 | 64.7 | 25.5 | 12.8 | 7.9 | 9.6 |

*a/ Улаанбаатар хотыг оруулаагүй.*

*Эх сурвалж: ӨОЗС, АТТС 2002-2003, ӨНЭЗС 2007-2008*

(f) (e)

(f)

(e)